



МОНГОЛБАНК



ЖИЛИЙН ТАЙЛАН 2007

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮГ

Эрхэмсэг ноёд хатагтай нараа,

Монголбанкнаас 2007 онд авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ, үйл ажиллагааны үр дүнг тусгасан жилийн тайланг та бүхэнд толилуулж байна.

Төрөөс 2007 онд мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд инфляцийг жилийн 5 хувиас хэтрүүлэхгүй гэсэн зорилт тавигдсан хэдий ч гадаад, дотоодын хүчин зүйлсээс шалтгаалан инфляци жилийн 15.1 хувьтай байв. Энэ нь нефть болон улаан буудай, гурил, цагаан будаа зэрэг хүнсний гол бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ өссөн, дотоодод нийгмийн халамжийн зардал, төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн, улирлын шинж чанартай зарим бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хомсдол үүссэн зэргээс голчлон шалтгаалсан юм.

Тайлант оны хоёрдугаар хагасаас эхлэн Монголбанк үнийн өсөлтийн хандлагатай уялдуулан инфляцийн эсрэг чиглэсэн бодлого хэрэгжүүлж эхэлсэн билээ. Мөнгөний бодлого хэрэгжүүлэх хэлбэрийг боловсронгуй болгож 2007 оны 7 дугаар сараас мөнгөний бодлогын хүүг дотоодын зах зээл дээр анх удаа нэвтрүүлэв. Инфляциас сэргийлж мөнгөний бодлогын хүүг 10, 11 дүгээр саруудад тус бүр 1 нэгжээр нэмэгдүүлж 8.4 хувьд хүргэв. Мөнгө, зээлийн агрегатуудын өсөлтийн хурдыг сааруулах зорилгоор заавал байлгах нөөцийн хувийг 2008 оны 12 дугаар сард 0.5 нэгжээр өсгөж 5.5 хувьд хүргэн 2008 оны эхнээс мөрдүүллээ.

Нийт активын хэмжээ өмнөх оныхоос 51.2 хувь, харилцах 75.7 хувь, хадгаламж 46.0 хувиар, өөрийн хөрөнгө 27.6 хувиар тус тус өссөн нь банкны салбар улам өргөжиж, санхүүгийн зуучлал гүнзгийрснийг илэрхийлж байна. Нийт зээлийн хэмжээ өмнөх оныхоос 68.1 хувиар өсч, түүний чанарын үзүүлэлт болох нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувийн жин 1.5 нэгжээр буурсан байна. Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2007 онд 4.6 нэгжээр буурч 19.9 хувьд хүрчээ. Мөн банк хоорондын хоёрдогч захын үйл ажиллагаа идэвхжсэн, ипотекийн хоёрдогч зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн зэрэг ахицтай олон үр дүн банкны салбарт гарлаа.

Дэлхийн зах зээл дээр алт, зэсийн үнэ өндөр хэвээр байсан нь манай улсын эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт жилийн 9.9 хувьд хүрэв. Монгол улсын нэгдсэн төсөв 102.0 тэрбум төгрөгийн ашигтай гарсан нь ДНБ-ий 2.2 хувийг эзэлж байна. Гадаад валютын цэвэр нөөц өмнөх оныхоос 41.9 хувиар нэмэгдэж 975.3 сая америк доллар болсон нь манай улсын импортын 24 долоо хоногийн хэрэгцээг хангахаар байна.


Тайлант онд Дэлхийн банк, ОУВС хамтран Монгол улсын санхүүгийн салбарын байдлыг дэлхийн бусад орнуудтай харьцуулан шинжлээд тогтвортой эрсдэл багатай гэсэн үнэлэлт өглөө. Түүнчлэн мөнгөний бодлого хэрэгжүүлэх байдал нь харьцангуй нээлттэй, эрүүл орчинд явагдаж буй бөгөөд томоохон дэвшил гарсан байна гэж дүгнэжээ. Энэ нь манай хамт олны ажлыг олон улсын хэмжээнд харьцуулан авч үзсэн үнэлгээ юм.

Цаашид банкуудын хөрөнгөжих болон эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, олон улсын санхүүгийн зах зээлд гарах, стратегийн хөрөнгө оруулагчдыг татан оруулах таатай нөхцөлүүдийг бүрдүүлэхийн зэрэгцээ банкны салбарын тогтвортой байдлыг хангах, хууль эрх зүйн орчинг сайжруулах, банкны хяналт шалгалтыг илүү үр ашигтай эрхлэх, төлбөр тооцооны шинэ технологи нэвтрүүлэх зэрэг олон зорилтыг авч хэрэгжүүлэхээр анхаарч байна. Бидний өмнө ойрын хугацаанд тулгарч буй хамгийн гол асуудал болсон үнийн өсөлтийг саармагжуулах улмаар бууруулахад мөнгөний бодлогыг чиглүүлэн ажиллах болно.



А. Батсүх
Монголбанкны ерөнхийлөгч

МОНГОЛБАНКНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ







1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ	9
1.1 Мөнгөний бодлогын зорилт, түүний хэрэгжилт	9
1.2 Мөнгөний үзүүлэлтүүд	31
1.3 Валютын нөөцийн удирдлага	38
1.4 Төгрөгийн ханшийн хөдөлгөөн	40
2. БАНКНЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ	43
2.1 Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд	43
2.2 Банкны салбарын хөрөнгө болон эх үүсвэрийн бүтэц	48
2.3 Банкны салбарын зохистой харьцааны үзүүлэлтүүд	48
2.4 Банкны хяналт шалгалт	53
3. ТӨВ БАНКНЫ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА	59
4. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ	73
4.1 Монгол улсын эдийн засгийн тойм	73
4.2 Үнэ	83
4.3 Хөдөлмөрийн зах зээл, бүтээмж	88
4.4 Засгийн газрын санхүү	92
4.5 Хөрөнгийн зах зээлийн хөгжил	94
4.6 Төлбөрийн тэнцэл	97
5. МОНГОЛБАНКНААС 2007 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БА ТЕХНИКИЙН ШИНЖТЭЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ	115
8. АУДИТОРЫН ТАЙЛАН	117
9. СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД	173

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

1

1.1 Мөнгөний бодлогын зорилт, түүний хэрэгжилт

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2007 онд баримтлах үндсэн чиглэлд хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийг жилийн 5 хувиас хэтрүүлэхгүй гэж мөнгөний бодлогын үндсэн зорилтыг тодорхойлсон хэдий ч гадаад, дотоод хүчин зүйлсээс шалтгаалан инфляцийн түвшин 2007 онд 15.1 хувьд хүрсэн нь сүүлийн 10 жилийн хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд зорилтод түвшнээс 10.1 нэгжээр өндөр байв.

Инфляцийн жилийн түвшин 2007 оны 6, 7 дугаар сарын байдлаар харгалзан 6.3, 7.1 хувьтай байсан бол 8 дугаар сард огцом өсч 11.3 хувьд хүрч улмаар оны эцэст 15.1 хувь болж өссөн байна. Инфляцийн энэхүү өсөлтөд дотоод эдийн засгийн өндөр эрэлтийн болон гадаад эдийн засгийн нийлүүлэлт шууд нөлөөлөв. Улаан буудай, нефть, ургамлын тос, гурил, цагаан будаа зэрэг бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн өсөлт, гадаад худалдааны гол түнш орнуудын инфляцийн өсөлт зэрэг нь өргөн хэрэглээний бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнэ өсөхөд нөлөөлсөн гадаад хүчин зүйл болов. Гадаад хүчин зүйлсийн нөлөөлөл нь дотоодын зах зээл дээр өргөн хэрэглээний импортын барааны үнэ өсөхөд шууд нөлөөлсөн нь манай инфляцид гадаад үнийн өсөлт хүчтэй нөлөөлдгийн үр дагавар юм.

Мөн төрийн албан хаагчдын цалин, нийгмийн халамжийн зардал, дотоод дахь төмөр замын тээврийн саатал, Засгийн газрын хөрөнгө оруулалтын өсөлт, сүүлийн жилүүдийн мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, эдийн засаг дахь зээл олголтын өндөр өсөлт зэрэг нь үнэ өсөхөд нөлөөлсөн дотоод эдийн засгийн эрэлтийн хүчин зүйл болж байв. 2006 оны 10 дугаар сараас 2007 оны 7 дугаар сар хүртэлх хугацаанд маш тогтвортой байсан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 8 дугаар сард 1.4 хувиар суларсан байна. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларсан 8 дугаар сард инфляцийн түвшин 3.3 нэгжээр огцом өссөн нь өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, үйлчилгээний сагсны 30 гаруй хувь нь импортоор хангагддаг манай улсын хувьд валютын ханш инфляцийн өөрчлөлтөнд нөлөөтэй болохыг харуулж байна.

Монголбанк 2007 онд ТБҮЦ-ны арилжаа, заавал байлгах нөөц, бодлогын хүү зэрэг хэрэгслүүдийг ашиглан мөнгөний бодлогоо хэрэгжүүлэв. “Заавал байлгах нөөц тогтоож, хяналт тавих журам”-ыг шинэчлэн өөрчилж 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс мөрдөж эхэллээ. Энэхүү журмын өөрчлөлтөөр заавал байлгах нөөцийн хувийг 14-өөс 5 хувь болгож (бодитоор 2 орчим нэгжээр) бууруулсан. Энэ нь арилжааны банкуудын зээлийн эх үүсвэрийн өртгийг бууруулж, зээлийн хүүд шингэж буй татан төвлөрүүлсэн хөрөнгийн алдагдсан боломжийн зардлыг бууруулах зорилготой байв. Түүний зэрэгцээ “ТБҮЦ-ны арилжааны журам”-ыг шинэчлэн 2007 оны 7 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэллээ. Журмын энэхүү өөрчлөлтөөр 7 хоногийн хугацаатай ТБҮЦ-ны хүүг мөнгөний бодлогын хүү болгож зарладаг болов. Банкуудын эрэлтийг 7 хоногийн хугацаатай ТБҮЦ-ны нийлүүлэлтээр бүрэн хангах, 7-гоос дээш хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг хүүний хязгаар

тогтоолгүй, хэмжээг хязгаарлан, банкуудын ирүүлсэн хүүний саналаар өрсөлдүүлэх зарчмаар явуулах болсноор зах зээл дээр үнэн бодит хүүний мэдээллийг зарлах, банк хоорондын захын илүүдэл нөөцийг бууруулах зэрэг боломжийг бүрдүүлсэн байна.

Монголбанк анх удаа мөнгөний бодлогын хүү зарлаж, түүгээрээ дамжуулан банк хоорондын захын хүүд нөлөөлөх, улмаар эдийн засаг дахь зээл, хадгаламжийн хүүд нөлөөлөх бодлогын үндэс суурийг бүрдүүлж эхэлсэн нь мөнгөний бодлогын шинэ арга хэлбэрт дунд хугацаанд шилжих бэлтгэл ажлыг эхлүүлсэн онцлог жил байлаа. Монголбанк сүүлийн жилүүдэд хэрэгжүүлж ирсэн мөнгөний “зөөлөн” бодлогоо 2007 оны сүүлийн хагасаас “хатууруулах” чиглэлд өөрчилсөн нь 2007 оны бас нэгэн онцлог байв. Энэ хүрээнд Монголбанк 2007 оны 7 дугаар сараас эхлэн дараахь бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

1. 2007 оны 7 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн Төв банкны үнэт цаас / ТБҮЦ/ -ны арилжааны шинэчилсэн журмаар 7 хоногийн хугацаатай ТБҮЦ-ны хүүг мөнгөний бодлогын хүү болгож зарлав. Монголбанк мөнгөний бодлогын хүүгээ анх удаа 6.4 хувиар тогтоосон бөгөөд энэ нь 7 хоногийн хугацаатай ТБҮЦ-ны өмнөх арилжаануудын жигнэсэн дундаж хүүнээс өндөр байв. Монголбанк тухайн үеийн болон ирээдүйн инфляцийн хүлээлттэй уялдуулан мөнгөний хатуу бодлогоо үргэлжлүүлэх зорилгоор 10 дугаар сард 1 нэгжээр нэмэгдүүлж 7.4 хувь, 11 дүгээр сард дахин 1 нэгжээр нэмэгдүүлж 8.4 хувь болгосон;
2. Монголбанк мөнгөний бодлогын хүүгээ нэмэгдүүлснээр ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү болон банк хоорондын захын хүү 2007 оны 7 сараас тасралтгүй өссөөр оны эцэст харгалзан 9.85 хувь, 8.25 хувьд тус тус хүрчээ. Энэ өсөлтийг 2007 оны 6 дугаар сартай харьцуулахад ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү 6.19 нэгжээр, банк хоорондын захын хүү 2.99 нэгжээр өссөн байна;
3. Банк хоорондын захын илүүдэл нөөц 2007 оны эхнээс өссөөр 6 дугаар сард 81.1 тэрбум төгрөгт хүрэв. Монголбанк мөнгөний бодлогыг “хатууруулах” зорилготой уялдуулан 2007 оны 7 дугаар сараас ТБҮЦ-ны хүү болон борлуулах хэмжээг нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд банк хоорондын захын илүүдэл нөөцийн өдрийн дундаж хэмжээ 7 дугаар сард 25.7 тэрбум улмаар тасралтгүй буурсаар 10 дугаар сард хамгийн бага түвшинд буюу 10.1 тэрбум төгрөгт хүрсэн. Харин оны эцэст бага зэрэг өсч 15.7 тэрбум төгрөг болов.
4. Зээлийн хүүг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор заавал байлгах нөөцийн хувийг 2007 оны 3 дугаар сард 5 хувь болгон бууруулсан хэдий ч 2007 оны дунд үеэс ажиглагдсан үнийн өсөлт цаашид үргэлжлэх хандлагатай байсан тул мөнгөний бодлогыг хатууруулах зорилгоор заавал байлгах нөөцийн хувийг 5.5 хувь болгож өсгөх шийдвэрийг 2007 оны 12 дугаар сард гаргасан болно. Энэхүү шийдвэр нь 2008 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд тухайн үеийн тооцоогоор заавал байлгах нөөцийн хэмжээ 1 дүгээр сард 8.0 орчим тэрбум төгрөгөөр өсөхөөр хүлээгдэж байсан юм.



Зураг 1.1.

Инфляци



Зураг 1.2.

Банк хоорондын
захын илүүдэл нөөц
ба хүүнүүд

Шигтгээ 1. Мөнгөний бодлогын зорилт

Эдийн засгийн үйл ажиллагаа зөв явагдахад мөнгөний үүрэг маш чухал. Төв банк мөнгөний бодлогоор дамжуулан инфляцийг тогтвортой бага түвшинд барьж төгрөгийн худалдан авах чадварыг хамгаалдаг. Инфляцийг тогтвортой бага түвшинд байлгах (үнийн тогтвортой байдлын тухай үзэл баримтлалыг ингэж ойлгодог) зорилго нь энгийн нэгэн хуулийн заалт төдий бус улс орны эдийн засгийг бүрэн ажил эрхлэлтээр хангах, Монголчуудын чинээлэг аж амьдрал, хөгжил дэвшил бүхий тогтвортой хөгжлийн замд хүрэх өргөн цар хүрээтэй зорилгод чиглэгддэг.

Төв банкны зүгээс улс орны хөгжил дэвшилд оруулж буй хамгийн том тус нэмэр нь хүмүүсийн ирээдүйдээ итгэх итгэлийг тогтвортой үнээр төсөөлүүлэн бий болгодогт оршино. Энэхүү тогтвортой байдал нь хадгаламж, хөрөнгө оруулалт, бүтээмжээс олох ашгийг урамшуулдаг бөгөөд тэдгээр нь эдийн засгийн өсөлттэй салшгүй холбоотой билээ. Үүгээр ч зогсохгүй, тогтвортой бага инфляци нь орлогын хуваарилалт талаасаа ажил эрхлэлтийн түвшинг өсгөх, нийгмийн эмзэг бүлгийнхний бодит орлогыг хамгаалдаг тустай зүйл юм.

Мөнгөний бодлого үнийн тогтвортой байдлыг хангах замаар урт хугацааны эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөг. Эдийн засаг болон ажил эрхлэлтэд үзүүлэх богино болон дунд хугацааны нөлөөлөл нь мөнгөний бодлогын шилжих механизмын сувгуудаас хамаарах бөгөөд тэдгээрээр дамжиж буй мөнгөний бодлогын өөрчлөлт нь эцсийн дүндээ инфляцид нөлөөлөхөд чиглэгддэг. Иймээс мөнгөний бодлого нь үнийн тогтвортой байдлын сацуу эдийн засгийн мөчлөгийн сөрөг нөлөөг зөөлрүүлэх буюу санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдал, эдийн засгийн уналт, ажилгүйдлийг дагуулах дотоодын эрэлтийн цочмог савалгаанаас зайлсхийх зарчим баримталдаг.

Монголбанкны мөнгөний бодлогын үндсэн чиглэл нь эдийн засаг, ажил эрхлэлтэд үзүүлж болох богино болон дунд хугацаанд нөлөөллийг харгалзан үзэх замаар урт хугацааны үнийн тогтвортой байдлыг хангахад оршино.

Зарим судлаачдын¹ дүгнэснээр эдийн засгийн түргэн өсөлтөд харгалзах инфляцийн хувь хөгжингүй орнуудын хувьд 1-3, харин хөгжиж буй орнуудын хувьд 7-11 хувь байдаг. Зураг 1-т инфляци болон эдийн засгийн өсөлтийн хоорондох хамаарлыг үзүүлэв.

Төв банк урт хугацааны зорилгыг хангахын тулд ойрын хугацааны зорилтуудыг томъёолдог. Завсрын зорилтууд болох мөнгөний агрегатууд (тухайлбал M2) болон урт хугацаатай санхүүгийн хэлцлийн хүү нь Төв банкны шууд бус хяналтанд байна. Харин нөөц мөнгө болон богино хугацааны хүү нь Төв банкны бодлогын шийдвэрийг богино хугацаанд мэдрэн өөрчлөгддөг. Иймээс Төв банкны мөнгөний бодлогын хэрэгсэл нь үйл ажиллагааны зорилтуудаар дамжин завсрын зорилтуудад, улмаар эцсийн зорилгын хувьсагчид нөлөөлдөг. Үүнийг дараахь байдлаар харуулж болно:


¹ Khan & Senhadji (2000)

Нөөц мөнгөний өөрчлөлт \Rightarrow мөнгөний нийлүүлэлт (M2) \Rightarrow инфляци

Богино хугацааны хүүний өөрчлөлт \Rightarrow бусад хүүний түвшин \Rightarrow инфляци

Мөнгөний бодлогын шууд хэрэгслүүд нь хүү болон зээлийн хэмжээнд нөлөөлдөг бөгөөд мөнгө, санхүүгийн зах зээлийн хөгжлийн үр ашиггүй байдлыг бий болгодог. Захиргаадалтын аргаар хүү болон банкнаас олгох зээлийн хэмжээнд дээд хязгаар тогтоох, заавал байлгах нөөцийн хувь, хэмжээг өөрчлөх зэрэг нь шууд хэрэгслүүдийн жишээ юм. Харин “зах зээлд суурилсан” буюу шууд бус хэрэгслүүдэд нээлттэй захын үйл ажиллагаа (ТБҮЦ-ны арилжаа, репо арилжаа гэх мэт) болон Төв банкны зээлийн бодлого (овернайт зээл, хямдруулалтын зээл) орох бөгөөд тэдгээр нь банкны нөөцийн зах зээлээр тодорхойлогдсон үнэ (хүү)-д нөлөөлдөг.

Зураг 1. Инфляци болон эдийн засгийн өсөлт



Нөөц мөнгө

Нөөц мөнгө болон түүний бүрэлдэхүүн хэсэг болох банкнаас гадуурхи мөнгө сүүлийн жилүүдтэй харьцуулахад 2007 онд нэлээд өндөр хувиар өссөн бол банкуудын нөөцийн хэмжээ бага хувиар өссөн байна.

Нөөц мөнгөний хэмжээ 2007 онд жилийн 40.1 хувиар өсч, 381.8 тэрбумаас 535.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэхүү өсөлтийн дийлэнх буюу 64.1 хувийг банкнаас гадуурхи мөнгө, 22.4 хувийг банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламж, 13.5 хувийг банкуудын кассын өсөлт тус тус эзлэв. Өмнөх онтой харьцуулахад нөөц мөнгөний өсөлтөд банкуудын харилцах, хадгаламж болон банкуудын кассын эзлэх хувь харгалзан 24.5, 7.0 нэгжээр тус тус буурсан бол банкнаас гадуурхи мөнгө 31.5 нэгжээр өссөн байна. Нөөц мөнгөний өсөлтийн дийлэнх хувийг 2006 онд банкуудын нөөцийн өсөлт эзэлж байсан бол 2007 онд банкнаас гадуурхи мөнгө болж өөрчлөгдсөн байна. Энэ нь Монголбанк мөнгөний бодлогын гол хэрэгсэл болох “ТБҮЦ-

ны арилжааны журам”-д өөрчлөлт оруулж, банкуудын нөөцийг удирдах болсонтой холбоотой юм.

Сүүлийн жилүүдэд нөөц мөнгөний бүтцэд банкнаас гадуурхи мөнгөний эзлэх хувь буурч, банкуудын нөөцийн эзлэх хувь өсөх хандлагатай байсан. Харин тайлант онд Монголбанк 7 хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг банкуудын эрэлтийн хэмжээгээр, тогтмол хүүгээр, 12 болон 28 долоо хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг хүүний дээд хязгаар тогтоолгүй, хэмжээг нь хязгаарлах зарчмаар арилжаалдаг болсноор банк хоорондын захын илүүдэл нөөц буурч, нөөц мөнгөнд банкуудын харилцах, хадгаламжийн эзлэх хувь 35.8 хувиас 32.0 хувь хүртэл буурсан байна.

Монголбанк заавал байлгах нөөцийн журмаа шинэчилж, заавал байлгах нөөцийн хангалтанд банкуудын кассыг тооцдоггүй болсноор банкуудын кассдаа мөнгө байршуулах сонирхол багассан юм. Ингэснээр банкуудын кассын нөөц мөнгөнд эзлэх хувь 15.7 хувиас 15.1 хувь болж буурахад нөлөөлсөн байна.

Дээрх өөрчлөлтүүдийн улмаас банкнаас гадуурхи мөнгөний нөөц мөнгөнд эзлэх хувь 48.5 хувиас 53.0 хувь болж өссөн байна. Энэ нь эдийн засгийн өндөр идэвхжилт, бэлэн бус төлбөр тооцооны хөгжилтэй холбоотойгоор эдийн засаг дахь бэлэн мөнгөний эрэлт өндөр хэвээр байгааг харуулж байна.


Тайлант онд нөөц мөнгөний хөдөлгөөнийг дараахь 4 үед хувааж болохоор байна. Үүнд:

2006 оны сүүл үеэс 2007 оны 2 дугаар сар. Тайлант оны 1, 2 дугаар саруудад банкнаас гадуурхи мөнгөний хэмжээ буурсан хэдий ч банкуудын нөөц өссөн тул нөөц мөнгөний хэмжээ нэмэгдэв.

2007 оны 3-5 дугаар саруудад. 2007 оны 3 дугаар сараас банкнаас гадуурхи мөнгөний хэмжээ өсч 167.6 тэрбумаас 267.4 тэрбум төгрөг болсон нь нөөц мөнгийг 401.3 тэрбумаас 521.6 тэрбум төгрөг болж өсөхөд голлох нөлөө үзүүлэв.


2007 оны 6-11 дүгээр саруудад. Банкнаас гадуурхи бэлэн мөнгөний хэмжээ 6-11 дүгээр саруудад харьцангуй тогтвортой байсан хэдий ч нөөц мөнгөний хэмжээ 415.1 тэрбум төгрөг болж багассан нь банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламж 198.8 тэрбумаас 91.4 тэрбум төгрөг болж буурснаас шалтгаалжээ. Энэ нь Монголбанкны зүгээс 2007 оны 7 дугаар сараас эхлэн мөнгөний бодлогыг хатууруулах чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд ТБҮЦ-ны борлуулсан хэмжээ 119.5 тэрбумаас 168.1 тэрбум төгрөг болж 48.6 тэрбум төгрөгөөр өссөн, ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүүг 3.68-аас 9.19 хувь болж нэмэгдсэнтэй холбоотой байна.

2007 оны 12 дугаар сар. 2007 оны 12 дугаар сард нөөц мөнгөний хэмжээ өмнөх сараас 120.0 тэрбум төгрөг буюу 28.9 хувиар өссөн. Энэ нь шинэ жилийн баяртай холбоотойгоор банкнаас гадуурхи мөнгөний хэмжээ 21.6 тэрбум төгрөгөөр, банкуудын касс 18.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой. Гэхдээ нөөц мөнгөний энэхүү өсөлтөд хамгийн хүчтэй нөлөөлсөн



Зураг 1.3.

Нөөц мөнгөний
бүрэлдэхүүн
хэсгүүд ба
тэдгээрийн нөөц
мөнгөнд эзлэх
хувь



хүчин зүйл нь банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн өсөлт юм. Банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламж 12 дугаар сард 79.6 тэрбум төгрөгөөр өссөн нь нөөц мөнгөний өсөлтийн 66.3 хувийг эзэлж байна. Банкуудын нөөц, гүйлгээнд байгаа мөнгөний энэхүү өсөлт нь ТБҮЦ өмнөх сараас 168.5 тэрбумаас 102.7 тэрбум төгрөг болж буурсан, Төв банк дахь Засгийн газрын харилцах, хадгаламж 724.0 тэрбум төгрөгөөс 606.6 тэрбум төгрөг болж, Засгийн газрын зардал 117.4 тэрбум төгрөгөөр өссөнтэй холбоотой.

Нөөц мөнгө болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд улирлын хэлбэлзэл өндөр ажиглагддаг. Банкуудын нөөцийн улирлын хэлбэлзлийн далайц 2006 оноос буурч эхэлсэн хандлага тайлант онд ч үргэлжлэв. Хэдийгээр банкуудын нөөцийн улирлын хэлбэлзлийн далайц буурсан ч нөөц мөнгөний улирлын хэлбэлзлийн далайц бага зэрэг өссөн нь банкнаас гадуурхи мөнгөнөөс шалтгаалсан байна. Банкнаас гадуурхи мөнгөний улирлын хэлбэлзлийн хандлага 2002 он хүртэл буурсан боловч 2003 оноос эргээд өсч эхэлсэн юм. Энэхүү хандлага тайлант онд үргэлжиллээ.

Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)


Мөнгөний бодлогын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор тайлант онд Монголбанк ТБҮЦ-ны арилжааны хэлбэрээ өөрчлөн, арилжааны шинэ журмыг боловсруулж 2007 оны 7 дугаар сараас эхлэн мөрдлөг болгон ажиллав. ТБҮЦ-ны арилжааг тогтмол хүүтэй болон хүүгээр өрсөлдөх гэсэн хоёр үндсэн төрлөөр явуулж байна. Ингэхдээ 7 хоногийн хугацаатай үнэт цаасыг тогтмол хүүтэй буюу арилжааны хүүг зарлаж хэмжээг хязгаарлахгүйгээр, харин 12, 28 долоо хоногийн хугацаатай үнэт цаасыг хүүгээр өрсөлдүүлэх зарчмаар тус тус арилжаалж байна.

Тайлант онд Монголбанк нийт 58 удаа ТБҮЦ-ны арилжааг явуулж 4124.6 тэрбум төгрөгийн үнэт цаас борлуулсан. Монголбанкнаас худалдсан үнэт цаасны хэмжээ оны эцэст 104.5 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь өмнөх улиралтай харьцуулахад 18.9 хувиар буурсан, өмнөх оны мөн үеэс 22.7 хувиар өссөн үзүүлэлт юм.

Монголбанк 2007 онд өдөрт дунджаар 121.2 тэрбум төгрөгийн ТБҮЦ-ыг банкуудад байршуулж байсан нь 2006 оны ТБҮЦ-ны өдрийн дундаж үлдэгдлээс 1.6 дахин өссөн байна.

ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 9.85 хувь байгаа нь өмнөх улирлынхаас 1.10 нэгжээр, 2006 оны эцсээс 3.43 нэгжээр тус тус өндөр байна. Тайлант онд ТБҮЦ-ны хүүний зардалд Монголбанк 7.9 тэрбум төгрөг банкуудад төлөв. Энэ нь өмнөх оныхоос 1.8 дахин өссөн үзүүлэлт юм.

Монголбанкнаас 2007 оны 4 дүгээр улиралд банкуудын нөөцийг бууруулан, нөөц мөнгөний өсөлтийг багасган улмаар мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хурдыг саармагжуулах зорилгоор 7 хоногийн хугацаатай үнэт цаасныхаа хүүг 6.4 хувиас 7.4 хувь, улмаар 8.4 хувь болгож өсгөв. Мөн тайлант онд банкуудын илүүдэл нөөцийг татах зорилгоор 12, 28 долоо хоногийн




Зураг 1.4.а

Нөөц мөнгө болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн улирлын хэлбэлзлийн хандлага



* Үзүүлэлтүүдийн динамикаас улирлын хэлбэлзлийг арилгасан утга



хугацаатай ТБҮЦ-ыг гаргаж арилжаалав. Тайлант оны эцсийн байдлаар 12 долоо хоногийн хугацаатай үнэт цаасны үлдэгдэл 50 тэрбум, 28 долоо хоногийн хугацаатай үнэт цаасны үлдэгдэл 6.3 тэрбум төгрөг, тэдгээрийн жигнэсэн дундаж хүү нь харгалзан 11.5, 12.62 хувьтай байв.

Төв банкны санхүүжилт

Тайлант онд Монголбанк арилжааны 6 банкинд санхүүжилт олгов. Монголбанк 2007 онд хямдруулалтын санхүүжилт олгохыг зогсоосон бөгөөд репо санхүүжилт болон овернайт зээл олгосон байна.

Монголбанкнаас 2007 онд 10 тэрбум төгрөгийн овернайт зээлийг 23 хувийн хүүтэй, 53.1 тэрбум төгрөгийн репо санхүүжилтийг 18 хувийн хүүтэй тус тус олгов. Одоогийн мөрдөж буй журмаар Төв банкнаас олгох овернайт зээлийн хүү нь ТБҮЦ-ны хамгийн өндөр хүү дээр 5 хүртэл нэгж хувийг нэмсэнтэй, репо санхүүжилтийн хүү нь ТБҮЦ-ны хамгийн өндөр хүүний хувьтай тус тус тэнцүү байв. Тайлант онд 7 хоногийн хугацаатай үнэт цааснаас бусад үнэт цаасны арилжаа нь хүүгээр өрсөлдөх хэлбэрээр явагддаг болсноос ТБҮЦ-ны хүү харьцангуй өндөр түвшинд тогтож байв.

Заавал байлгах нөөц (ЗБН)

Монголбанк заавал байлгах нөөцийн хувь хэмжээг тогтоон мөрдүүлж байгаа нь манай орны хувьд мөнгөний нийлүүлэлтийг хянах чухал хэрэгслийн нэг байсаар байна.

Инфляцийн нам түвшинд байсан 2007 оны эхний хагаст эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажилгүйдэл, банкуудаас олгож буй зээлийн хүүг бууруулах зорилгоор харьцангуй мөнгөний “зөөлөн” бодлого явуулж, ЗБН-ийн хувийг бууруулан 5 хувьд хүргэсэн. Гэвч голдуу гадны хүчин зүйлсийн нөлөөгөөр 7 дугаар сараас эхлэн инфляцийн түвшин өссөнөөр Монголбанк мөнгөний бодлогодоо өөрчлөлт оруулан ЗБН-ийн хувь хэмжээг 0.5 нэгжээр өсгөж 5.5 хувь болгон 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлж байна.


Шинэчилсэн “ЗБН тогтоох, хяналт тавих” журмын дагуу нийт 24 удаа заавал байлгах нөөцийн хэмжээг төгрөгөөр болон валютаар банк тус бүрээр тогтоож, түүний хангалтыг тооцож холбогдох арга хэмжээ авч ирэв. Нөөцөө хангаагүй банк 2007 онд цөөхөн байсан бөгөөд банкны салбарын хэмжээгээр нийт 10.3-49.9 тэрбум төгрөгөөр нөөцийн илүүдэлтэй байв. 2006 оны 12 дугаар сард ЗБН-ийн илүүдэл 26.1 тэрбум төгрөг байсан бол тайлант оны эцэст 14.9 тэрбум төгрөг болж буурчээ.

Засгийн газрын цэвэр зээл

Тайлант оны эцэст банкны салбарын нэгдсэн дүнгээр Засгийн газраас авах авлага 24.1 тэрбум төгрөг, төвлөрсөн болон орон нутгийн төсвийн эх үүсвэр 750.6 тэрбум төгрөг болж, Засгийн газрын цэвэр зээлийн хэмжээ сөрөг 726.5 тэрбум төгрөгт хүрэв. Энэ дүнг 2006 онтой харьцуулбал төвлөрсөн



* Үзүүлэлтүүдийн динамикаас улирлын хэлбэлзлийг арилгасан утга



* Үзүүлэлтүүдийн динамикаас улирлын хэлбэлзлийг арилгасан утга

Зураг 1.4.6

Нөөц мөнгө болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн улирлын хэлбэлзлийн хандлага

болон орон нутгийн төсөв 233.4 тэрбум төгрөгөөр өсч, Засгийн газраас авах банкны салбарын авлага 15.2 тэрбум төгрөгөөр буурч, нийт цэвэр зээлийн хэмжээ 248.6 тэрбум төгрөгөөр багассан байна.

ОХУ-д төлсөн их өрийн тооцоогоор гаргасан 23.7 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ) Монголбанкинд байршиж байсан бөгөөд 2007 оны 4 дүгээр улиралд бүрэн төлөгдөж дуусав.

Засгийн газраас авах банкуудын авлагын 93.7 хувийг Засгийн газрын богино хугацаатай үнэт цаас, 4.1 хувийг банкуудаас улсын төсөвт урьдчилж төлсөн ба хойшлогдсон татвар, 2.2 хувийг хуримтлуулж тооцсон хүүний авлага тус тус эзэллээ.

Банкууд 2007 оны эцсийн байдлаар нийт 22.6 тэрбум төгрөгийн ЗГҮЦ эзэмшиж байгаагаас ХААН банк 5.1 тэрбум төгрөг, ХХБанк 1.1 тэрбум төгрөг, Голомт банк 4.0 тэрбум төгрөг, Анод банк 6.5 тэрбум төгрөгийн богино хугацааны үнэт цаас тус тус эзэмшиж байна.


Банкны салбар дахь Засгийн газрын төсөв болон харилцах, хадгаламжийн үлдэгдэл тайлант оны эцэст 750.6 тэрбум төгрөгт хүрсний 80.8 хувь нь Монголбанкинд, 19.2 хувь нь банкуудад байршиж байна. Нийт төсвийн хөрөнгийн 84.7 хувь нь төрийн сангийн нэгдсэн данс болон Засгийн газрын харилцах дансны хөрөнгө, 6.9 хувь нь хугацаагүй болон хугацаатай хадгаламж, 7.4 хувь нь Засгийн газрын санхүүжилтийн хөрөнгө, 0.9 хувь нь орон нутгийн төсвийн хөрөнгө эзэлж байна.

Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх хөтөлбөр /ХААСХХ/



Азийн хөгжлийн банк (АХБ)-ны ХААСХ (1822-МОН) төсөл 2001 оноос хэрэгжиж эхэлсэн. Энэхүү төслийн зорилго нь тогтвортой хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлж, илүү үр ашигтай, зах зээлд чиглэсэн, бүтээмж, ашигт ажиллагааг сайжруулснаар орлогын түвшинг нэмэгдүүлэн ядуурлыг бууруулах явдал юм.

ХААСХ төслийн хүрээнд олгосон зээлийн 80 хувийг АХБ санхүүжүүлж, үлдсэн 20 хувийг оролцогч арилжааны банкууд санхүүжүүлэх замаар хөдөө аж ахуйн салбарт оруулах хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэгдэв. Монголбанк 2007 онд 3.5 тэрбум төгрөгийн зээлийг ХААН, Зоос, Анод банкуудад дамжуулан олгож, оны эцэст 2.2 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна.

ХААСХ төсөл нь Завхан, Увс, Ховд, Говь-Алтай, Дархан-Уул, Сэлэнгэ, Баянхонгор, Баян-Өлгий аймгуудад Анод, ХААН, Зоос, Монгол шуудан, Хадгаламж, ХАС зэрэг банкаар дамжин амжилттай хэрэгжин дуусч байгаа бөгөөд төслийн эргэлтийн сангийн эх үүсвэрийг Дэлхийн банкны Бичил санхүүгийн хөгжлийн хөтөлбөрт шилжүүлэх бэлтгэл ажлууд хийгдэж байна.



*7 хоногийн хугацаатай ТБҮЦ-ны хүүг 2007 оны 7 дугаар сараас эхлэн бодлогын хүү болгон ашиглаж эхлэсэн.



Зураг 1.5.

Төв банкны бодлогын хүү ба ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү

Зураг 1.6.

ТБҮЦ-ны үлдэгдэл ба хугацааны бүтэц

Зураг 1.7.

Заавал байлгах нөөц ба Илүүдэл нөөц

Шигтгээ 2. Инфляцийг таамаглах “SIMOM” загвар, түүний бүтэц

Мөнгөний бодлого нь мөнгөний бодлогын сувгуудаар дамжин тодорхой цаг хугацааны хоцрогдолтойгоор инфляцид нөлөөлж байдаг. Төв банк нь ирээдүйгээ харсан бодлого хэрэгжүүлэх шаардлагатай тулгардаг. Өөрөөр хэлбэл ирээдүйн инфляцид нөлөөлөхийн тулд Төв банк өнөөдөр мөнгөний бодлогын шийдвэрээ гаргах хэрэгтэй болдог бөгөөд энэхүү шийдвэр нь өнгөрсөн үеийн инфляцийн мэдээлэл дээр бус инфляцийн ирээдүйн таамаглал дээр үндэслэн гарч байх шаардлагатай болно гэсэн үг юм. Тиймээс инфляцийн таамаглал нь Төв банкны шийдвэр гаргалтанд хамгийн чухал үзүүлэлтүүдийн нэг байдаг бөгөөд мөн олон нийттэй харилцах нэг том хэрэгсэл болдог.

Төв банк ирээдүйн инфляцийг таамаглахын тулд маш олон тооны мэдээллийн эх үүсвэрийг ашигладаг. Ингэхдээ онол болон практик хослуулсан эдийн засгийн олон төрлийн загваруудыг ашиглан инфляцийн таамаглалыг хийдэг. Ялангуяа инфляцийг онилсон мөнгөний бодлого хэрэгжүүлдэг төв банкуудын хувьд инфляцид ихээхэн нөлөөлдөг хувь хүмүүсийн инфляцийн талаархи хүлээлтийн тухай мэдээллийг цуглуулж байдаг.

Монголбанк 2007 оноос мөнгөний бодлогын шийдвэр гаргалтанд ашиглагдах мэдээллийн баазыг бэхжүүлэх, мөнгөний бодлогын ирээдүйгээ харсан байдлыг хангахад анхаарлаа онцгойлон хандуулан ажиллаж байна. Монголбанкинд хийгдэж буй макро эдийн засгийн болоод эконометрик загварууд нь макро эдийн засгийн үйл хөдлөлийг таамаглах чадварыг улам сайжруулах чиглэлд хийгдэж байгаа бөгөөд түүний нэг жишээ нь Монголын инфляцийг таамаглах жижиг загвар (SIMOM) юм.

SIMOM загварын бодит эдийн засгийн үйл хөдлөлтэй нийцтэй байдал нь хамгийн чухал бөгөөд давуу талуудын нэг байдаг. SIMOM загвар нь нийтдээ 10 тэгшитгэлээс бүрдэх бөгөөд үүнд: төгрөгийн зээлийн хүү, гадаад валютын зээлийн хүү, IS муруйн тэгшитгэл, LM муруйн тэгшитгэл, валютын ханшийн тэгшитгэл, Филлипсийн муруйн тэгшитгэл, хүнсний барааны үнийн тэгшитгэл, шатахууны үнийн тэгшитгэл, ДНБ болон цалингийн тэгшитгэл зэрэг болно.

Тус загварын үндсэн зорилго бол Монгол дахь инфляцийн үйл явц, мөнгөний бодлогын шилжих механизмыг шинжлэх, манай орны макро эдийн засгийн гол үндсэн үзүүлэлтүүд нь эдийн засгийн тодорхой өөрчлөлтүүдэд хэрхэн хариу үзүүлэх вэ гэдгийг дунд хугацааны динамикийг мөнгөний бодлогын шилжих механизмын хугацааны нийцтэй байдлаар тодорхойлоход оршдог.

Энэхүү загварын итгэлцүүрүүд нь улирал бүр шинэчлэгдэн тогтмол үнэлэгдэж байдаг бөгөөд загварын таамаглалыг гадаад, дотоод экзоген хувьсагчдын өөрчлөлт, судлаачдын мэргэжлийн дүгнэлтэд суурилан улирал доторх сар бүр шинэчлэн гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн таамаглал, тухайлбал шатахуун, хүнсний бараа бүтээгдэхүүний инфляци нь судлаачдын бусад эх сурвалжаас авсан мэдээлэл, хүлээлтээс илт зөрүүтэй үр дүн гарах тохиолдолд зарим үзүүлэлтүүдийн таамаглалд нийцтэй (тайлбарлагдахуйц) байдлаар мэргэжлийн дүгнэлт хийгддэг.

Загвараар үнэлэгдсэн тэгшитгэлүүдийг дор үзүүлэв. Үүнд:

- **Төгрөгийн зээлийн хүү:** төгрөгийн зээлийн хүү нь: (1) мөнгөний бодлогын хүү; (2) нөөц мөнгө (M0); (3) улирлын дамми хувьсагч зэргээс хамаарна.
- **Гадаад валютын зээлийн хүү:** гадаад валютын зээлийн хүү нь: (1) мөнгөний бодлогын хүү; (2) нөөц мөнгө; (3) улирлын дамми хувьсагч зэргээс хамаарна.
- **IS муруй:** ДНБ-ий алдагдал нь: (1) өөрийн өмнөх үеийн утга; (2) зээлийн бодит дундаж хүү; (3) төгрөгийн бодит үйлчилж буй ханш; (4) гадаад эрэлт (Хятадын эдийн засгийн эрэлт); (5) экспортын барааны үнийн өөрчлөлт (алт, зэсийн үнэ); (6) дамми хувьсагч зэргээс хамаарна.
- **LM муруй:** нөөц мөнгө (M0) нь: (1) өөрийн өмнөх үеийн утга; (2) мөнгөний бодлогын хүү; (3) Бодит ДНБ; (4) улирлын дамми хувьсагч; (5) ТБҮЦ-ны арилжааны журам өөрчлөгдсөнтэй холбоотой дамми хувьсагч зэргээс хамаарна.
- **Валютын ханш:** төгрөгийн ам. доллартай харьцах ханш нь: (1) өөрийн өмнөх үеийн утга; (2) гадаад болон дотоод зээлийн хүүний тэнцвэр; (3) PPP нөхцөлөөс зөрөх зөрүү; (4) экспортын барааны жигнэсэн дундаж үнэ; (5) ДНБ-тэй холбоотой засгийн газрын зардал (эрсдэлийн хэмжээг төлөөлүүлэн авч үзсэн); (6) улирлын дамми хувьсагч зэргээс хамаарна.
- **Филлипсийн муруй:** цэвэр инфляци нь: (1) өөрийн өмнөх үеийн утга; (2) шатахууны үнийн инфляци; (3) ДНБ-ий алдагдал; (4) цалингийн өсөлт; (5) импортын барааны үнийн өсөлт; (6) улирлын дамми хувьсагч зэргээс хамаарна.
- **Хүнсний бүтээгдэхүүний үнэ:** хүнсний бүтээгдэхүүний үнийн инфляци нь: (1) өөрийн өмнөх үеийн утга; (2) шатахууны үнийн инфляци; (3) төгрөгийн ам. доллартай харьцах ханшийн өөрчлөлт; (4) улирлын дамми хувьсагч зэргээс хамаарна.
- **Шатахууны үнийн инфляци:** шатахууны үнийн инфляци нь: (1) өөрийн өмнөх үеийн утга; (2) дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлт; (3) төгрөгийн ам. доллартай харьцах ханшийн өөрчлөлт; (4) улирлын дамми хувьсагч зэргээс хамаарна.
- **Бодит ДНБ:** Бодит ДНБ нь: (1) өөрийн өмнөх үеийн утга; (2) ДНБ-ий алдагдал; (3) улирлын дамми хувьсагч зэргээс хамаарна.
- **Цалин:** цалингийн хэмжээ нь: (1) өөрийн өмнөх үеийн утга; (2) зэсийн үнэ; (3) улирлын дамми хувьсагч зэргээс хамаарна.

Загварын тэгшитгэлүүдээс үнэлэгдсэн итгэлцүүрүүд нь онолын болон эдийн засгийн бодит байдалтай нийцтэй, диагностик тестийг бүрэн хангасан болно. SIMOM загварыг боловсруулахад Польшийн төв банкнаас үнэтэй туслалцаа үзүүлснийг энд дурьдах нь зүйтэй юм.


Шигтгээ 4. Зээлийн хүү

Эдийн засаг дахь хамгийн чухал үнийн нэг нь зээлийн хүү билээ. Зээлийн хүү нь зээлийн үнэ бөгөөд бусад үнэтэй нэгэн адил зээлийн зах зээл дээрх хөрөнгийн эрэлт, нийлүүлэлтийн харилцан үйлчлэлээр илэрхийлэгдэж байдаг. Тиймээс зээлийн хүүний өөрчлөлтийн шалтгааныг зээлийн хөрөнгийн эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлөгч хүчин зүйлсээр судлах шаардлагатай. Зээлийн хүүний бууралтад нөлөөлдөг хүчин зүйлсийг дор дурдсанчлан ангилж болно. Үүнд:

1. Макро эдийн засгийн
2. Банкны салбарын
3. Өрсөлдөөн

Зээлийн хүү сүүлийн жилүүдэд тасралтгүй буурах хандлагатай байсан нь тайлант онд ч үргэлжиллээ. Тайлант онд төгрөгийн болон валютын зээлийн хүү өмнөх онтой харьцуулахад харгалзан 4.6 болон 1.3 нэгжээр буурч, 19.9 болон 14.2 хувьд хүрсэн байна.

Зураг 1. Зээлийн хүү,
хувиар



Макро эдийн засгийн хүчин зүйлс

Зээлийн хүү хэрхэн тодорхойлогддог вэ? гэдгийг тайлбарладаг онолын хэд хэдэн загвар байдаг. Тухайлбал, капиталын зах зээлийн онол, зээлийн зах зээл, мөнгөний зах зээл, бондын зах зээл, нэрлэсэн зээлийн хүү болон инфляцийн хоорондын хамаарлын Фишерийн онол гэх мэт. Онолын эдгээр загваруудаас дараахь хүчин зүйлс манай улсын зээлийн хүүний бууралтанд нөлөөлсөн байна. Үүнд:

1. Эдийн засгийн өсөлт, бизнес мөчлөгийн тэлэлт
2. Мөнгөний бодлого
3. Валютын ханш
4. Татварын бодлого

Эдийн засгийн өсөлт, бизнес мөчлөгийн тэлэлт. Сүүлийн жилүүдэд эдийн засаг өндөр хурдацтай өсч, бизнесийн мөчлөгийн тэлэлтийн үе үргэлжлэв. Эдийн засаг дахь нийт мөнгө, зээл, хадгаламжийн өсөлт ч өндөр хувьтай байна. Түүнчлэн гадаадад ажиллагсдын мөнгөн гуйвуулга, гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлт, банк санхүүгийн салбарын цар хүрээ өргөжин тэллээ.

Банкууд эх үүсвэрийн өсөлт дээр тулгуурлан зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлж байгаа нь зээлийн хүүг буурахад нөлөөлж байна. Эдийн засгийн өсөлтийн үед хүмүүсийн орлого (баялаг) нэмэгдсэнээр зээлийн нийлүүлэлт өсч, зээлийн хүү буурах боломж бүрддэг.

Мөнгөний бодлого. Төв банкны мөнгөний бодлогын хэрэгслүүд зээлийн нийлүүлэлтэд нөлөөлөхөөс эрэлтэд шууд нөлөө үзүүлдэггүй. Тиймээс зээлийн хүүг бүрэн хянах боломж хязгаарлагдмал байдаг. Ерөнхийдөө мөнгөний зөөлөн бодлого нь эдийн засаг дахь зээл, мөнгөний хэмжээг нэмэгдүүлэн зээлийн хүүг бууруулах хандлагатай байдаг ч зээлийн хүү нь өөр бусад олон хүчин зүйлээс шалтгаалдаг.

Монголбанк 2007 оны 3 дугаар сард банкуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулсан нь нэг талаас зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ нөгөө талаас банкуудын заавал байлгах нөөцийн шаардлагыг хангахтай холбоотой зээлийн хүүнд шингэж байсан зардлыг багасгасан юм.

Валютын ханш. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2006 онд бага хэмжээгээр чангарсан, 2007 оны эхний хагас жилд тогтвортой байсан нь зээлийн хүүний бууралтад нөлөөлөх нэг хүчин зүйл болжээ. Банкуудын төгрөгийн зээлийн хүү долларын зээлийн хүүнээс байнга өндөр байгаа юм.

Төгрөгийн зээлийн хүү болон долларын зээлийн хүү хоёулаа буурах хандлагатай байгаа ч эдгээрийн зөрүү 2007 оны эхэнд 10.2 нэгжээс оны эцэст 5.7 нэгж болон буурчээ. Үүнд төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хөдөлгөөн нөлөөлжээ.

Татварын бодлого. Зээлийн хүүний бууралтад нөлөөлсөн чухал зүйл бол 2007 оны 1 дүгээр сараас хэрэгжсэн татварын хувийн бууралт юм. Татвар нь банкуудын ашигт ажиллагаанд нөлөөлж байдаг учраас татвар буурснаар банкуудын зардал бууран, улмаар зээлийн хүүгээ бууруулах боломжтой болно. Нөгөө талаас төсөв ашигтай гарах болсон нь зээлийн зах зээл дээрх улсын секторын зээлийн эрэлт буурч, улмаар зээлийн хүүний бууралтад нөлөөлсөн.

Банкны салбарын хүчин зүйлс

Банкны зуучлал гүнзгийрч, үр ашиг сайжрах нь арилжааны банкуудын зээлийн хүү буурахад чухал нөлөөтэй юм. Санхүүгийн зуучлалын гүнзгийрэлтийг М2, М1 мөнгө ба нийт зээлийн ДНБ-д эзлэх хувиар хэмжиж Зураг 2-д үзүүлэв.

Бага мөнгө буюу М1 мөнгөний ДНБ-д эзлэх хувийн жин 2002-2006 онд тасралтгүй буурсан боловч, 2007 онд 13.0 хувь болж өслөө. Харин нийт мөнгө /М2/ болон нийт зээлийн өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 2004 оныг эс тооцвол ерөнхийдөө өсөх хандлагатай байгаа бөгөөд 2007 онд М2 мөнгөний ДНБ-д эзлэх хувь 52.7 хувь, зээлийн өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 45.1 хувь байна.

Арилжааны банкуудын зээлийн хүүний бүтцээс үзэхэд зээлийн эх үүсвэрийн зардал, эрсдэлийн үнэ зэрэг нь зээлийн хүүд нөлөөлөгч томоохон хүчин зүйлүүд юм.

1. Эх үүсвэрийн зардал.

Арилжааны банкуудын зээлийн нэг эх үүсвэр болох татан төвлөрүүлсэн хөрөнгийн бүтэц нь харилцан адилгүй боловч ерөнхийд нь авч үзвэл гадаад, дотоод эдийн засгийн агентуудын харилцах данс, хадгаламж, тэдгээрээс авсан зээл зэрэгт ангилж болно. Манай улсын хувьд банкуудын хадгаламжийн хүү харьцангуй өндөр түвшинд хадгалагдсаар байгаа нь зээлийн эх үүсвэрийн зардал өндөр байхад нөлөөлж байна. Сүүлийн жилүүдэд банкуудын олгосон нийт зээл болон хадгаламжийн харьцаа (хадгаламж/зээл) буурч байгаа нь зээлийн хүүд хадгаламжийн хүүний зардлын үзүүлэх дарамтыг харьцангуй бууруулж байна. Төсвийн харилцахын үлдэгдэл сүүлийн жилүүдэд өссөн нь зарим томоохон арилжааны банкны эх үүсвэрийн зардлыг бууруулахад нөлөөлсөн.

2. Эрсдэлийн үнэ.


Арилжааны банкуудын зээлийн хүүд нөлөөлөгч бас нэг томоохон хүчин зүйл нь эрсдэлийн хүчин зүйл юм. Банкууд ирээдүйд учирч болох эрсдэлээ үйл ажиллагааны зардалтай адилтгаж зээлийн хүүдээ шингээдэг. Банкинд учирч болох эрсдэлийг ерөнхийд нь үйл ажиллагааны, ханшийн, зээлийн, хөрвөх чадварын эрсдэл зэргээр ангилж байна.

Зээлийн эрсдэл. Банкуудын олгосон зээлийн эргэн төлөгдөх магадлал ихсэх буюу зээлийн чанар сайжрах нь зээлийн хүү буурахад ихээхэн чухал нөлөөтэй юм. Зээлийн чанарын үзүүлэлтийг нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувиар хэмжиж Зураг 3-т үзүүлэв. Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 2006 оны 7 дугаар сараас тасралтгүй буурсаар 2007 оны 12 дугаар сарын байдлаар 3.3 хувьд хүрч оны эхнээс 1.6 нэгжээр буурсан байна.


Хөрвөх чадварын эрсдэл. Банкууд нь харилцагчдынхаа итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлагч болохынхоо хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангаж ажиллах нь маш чухал юм. Энэ нь банкуудад хөрвөх чадварын эрсдэлээ зөв, үр ашигтай удирдах шаардлагыг бий болгодог. Хөрвөх чадварын эрсдэлийг үр ашигтай удирдаж чадах эсэх нь мөнгөний захын хөгжилтэй буюу банк хоорондын мөнгөний зах хэр идэвхтэй ажиллаж байна гэдгээс шууд хамаардаг. Сүүлийн жилүүдэд манай улсын банк хоорондын мөнгөний захын үйл ажиллагаа сэргэж, мөнгөний зах дээрх хэлцлийн тоо болон дүн нэмэгдэх хандлагатай байна. Банк хоорондын мөнгөний зах дээрх хэрэгслүүдийн дүн 2006 онтой харьцуулахад 2007 оны 12 дугаар сарын байдлаар 6.6 дахин өссөн байна. Энэ нь банкуудын хувьд хөрвөх чадварын эрсдэлд орох, түүнийг удирдахтай холбогдон үүсч байдаг алдагдсан боломжийн зардлыг бууруулахад чухал нөлөөтэй.

Хууль эрх зүйн орчны эрсдэл. Зээлдэгч зээлээ төлж чадахгүй тохиолдолд банк барьцаанд тавьсан үл хөдлөх хөрөнгийг шууд захиран зарцуулж худалдахад үүсдэг эрх зүйн зохицуулалтын цоорхойгоос шалтгаалан энэ ажиллагаанд 1-2 жил хүртэл хугацааг зарцуулдаг. Гэтэл нөгөө талд уг орлого авчрахаа больсон зээлийг санхүүжүүлсэн хадгаламжийн хүү автоматаар тооцогддог нь эргээд банкуудыг зээлийн хүүгээ өсгөхөд хүргэдэг.


Зураг 2. М1, М2 мөнгөний ДНБ-д эзлэх хувь




Зураг 3. Хадгаламж, дотоодын цэвэр зээлийн харьцаа



Зураг 4. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь



Зураг 5. Мөнгөний захын хэрэгслүүд, тэрбум төгрөг



Өрсөлдөөн

Банкны салбарт хадгаламж, зээлийн хүүг тогтоох явдал нь тухайн нэг банкны ашиг, эрсдэл, үйл ажиллагааны зардал болон банкны салбар дахь хадгаламж, зээлийн төлөөх өрсөлдөөнөөс ихээхэн хамааралтай байдаг. Өрсөлдөөн өндөр байна гэдэг нь банкууд зээлийн хүүгээ нэмэх боломжийг хязгаарлаж байдаг буюу байнга зээлийн хүүгээ бага байлгах шаардлагыг үүсгэдэг.

Манай улсад одоогийн байдлаар нийт 16 арилжааны банк үйл ажиллагаа явуулдаг. Эдгээрээс 2007 оны 12 дугаар сарын байдлаар нийт хадгаламжийн 82 хувийг том 5 банк дангаараа татсан байгаа бол нийт зээлийн 71 хувийг мөн тус таван банк олгосон байна. Монголын банкны салбарт төвлөрөл их байгаа бөгөөд хадгаламжийн зах зээл нь зээлийн зах зээлийг бодвол өрсөлдөөн багатай гэж үзэж болохоор байна.

Хадгаламжийн зах зээл дээр төвлөрөл ихтэй байгаа нь хадгаламжийн хүүг буурахад сөргөөр нөлөөлж, хүүг тогтоож байгаа цөөн тооны том банкуудын

хувьд хадгаламжийн хүүгээ буулгах сонирхол бага тул бусад жижиг банкууд ч мөн тэднийг даган хүүгээ өндөр түвшинд барьсаар байна. Харин банкуудын зээлдэгчдийн төлөөх өрсөлдөөн харьцангуй өндөр байгаа бөгөөд макро эдийн засгийн таатай орчин, заавал байлгах нөөцийн бууралт, банкуудын зээлжих боломжтой активын өсөлт зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан банкуудын зээлийн хэмжээ 2007 онд 68.1 хувиар өсчээ. Улмаар банкуудын зээлийн төрөлжилт эрчимтэй явагдаж, иргэдэд төрөл бүрийн урт хугацаат, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн зээл олголт өсч, энэ зах зээл дээрх өрсөлдөөн нэмэгдэх байдал ажиглагдаж байна. Зээлийн хүү ч буурах хандлага ажиглагдаж эхлээд байна. Зээлийн хүү буурч буй орчинд зээлийн хүүнээс олох орлогоо бууруулахгүйн тулд банкууд хадгаламжийн хүүгээ бууруулах боломжтой юм.

Монголбанкнаас дамжуулан олгосон зээл

Ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл

Тайлант онд Азийн хөгжлийн банкны “Ажлын байр нэмэгдүүлэх 1290-МОН төсөл”-д Голомт, Зоос, Эрэл, Анод, ХАС, Улаанбаатар хотын банкууд оролцов. 2007 оны эцсийн байдлаар ажлын байр нэмэгдүүлэх төслийн эх үүсвэр 3.4 тэрбум төгрөгтэй тэнцүү байна. Монголбанк ажлын байр нэмэгдүүлэх төслийн эргэлтийн сангийн эх үүсвэрээс 2007 оны эцсийн байдлаар 2.4 тэрбум төгрөгийн зээлийг төсөлд оролцогч банкуудад дамжуулан олгож, 2.8 тэрбум төгрөгийн зээлийг эргэн төлүүлж, банкуудын зээлийн өрийн үлдэгдэл 2.5 тэрбум төгрөг болов.

Төслийн хүрээнд 2007 онд Голомт банк 1886, Зоос банк 1007, Анод банк 345, ХАС банк 277, Эрэл банк 69, нийт 3584 ажлын байрыг шинээр бий болгожээ.

KfW төслийн зээлийн тухай

Монгол улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу экспортын чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, санхүүгийн секторыг дэмжих зорилго бүхий хоёр хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна. Монгол улс 1 дүгээр хөтөлбөрийн хүрээнд 10.0 сая марк буюу 5.1 сая евро, 2 дугаар хөтөлбөрийн хүрээнд 3.6 сая евро, нийт 8.7 сая еврогийн зээлийг авсан болно. Тайлант онд тус хөтөлбөрт Капитрон, Худалдаа хөгжил, Монгол шуудан банкууд оролцлоо.

Төслийн үндсэн эх үүсвэрийг бүрэн ашиглаж дууссан бөгөөд банкуудаас эргэн төлөгдсөн зээлийн эх үүсвэрээр төслийн зориулалтын дагуу дахин зээл олгож байна. Төсөлд оролцогч банкуудад 2007 онд 3.6 сая еврогийн зээлийг дамжуулан олгож, 2.3 сая еврогийн зээл эргэн төлүүлсэн болно. Банкуудын төслийн зээлийн өрийн үлдэгдэл тайлант оны эцсийн байдлаар 13.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.

1.2. Мөнгөний үзүүлэлтүүд

Мөнгөний нийлүүлэлт

Тайлант онд эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт оны эхнээс 56.3 хувиар буюу 864.6 тэрбум төгрөгөөр өсч 2.4 их наяд төгрөгт хүрлээ. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 70.1 хувийг бараг мөнгөний өсөлт эзэлж байгаа нь өнгөрсөн оныхоос 14.1 нэгжээр буурсан байна. Харин М1 мөнгөний өсөлт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 29.9 хувийг эзэлж, өмнөх оныхоос 14.1 нэгжээр өслөө. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт өмнөх оныхоос 21.5 нэгжээр хурдасчээ.

Мөнгөний нийлүүлэлтийг бүтцээр нь авч үзвэл, бараг мөнгө 75.4 хувь (үүнд төгрөгийн хадгаламж 46.4 хувь, гадаад валютын хадгаламж 15.7 хувь, гадаад валютын харилцах 13.3 хувь), М1 мөнгө 24.6 хувийг тус тус эзэлж байна. Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн өөрчлөлтийн хандлагыг авч үзвэл өмнөх жилд тогтвортой байсан М1 мөнгөний жилийн өсөлтийн хурдац тайлант оны нэгдүгээр сараас хойш тасралтгүй өсч оны эцэст 77.9 хувьд хүрчээ. Харин бараг мөнгөний хувьд М1 мөнгөтэй харьцуулахад харьцангуй тогтвортой байсан бөгөөд тайлант оны сүүлийн улиралд бусад улирлаас харьцангуй өндөр хувиар өссөн нь төгрөгийн хадгаламж болон валютын харилцахын өсөлттэй холбоотой. Тайлант оны мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөнд бараг мөнгө түүний дотор иргэд, аж ахуйн нэгжийн төгрөгийн хадгаламжийн өсөлт зонхилох нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт 1.1. Мөнгөний үзүүлэлтүүд

	М2 мөнгөнд эзлэх хувь*	Жилийн өсөлтийн хувь						
		2004	2005	2006	2007		2007 III улирал	2007 IV улирал
					I улирал	II улирал		
М1 мөнгө	24.6	4.0	21.6	23.3	46.3	52.8	55.6	77.9
Банкнаас гадуурхи мөнгө	11.8	9.1	6.2	21.5	49.3	32.4	41.2	53.0
Төгрөгийн харилцах	12.8	-4.3	50.0	25.7	43.0	83.8	74.8	109.3
Бараг мөнгө	75.4	27.6	39.2	38.3	46.7	35.1	38.8	50.3
Төгрөгийн хадгаламж	46.4	25.3	41.6	62.5	75.1	78.5	75.8	60.8
Валютын харилцах	13.3	-14.7	84.0	5.0	15.8	20.8	31.1	53.4
Валютын хадгаламж	15.7	75.6	13.5	23.3	16.0	-17.2	-11.7	24.1
М2 мөнгө	100.0	20.4	34.6	34.8	46.6	39.1	42.4	56.3
Мөнгөний үржүүлэгч		3.61	4.05	4.02	4.05	3.92	4.82	4.49
Мөнгөний эргэлтийн хурд		2.54	2.44	2.42	-	-	-	1.90

* Тайлант оны эцсийн М2 мөнгөний үлдэгдэлд эзлэх хувь

Тайлант онд төгрөгийн бусад валюттай харьцах ханшийн өөрчлөлт, түүний ирээдүйн хүлээлтээс хамааран төгрөгийн хадгаламж болон валютын харилцах, хадгаламжийн өсөлт оны турш харилцан адилгүй байлаа. Төгрөгийн ам. доллартай харьцах ханш тогтвортой байсан сарууд буюу оны эхний 7 сард төгрөгийн хадгаламжийн жилийн өсөлт 82.2 хувьд хүрч байсан бол 8 дугаар сард төгрөгийн ханш түр хугацаанд суларч, төгрөгийн хадгаламжийн өсөлт оны төгсгөлд 60.8 хувьд хүрсэн. Харин гадаад валютын харилцах, хадгаламжийн жилийн өсөлт харгалзан 53.4 болон 24.1 хувьтай байлаа.

Тайлант оны эхний хагаст мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нь төсөвт байгууллагад ажиллагсдын цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө зэрэг нийгмийн халамжийн зардлын өсөлт болон уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн идэвхжилтээс голлон шалтгаалж байсан бол сүүлийн хагаст Засгийн газраас хэрэгжүүлсэн төсвийн эрчимтэй тэлэх бодлогоос хамаарсан байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг байршуулалт талаас нь авч үзвэл тайлант оны эхний хагас жилд мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг өмнөх оны адилаар гадаад цэвэр активын өсөлт дангаараа хангаж байсан бол сүүлийн хагас жилд дотоод цэвэр активт шилжсэн байна. Гадаад цэвэр активын энэхүү өсөлт нь дэлхийн зах зээл дээрх алт, зэсийн үнийн өсөлттэй холбоотойгоор улсын гадаад цэвэр албан нөөцийн өсөлтөөр хангагдаж байсан бол харин дотоод цэвэр активын жилийн өсөлт сүүлийн хагас жилээс ихээхэн өссөн нь банкны системээс иргэд, хувийн секторт олгосон зээлийн өсөлтөөр хангагдаж байна.

Дотоодын зээл ийнхүү өсөхөд тайлант оны эхний улиралд Монголбанкнаас эдийн засгийн өсөлтийг дэмжих, зээлийн хүүг бууруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын хүрээнд банкуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулсан нь нөлөөлсөн. Энэ нь зээлийн хүү буурах нэг нөхцөл болжээ. Тайлант оны эцэст зээлийн хүү 19.9 хувь болж өмнөх оны мөн үеэс 4.6 нэгжээр буурав.

Банкны салбараас дотоодод олгосон цэвэр зээл өмнөх оноос 78.4 хувь буюу 584.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь дотоод цэвэр актив 138.4 хувь буюу 560.2 тэрбум төгрөгөөр өсөхөд голчлон нөлөөлжээ. Тайлант онд улсын секторт олгосон зээл 9.4 тэрбум төгрөг буюу 25.6 хувиар буурсан бол, хувийн секторт олгосон зээл 507.1 тэрбум төгрөг буюу 77 хувиар өсчээ.

Гадаад валютын цэвэр нөөц 29.1 хувь буюу 269.6 сая ам. доллараар, үүний дотор гадаад цэвэр албан нөөц 41.5 хувь буюу 284.9 сая ам. доллараар өсчээ. Энэ нь гадаад цэвэр актив өмнөх оноос 26.9 хувь буюу 304.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэх шалтгаан болов. Гадаад цэвэр албан нөөцийн энэхүү өсөлтөнд гадаадын банк дахь хугацаат хадгаламжийн хэмжээ 38.5 хувь буюу 165.4 сая ам. доллараар, гадаадын засгийн газрын үнэт цаас 27.7 хувь буюу 32.9 сая ам. доллараар, гадаадын банк дахь харилцах 18.0 сая ам. доллараар, мөнгөжсөн алт 64.2 сая ам. доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.



Зураг 1.8.

**M2 мөнгөний
бүтцийн
задаргаа
(M2-т эзлэх
хувиар)**



Зураг 1.9.

**Мөнгө, гадаад
болон дотоод
цэвэр актив
(жилийн
өөрчлөлт)**

М1 мөнгө

Тайлант оны эцэст М1 мөнгө өмнөх оны мөн үеэс 77.9 хувь буюу 258.6 тэрбум төгрөгөөр өсч 590.5 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт мөнгөний 24.6 хувийг эзэлж байна. Тайлант онд Засгийн газрын нийгмийн шинж чанартай зардлууд өссөнтэй холбоотойгоор хүмүүсийн гар дээрх бэлэн мөнгө өссөн хэдий ч санхүүгийн зуучлал гүнзгийрч, бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийн цар хүрээ улам өргөжихийн хэрээр М1 мөнгөний өсөлтөнд төгрөгийн харилцахын өсөлт зонхилох (62.0 хувь) хувийг эзлэх болж, банкнаас гадуурхи мөнгөний М1 мөнгөнд эзлэх хувийн жингээс давж гарсан байна. Сүүлийн жилүүдэд бараг мөнгөний өсөлтийн хурд М1 мөнгөний өсөлтөөс байнга өндөр байсан хандлага тайлант онд өөрчлөгдөж, М1 мөнгөний өсөлт бараг мөнгөний өсөлтөөс давах болов. Тайлант онд мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөнд М1 мөнгөний эзлэх хувь 14.1 нэгжээр өсчээ.


Тайлант онд банкнаас гадуурхи мөнгө 98.2 тэрбум төгрөг буюу 53.0 хувь, банкуудын касс 20.8 тэрбум төгрөг буюу 34.6 хувь, төгрөгийн харилцах 160.4 тэрбум төгрөг буюу 109.3 хувиар тус тус өсчээ.

2007 оны 2 дугаар сард төсвийн байгууллагын албан хаагчдын цалинг өсгөсөнтэй холбоотойгоор М1 мөнгө 1 дүгээр улирлаас эхлэн хурдтай өсч, түүний өсөлт цаашид ч тогтвортой хадгалагдсан бөгөөд 10 дугаар сард цалин дахин өссөнөөр түүний хурдац оны эцэст хамгийн дээд цэгтээ хүрэв. Дээрх нөлөөллөөс шалтгаалан 4 дүгээр улиралд буурдаг байсан өмнөх жилүүдийн М1 мөнгөний улирлын хэлбэлзэл суларсан байна. Үүнээс гадна сүүлийн жилүүдэд бараг мөнгөний хурдтай өсөлтөөс шалтгаалан М2 мөнгөнд эзлэх хувь нь буураад байсан М1 мөнгө тайлант онд өссөнөөр М2 мөнгөнд эзлэх хувь өслөө.

Бараг мөнгө


Тайлант онд бараг мөнгө 606.0 тэрбум төгрөг буюу 50.3 хувиар өсч 1.8 их наяд төгрөгт хүрсэн нь нийт мөнгөний 75.4 хувийг эзэлж байна. Энэ нь сүүлийн жилүүдэд эдийн засаг өсөхийн хэрээр иргэд, аж ахуйн нэгжийн төгрөг, валютын хуримтлал болон гадаад мөнгөн гуйвуулгын өсөлт зэргээс шалтгаалан бараг мөнгө тасралтгүй өсч буйтай холбоотой байна. Бараг мөнгөний бүтцээс харахад төгрөгийн хадгаламж оны эхнээс 421.2 тэрбум буюу 60.8 хувиар, гадаад валютын харилцах, хадгаламж 184.7 тэрбум буюу 36.1 хувиар тус тус өссөн байна. Энэ нь тайлант онд бараг мөнгөний өсөлт төгрөг болон валютын хадгаламжийн өсөлтөөр хангагдсан болохыг илэрхийлж байна.

Тайлант оны эцсийн байдлаар нийт хадгаламжийн 74.8 хувийг төгрөгийн хадгаламж, 25.2 хувийг гадаад валютын хадгаламж эзэлж байлаа. Үүнийг 2006 онтой харьцуулбал төгрөгийн хадгаламж 5.2 нэгжээр өссөн бол валютын хадгаламж мөн хувиар буурчээ.



Зураг 1.10.

M1 мөнгө
түүний бүтэц
(жилийн
өөрчлөлт)



Зураг 1.11.

Бараг мөнгө,
түүний бүтэц
(жилийн
өөрчлөлт)

Мөнгөний үржүүлэгч ба эргэлтийн хурд

Мөнгөний эргэлтийн хурд гэдэг нь эдийн засагт нийлүүлэгдэж буй мөнгө хэдэн удаа эргэлтэнд орж байгааг илэрхийлдэг үзүүлэлт юм. Тайлант оны эцсийн байдлаар мөнгөний эргэлтийн хурд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.52 нэгжээр буурч 1.90 болсон нь мөнгөний нийлүүлэлт жилд 1.9 удаа эргэлдэж байна гэсэн үг юм.

Мөнгөний эргэлтийн хурд ингэж буурах болсон шалтгаан нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нэрлэсэн үнээр илэрхийлэгдсэн ДНБ-ий өсөлтөөс өндөр байсантай холбоотой.

Харин мөнгөний үржүүлэгч өндөр байх нь эдийн засагт бага хэмжээний нөөц мөнгөөр их хэмжээний мөнгөний нийлүүлэлтийг бий болгож чадаж байгааг илэрхийлдэг. Тайлант онд мөнгөний үржүүлэгч нь өмнөх оноос 0.47 нэгжээр өсч 4.49-д хүрчээ. Энэ нь нөөц мөнгө 4.49 дахин үржигдэж эдийн засагт нийлүүлэгдэж байгааг илэрхийлж байгаа юм. Мөнгөний үржүүлэгч ийнхүү өссөн нь нэгд, тайлант онд мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нь нөөц мөнгөний өсөлтөөс өндөр байсан, хоёрт, банкнаас гадуурхи мөнгө, нийт хадгаламжийн харьцаа буурснаас бий болсон мөнгөний үржүүлэгчийн өсөлт нь банкуудын нөөц, нийт хагаламжийн харьцааны бууралтаар хангагдсан мөнгөний үржүүлэгчийн бууралтаас илүү их байсантай холбоотой байна.

Шигтгээ 5. Хөрш орнуудын 2007 оны мөнгөний бодлогын тойм

ОХУ-ын 2007 оны мөнгөний бодлогын тойм

Оросын Төв Банк (ОТБ)-ны мөнгөний бодлого нь 2007 онд өөрийн үндсэн зорилго болох инфляцийг бууруулж, үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг ханган ажиллах замаар эдийн засгийн өсөлтийг тогтвортой өндөр түвшинд байлгахад оршиж байлаа. ОХУ-ын эдийн засгийн бодит өсөлт 2007 онд 8.1 хувь гарч, гадаад секторын таатай байдал, экспортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалан гадаад худалдааны ашиг нэмэгдсэн, эдийн засагт оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ өссөн зэрэг эерэг хандлага ажиглагдсан хэдий ч дэлхий нийтээр ажиглагдаад байгаа хүнсний бүтээгдэхүүний үнэ тэр дундаа жимс, хүнсний ногоо, болон гурил гурилан бүтээгдэхүүний үнэ ихээхэн өссөн нь ОХУ-ын инфляцийг зорилтот түвшнээс өндөр (2007 онд инфляцийн зорилт нь 8.0 хувь байсан) буюу 11.9 хувьтай гарахад голлон нөлөөлсөн байна.

Дээрх инфляцийн өндөр өсөлтийн эсрэг авч хэрэгжүүлэх мөнгөний хатуу бодлогын хүрээнд ОТБ-аас 2007 онд заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээг 2 удаа өсгөж, иргэдээс татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тооцох заавал байлгах нөөцийн хэмжээг 4.0 хувьд хүргэснээс гадна, ЗБН-ийн дундаж хэмжээг тооцох хувийг 0.4 болгон өсгөсөн байна. Мөн оны эхнээс бууран 10.0 хувьд хүрээд байсан дахин санхүүжилтийн хувийг 10.25 болгож, үнэт цаасны арилжааны зарлах хэмжээг өсгөх замаар банкуудад байгаа сул хөрөнгийг бууруулж, хадгаламжийн хэрэгслийн хүүг өсгөв.

ОТБ-ны авч хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд М2 мөнгө 13.3 их наяд рубльд хүрч өмнөх оны мөн үеэс 47.5 хувиар өсч, өсөлтийн хурд нь 1.3 нэгжээр нэмэгдсэн, харин нөөц мөнгө 5.5 их наяд рубльд хүрч, жилийн өсөлт нь 33.7 хувь буюу өмнөх оны өсөлтөөс 7.8 нэгжээр саарсан байна.

ОХУ-д улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудаас 2007 онд олгосон нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 49.3 хувиар өсч 13.0 их наяд рубльд, хадгаламжийн хэмжээ 43.6 хувиар өсч 10.5 их наяд рубльд тус тус хүрчээ. Зээлийн хүү өмнөх оноос 0.3 нэгжээр өсч 10.8 хувь, хадгаламжийн хүү 1.2 нэгжээр өсч 5.2 хувьд хүрсэн байна.

БНХАУ-ын 2007 оны мөнгөний бодлогын тойм

БНХАУ-ын Ардын банкны мөнгөний бодлогын үндсэн зорилго нь үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих хэмээн тодорхойлогдсон байдаг бөгөөд тус зорилтын хүрээнд заавал байлгах нөөцийн хэмжээг тогтоох, төв банкны суурь хүүг тогтоох, дахин санхүүжилт олгох, нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах зэрэг хэрэгслүүдээр дамжуулан мөнгөний бодлогоо голлон явуулдаг.

Тус улсын эдийн засгийн өсөлт 2007 онд 11.2 хувьд хүрч, улсын хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн салбарын өсөлт хурдасч, нийт гадаад худалдааны эргэлт 2.2 их наяд ам. долларт хүрснээр гадаад худалдааны ашиг нь 0.26 их наяд ам. доллар болсон нь өмнөх оноос 13.6 хувиар илүү байна. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 13 мянган юанд хүрч, ажилгүйдлийн түвшин 0.1 нэгжээр буурсан боловч инфляцийн түвшин 6.5 хувьтай гарсан нь хүмүүсийн бодит худалдан авалтыг бууруулж, санхүүгийн зуучлалын зардлыг өсгөв.

БНХАУ-ын Ардын банк 2007 онд дээрх инфляцийн өндөр өсөлтийн эсрэг авч хэрэгжүүлсэн мөнгөний хатуу бодлогын хүрээнд заавал байлгах нөөцийн хэмжээг нийтдээ 10 удаа нэмэгдүүлж 14.5 хувьд хүргэсэн бөгөөд харин хадгаламж, зээлийн суурь хүүг нийт 6 удаа нэмж, нэг жилийн хугацаатай хадгаламжийн хүүг 4.14 хувь, харин нэг жилийн хугацаатай зээлийн хүүг 7.47 хувь болгосон байна. Хятадын Ардын банк сүүлийн жилүүдэд хэрэгжүүлж байсан зээл, хадгаламжийн хүүг тогтоох буюу мөнгөний бодлогын шууд арга хэрэгслүүдийг хэрэглэх арга барилаас татгалзах болж, шууд бус аргуудаар дамжуулан мөнгөний бодлого явуулахыг илүүд үзэх болов.

Хэдийгээр мөнгөний хатуу бодлого явуулж байгаа хэдий ч тогтвортой өсөн нэмэгдэж буй эдийн засгийн өсөлтөөс шалтгаалан мөнгөний нийлүүлэлт тасралтгүй өссөөр байна. Тухайлбал 2007 оны эцэст М2 мөнгө 5.5 их наяд ам. долларт хүрч 2006 оны мөн үеэс 16.7 хувиар нэмэгдэж, өсөлтийн хурд нь 0.22 нэгжээр буурсан байна. М1 мөнгөний хувьд 2.09 их наяд ам. долларт хүрч өмнөх оноос 21.0 хувиар өсч, 2006 оны эцэстэй харьцуулахад 3.53 нэгжээр хурдасчээ. Нөөц мөнгөний хувьд 0.42 их наяд ам. доллар болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.1 хувиар өссөн байна.

Нөөц мөнгө ийнхүү хурдацтай өсч байгаа нь 2006 оны сүүлийн хагас жилээс хадгаламжийн байлгах нөөцийн хувь хэмжээг удаа дараалан нэмсэнтэй холбоотой.

Харин БНХАУ-ын банк санхүүгийн байгууллагуудын юань болон гадаад валютын зээлийн үлдэгдэл 2007 оны байдлаар 3.8 их наяд ам. долларт хүрч, 16.4 хувиар өсчээ. Үүнээс юанийн зээлийн үлдэгдэл 3.6 их наяд ам. доллар болж өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар, гадаад валютын зээлийн үлдэгдэл 219.8 тэрбум ам. долларт хүрч 30.2 хувиар тус тус өссөн байна.

1.3. Валютын нөөцийн удирдлага

Монголбанкнаас 2007 оны санхүүгийн жилд улсын гадаад валютын нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх, эрсдэл багатай, үр өгөөжтэй санхүүгийн хэрэгслүүдэд байршуулах, удирдлагын оновчтой тогтолцоог бүрдүүлэх зэрэг чиглэлээр ажиллалаа.

Гадаад активын дүн 282.6 сая ам. доллараар нэмэгдэж, пассивын дүн 5.4 сая ам. доллараар буурснаар, гадаад валютын цэвэр албан нөөцийн хэмжээ 2007 оны эцсийн байдлаар 975.3 сая ам. долларт хүрлээ. Энэ нь манай улсын импортын 24 долоо хоног буюу 5.4 сарын хэрэгцээг хангахуйц хэмжээнд хүрч, төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд тусгагдсан зорилтот хэмжээ болох импортын 17 долоо хоногийн нөөцийг бүрэн хангасан байна.

Гадаад валютын энэхүү өсөлтийн 79.9 хувь нь нөөцийн бодит өөрчлөлт байсан бол 20.1 хувь нь валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалжээ. Тухайлбал, гадаад валютын цэвэр албан нөөцийн хэмжээ алтны үнийн ам. доллартай харьцах ханшийн өөрчлөлтөөс 37.1 сая ам. доллараар, еврогийн ам. доллартай харьцах ханшийн өөрчлөлтөөс 17.4 сая ам. доллараар тус тус нэмэгдсэн байна.


Гадаад валютын нөөцийн удирдлагын шийдвэр гаргалтыг дэлхийн улс орнуудад хэрэглэгддэг туршлагыг үндэслэн хөрөнгө оруулалтын хороо болон гүйцэтгэх түвшний ажилтнууд гэсэн 2 түвшний бүтцийг 2007 оны 4 дүгээр улирлаас эхлэн нэвтрүүллээ.

Нөөцийн удирдлагын албадын бүтцийг олон улсад нийтлэг хэрэглэгддэг, нөөцийн удирдлагын стандарт бүтэц болох арилжааны, дундын, арын албаны бүтцэд шилжүүлэх зорилгоор дундын албаны үүргийг гүйцэтгэх үүрэг бүхий “Эрсдэлийн удирдлагын алба”-ыг 2007 оны 1-р сард байгуулсан. Энэхүү алба нөөцийн удирдлага, гадаад валютын арилжааны үйл ажиллагаатай холбоотой гаргах бүх төрлийн эрсдэлийг бие даан тодорхойлох, хэмжих болон хянах, нөөцийг байршуулах жишгийг тодорхойлох, түүний гүйцэтгэлийн үр дүнг тайлагнах үүрэгтэйгээр ажиллаж байна.



Зураг 1.12.

Гадаад валютын цэвэр албан нөөцийн хөдөлгөөн /1992-2007/



Зураг 1.13.

Монголбанкинд тушаасан алт (бохир жингээр)



Зураг 1.14.

Төгрөгийн үйлчилж буй нэрлэсэн болон бодит ханш

Монголбанк алт олборлогч 110 гаруй аж ахуйн нэгж, давхардсан тоогоор 168 иргэдээс бохир жингээр 8.4 тонн, цэвэрт шилжүүлснээр 7.4 тонн алтыг 277.4 тэрбум төгрөгөөр шууд болон арилжааны банкуудаар дамжуулан худалдан авсан бөгөөд Алтандорнод Монгол ХХК-ийн хадгалуулж байсан 2.0 тонн алтыг жилийн эцэст тооцоо хийж дуусгаснаар 2007 оны санхүүгийн жилд бохир жингээр 10.5 тонн, цэвэрт шилжүүлснээр 9.3 тонн алт худалдан авчээ. Энэхүү худалдан авсан алтны бохир жинг өмнөх онтой харьцуулахад 7.1 хувиар буюу 0.6 тонноор буурчээ. Сүүлийн 2 жилд иргэд, аж ахуйн нэгжээс тушаах алтны хэмжээ буурсан дүнтэй байна.

Гадаад валютын нөөцийн хэмжээ өссөн, удирдлагын үр ашиг сайжирсантай холбоотойгоор санхүүгийн хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн хүүний орлого 39.3 сая ам. долларт хүрч өнгөрсөн оноос 2.7 дахин өссөн байна.

Тайлант онд нийт гадаад активын дундаж үр өгөөж бэлэн валютыг оруулахгүйгээр жилийн 4.13 хувь, бэлэн валютыг оруулснаар жилийн 4.09 хувьтай тус тус байна.

Тайлант оны туршид нийт гадаад активын голлох хувийг эзэлж байсан ам. доллар, мөнгөжсөн алт, еврогийн хөрөнгө оруулалтын жилийн дундаж үр өгөөжийг хэрэгсэл, валютын хувьд авч үзвэл дараахь байдалтай байна.

Хүснэгт 1.2. Хөрөнгө оруулалтын 2007 оны өгөөж, хувиар

Активын төрөл	Ам. доллар	Евро	Мөнгөжсөн алт	Нийт дүн
Хадгаламж	5.15	4	0.16	4.64
Харилцах	4.95	2.19	0	2.91
Үнэт цаас	5.41	-0.41	0	4.38
Дундаж үр өгөөж	5.13	3.39	0.02	4.13

Эх сурвалж: Эрсдэлийн удирдлагын алба, 2008 оны 1 дүгээр сар

Мөнгөжсөн алтны өгөөж тайлант онд 2006 онтой харьцуулахад 0.22 нэгжээр буурсан хэдий ч бусад үндсэн валют болох ам. долларын өгөөж 0.26 нэгжээр, еврогийнх 0.58 нэгжээр тус тус өсч, нийт дүнгээрээ гадаад валютын нөөцийн өгөөж 0.9 нэгжээр нэмэгдсэн байна.

1.4. Төгрөгийн ханшийн хөдөлгөөн

Төгрөгийн нэрлэсэн ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр 1165.0 төгрөг байсан бол жилийн явцад 0.4 хувиар суларч 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1169.97 төгрөгт хүрэв. Тайлант онд төгрөгийн ханшийн хэлбэлзэл 0.1 хувь байсан тул ханш ерөнхийдөө тогтвортой байв.

Нефтийн гадаад зах зээлийн үнэ, дотоодын нефтийн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ эрчимтэй өсч байсан ч 2007 оны эхний хагас жилийн байдлаар урсгал данс 92.6 сая ам. долларын ашигтай гарсан тул төгрөгийн ам.

доллартай харьцах ханш тогтвортой байх үндэс боллоо. Үүнд зэс, алтны экспортын үнэ өндөр, гадаадад ажиллагсдын гуйвуулга 67.8 сая ам. долларт, шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 73.6 сая ам. долларт хүрсэн, 74.8 сая ам. долларын санхүүгийн хөрөнгө оруулалт орж ирсэн зэрэг нь нөлөөлөв.

Нефтийн гадаад зах зээлийн үнэ 2007 оны 7 дугаар сард 4.5 хувиар өсч, уул уурхай болон барилгын ажил эрчимжиж тухайн сарын худалдааны тэнцэл 19.8 сая ам. долларын алдагдалтай гарав. Нефтийн дэлхийн зах зээлийн үнэ 2007 оны 8 дугаар сард дахин 2.8 хувиар өссөн, түүнээс гадна, тухайн сард шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 33.9 сая ам. долларт, гадаадад ажиллаж байгаа монголчуудын гуйвуулга 32.3 сая ам. долларт хүрсэн, дотоодын цалингийн дундаж түвшин, барилгын ажил улам эрчимжсэн зэрэг нь дотоодын бараа бүтээгдэхүүний хэрэгцээг нэмэгдүүлж импортыг өсгөв. Иймд тухайн сарын худалдааны тэнцэл 9.5 сая ам. долларын алдагдалтай гарч дотоодын валютын эрэлт хэрэгцээ нэмэгдэж төгрөгийн ам. доллартай харьцах ханш 8 дугаар сарын 1-ний өдөр 1164.13 төгрөг байсан бол сарын явцад 2.0 хувиар суларч сарын эцэст 1187.28 төгрөг болсон байв.

Тайлант оны 4 дүгээр улиралд экспортын орлого өсч, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ эрс нэмэгдэж 172.1 сая ам. долларт, гадаадад ажиллагсдын гуйвуулга 53.5 сая ам. долларт хүрч, валютын нийлүүлэлт нэмэгдэж, төгрөгийн ам. доллартай харьцах ханш чангарч эхэлсэн.

Түүнчлэн манай улсаас БНХАУ-тай хийж байгаа гадаад худалдааны төлбөр тооцоонд юанийн эзлэх хувь 4 дүгээр улирлын байдлаар 15.0 хувьд хүрэв. Энэ нь ам.доллартай харьцах төгрөгийн ханшинд эерэгээр нөлөөлж байлаа.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш

Тайлант оны эцэст төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 80.55³, бодит үйлчилж буй ханшийн индекс 81.73⁴ болж, суурь 2000 оноос төгрөг худалдааны түнш орнуудын валютын эсрэг нэрлэсэн үнээр 19.5 хувь, бодит үнээр 18.3 хувиар тус тус сулрав. Үүнд манай улсын худалдааны томоохон түнш орнуудын валютын ханш тайлант онд америк долларын эсрэг ихээр чангарсан нь нөлөөлжээ.

³ Нэрлэсэн үйлчилж буй ханш гэдэг нь гадаад худалдааны гол түнш орнуудын валютуудын жигнэсэн дундаж үнэтэй харьцах үндэсний валютын үнийг хэлнэ.

⁴ Бодит үйлчилж буй ханш гэдэг нь гадаад худалдааны гол түнш орнуудын валютуудын дундаж нэгжтэй харьцах үндэсний валютын ханшийг тэдгээр улсуудын дундаж үнийн өөрчлөлттэй уялдуулан тооцсон ханшийг хэлнэ.

Банкны салбарт 2007 оны эцсээр 16 банк 981 салбар нэгж, 9369 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

2.1. Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд

Сүүлийн жилүүдэд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас банкинд байршуулсан эх үүсвэрийн дүн тогтмол нэмэгдэж байна. Тухайлбал, 2007 онд банкны салбарын харилцахын дүн 75.7 хувь буюу 304.9 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн дүн 46.0 хувь буюу 477.2 тэрбум төгрөгөөр тус тус өсч 707.9 болон 1515.2 тэрбум төгрөгт хүрсэн нь банкуудын эдийн засагт гүйцэтгэх санхүүгийн зуучлалын цар хүрээг өргөжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан болно.

Харилцах, хадгаламжийн энэхүү өсөлтийн зэрэгцээ 2007 онд банкуудын өөрийн хөрөнгийн хэмжээ 27.6 хувь буюу 81.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд энэхүү өсөлтийн дийлэнх хэсгийг ашиг болон хоёрдогч өглөгийн өсөлт бүрдүүлж байна. Үүнд банкны ашигт ажиллагааг илэрхийлсэн цэвэр орлого болон нийт активын харьцаа салбарын дунджаар 2.5 хувьтай гарсан нь аж үйлдвэржсэн буюу өндөр хөгжилтэй зарим нэг орны үзүүлэлтээс өндөр хэвээр байна.

Харилцах, хадгаламж, бусад банкнаас авсан зээлийн өсөлт нь банкны салбарын нийт активыг 51.2 хувь буюу 1110.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүллээ. Үүний үр дүнд банкны салбарын нийт актив 3.3 их наяд төгрөгт хүрч, дотоодын нийт бүтээгдэхүүний 71.9 хувьтай тэнцэх болсон байна. Энэ нь банкны салбарын хямралт үе буюу 1996-1998 оны үзүүлэлтээс даруй 3.5 дахин өндөр байгаад зогсохгүй Энэтхэг, Бразил, Унгар зэрэг улс орны түвшинд хүрээд байгаа юм.

Банкны салбарын актив өсөхийн хэрээр хувийн хэвшилд олгох зээл, санхүүжилтийн хэмжээ тогтвортой нэмэгдэж байна. Тухайлбал, 2000 онд банкууд 1700 хүрэхгүй тооны зээлдэгчдэд 60 орчим тэрбум төгрөгийн зээл олгож байсан бол 2007 оны эцсийн байдлаар 16 банкнаас 500 мянга шахам зээлдэгчдэд 2.1 их наяд төгрөгийн зээл олгосон нь 2000 оны үзүүлэлтээс 35 дахин нэмэгджээ.

Нийт зээлийн 29.2 хувь нь худалдаа үйлчилгээний салбарт, 15.6 хувь нь барилгын салбарт, 13.0 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 7.6 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 6.3 хувь нь уул уурхайн салбарт олгогдсон байна. Барилга угсралтын салбарт 2007 онд олгосон зээлийн хувийн жин 6.6 нэгжээр өсч, тээвэр холбооны салбарт олгосон зээлийн хувийн жин 2.6 нэгжээр, худалдааны салбарт олгосон зээлийн хувийн жин 2.3 нэгжээр тус тус буурч, харин бусад салбарт олгосон зээлийн хувийн жин харьцангуй тогтвортой байв.

Үүний зэрэгцээ банкууд зээлийн удирдлагыг сайжруулж, чанаргүй зээлийн хувь хэмжээг бууруулах талаар санаачилга гарган ажилласны дүнд чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин тогтвортой буурч, 2007 оны эцсийн байдлаар 3.2 хувьтай болжээ.

Өнгөрсөн жилүүдэд банкууд зээлийн өрийн үлдэгдлээ эрчимтэйгээр нэмэгдүүлээд зогсохгүй бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, хөдөө орон нутаг буюу алслагдсан сум, багт санхүүгийн үйлчилгээг хүргэх, жижиг дунд үйлдвэрлэл болон орлого багатай иргэдийг банк, санхүүгийн үйлчилгээнд хамруулах талаар тодорхой үр дүнд хүрсэн болно. Үүний нэг илрэл нь хөдөө орон нутаг дахь банкуудын салбар, нэгжийн өсөлт юм. Банкуудын салбар нэгжийн тоо 17.9 хувь буюу 149-өөр нэмэгдлээ. Үүнд Монгол шуудан банкны салбар нэгжийн тоо 90, ХААН банкных 43, Голомт банкных 12-оор тус тус нэмэгдсэн нь салбарын хэмжээгээр ийнхүү томоохон өөрчлөлт гарахад нөлөөлөв.

Хүснэгт 2.1. Банкуудын салбар нэгжийн тоо

	2007	2006	2005	2007 2006	2007 2005
1 ХААН банк	466	423	397	43	69
2 Худалдаа хөгжлийн банк	20	18	17	2	3
3 Хадгаламж банк	47	54	45	-7	2
4 Голомт банк	45	33	23	12	22
5 Монгол шуудан банк	230	140	86	90	144
6 Эрэл банк	5	5	5	0	0
7 Улаанбаатар хотын банк	9	9	9	0	0
8 Капитал банк	27	25	18	2	9
9 Тээвэр хөгжлийн банк	3	3	4	0	-1
10 Кредит банк	7	10	9	-3	-2
11 Зоос банк	37	32	33	5	4
12 Анод банк	26	21	23	5	3
13 Капитрон банк	17	18	20	-1	-3
14 ХАС банк	40	39	40	1	0
15 ҮХО банк	0	1	1	-1	-1
16 Чингис хаан банк	2	1	1	1	1
Нийт	981	832	731	149	250

Шинээр байгуулсан салбар нэгжийн дийлэнх хэсэг нь хөдөө орон нутагт ногдож байгаа бөгөөд санхүүгийн салбар дахь өрсөлдөөнийг нэмэгдүүлж, хөдөө орон нутагт олгогдож байгаа зээлийн хүүг бууруулах, хугацааг уртасгахад зохих хувь нэмэр оруулж байна.



Зураг 2.1.


Банкуудын харилцах, хадгаламж, түүний ДНБ-д эзлэх хувь



Зураг 2.2.

Банкны ашигт ажиллагаа (цэвэр ашиг болон нийт активын харьцаагаар)


Эх сурвалж: Монголоос бусад орны мэдээллийг Олон улсын валютын сангаас гаргадаг "Global Financial Stability Report" эмхэтгэлээс авав. Үүнд Их Британи, Хятадын үзүүлэлт 2006 оны эцсийн байдлаар, бусад орны үзүүлэлт 2007 оны 3 дугаар сарын байдлаар үзүүлсэн болно.




Зураг 2.3.


ДНБ-д эзлэх банкны салбарын нийт актив

Зураг 2.4.
Банкуудын
ээлийн өрийн
үлдэгдэл,
эдийн засгийн
салбараар




Зураг 2.5.
Чанаргүй
ээлийн нийт
ээлд эзлэх
хувийн жин





Зураг 2.6.

Банкны салбарын активын бүтэц



Зураг 2.7.

Банкны салбарын эх үүсвэрийн бүтэц

2.2. Банкны салбарын хөрөнгө болон эх үүсвэрийн бүтэц

Банкуудын зээлийн үйл ажиллагаа 2007 онд ихээхэн эрчимжиж, зээлийн нийт активт эзлэх хувийн жин 7.5 нэгжээр нэмэгдэж 64.5 хувьд хүрчээ. Зээлийн хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалан банкуудын мөнгөн хөрөнгийн нийт активт эзлэх хувийн жин 24.6 хувьтай болов.

Банкны салбарын эх үүсвэрийн дийлэнх буюу 70-аад хувийг харилцах, хадгаламж эзэлж байна. Өмнөх онуудад харьцангуй бага өсөлттэй байсан харилцахын дүн 2007 онд төсвийн тэлэх бодлогоос улбаалан ихээхэн нэмэгдлээ. Бусад пассивын хувийн жин нэмэгдсэн нь банкууд хадгаламжийн сертификат болон бусад төрлийн санхүүгийн хэрэгслээр эх үүсвэр татах болсонтой холбоотой.

Банкны салбарын актив, пассивын бүтцэд үндэслэн дүгнэвэл:

- Зээлийн эрэлт өндөр байсан нь өмнөх оны сүүлээр банкуудад ихээр хуримтлагдаад байсан мөнгөн хөрөнгийн дүнг буурахад нөлөөлжээ.
- Банкуудын хувьд харьцангуй хямд эх үүсвэр болох харилцахын хувийн жин өссөн байна.

2.3. Банкны салбарын зохистой харьцааны үзүүлэлтүүд


Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Банкуудын ашигт ажиллагаа дээшилсэн, хоёрдогч өглөг ихээр татсан, чанаргүй зээлийн хувь хэмжээ буурсан зэрэг нь банкны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүдийг зохистой түвшинд барихад нөлөөлжээ. Үүнд банкуудын эрсдэлээ даах чадварыг илэрхийлсэн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 1999 оноос хойш 14-24 хувьтай байсан нь олон улсын стандарт буюу Швейцарь дахь Базелийн хорооноос тогтоосон хувь хэмжээнээс 1.8-3 дахин өндөр үзүүлэлт юм. Манай улсын банкны салбарын өөрийн хөрөнгийн зохистой харьцааг зарим нэг өндөр хөгжилтэй болон шилжилтийн эдийн засагтай улс, орны үзүүлэлттэй харьцуулахад дараахь байдалтай байна. (Зураг 2.8)

Банкуудын өрсөлдөөн нэмэгдэж, сул чөлөөтэй эх үүсвэрийн ашиглалт сайжирснаас зээл болон бусад эрсдэлтэй активын өсөлт өндөр байж, улмаар өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа банкны салбарын хэмжээгээр 2007 онд 14.2 хувьтай болжээ.

Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлт


Арилжааны банк нь гадаад валютын нээлттэй позици, өөрийн хөрөнгийн харьцааг нэг валютын хувьд +/-15 хувийн дотор, нийт нээлттэй позицийн хувьд +/-40 хувийн дотор барьж байх ёстой. Банкны салбарын дундаж үзүүлэлтээр 2007 оны эцэст нийт нээлттэй позицийн зохистой харьцаа нь 30.1 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон хязгаарт байна.



Эх сурвалж: Монголоос бусад орны мэдээллийг Олон улсын валютын сангаас гаргадаг "Global Financial Stability Report" эмхэтгэлээс авав. Үүнд Их Британи, Хонг Конгийн үзүүлэлт 2006 оны эцсийн байдлаар, бусад орны үзүүлэлт 2007 оны 3 дугаар сарын байдлаар үзүүлсэн болно.

Зураг 2.8.

Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, орнуудаар



Зураг 2.9.

Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, жилээр



Зураг 2.10.

Гадаад актив, пассивын нийт актив, пассивт эзлэх хувийн жин

Тайлант онд гадаад валютын актив 17.5 хувь буюу 189.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 1270.8 тэрбум төгрөгт хүрсэн бол гадаад пассив 8.4 хувь буюу 78.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 1012.6 тэрбум төгрөг болов. Үүнд гадаад активын нийт активт эзлэх хувийн жин 8.4 нэгжээр буурч 36.8 хувь болсон бол гадаад пассивын хувийн жин 0.3 нэгжээр өсч 32.3 хувь боллоо. Энэ нь төгрөгийн ханш харьцангуй тогтвортой байгаа болон төгрөгөөр хийгдсэн мөнгөний нийлүүлэлт өсч байгаатай холбоотойгоор гадаад валютын гүйлгээ буурч байгаагийн илрэл юм.

Банкууд эх үүсвэрийнхээ өсөлт дээр тулгуурлан актив болон зээлийн хэмжээг нэмэгдүүлж, улмаар эдийн засагт гүйцэтгэж буй санхүүгийн зуучлалын цар хүрээг өргөжүүлсээр байна. Банкуудын үйл ажиллагааны өргөжилт нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны хүрээнд явагдаж, тогтвортой болон зохистой хөгжлийг хадгалжээ.

Шигтгээ 6. Бичил санхүүгийн хөгжил

Бичил санхүүжилт гэдэг нь ядуу, орлого багатай иргэдэд үйлдвэрлэлийн буюу бүтээлч үйл ажиллагаа эрхлэх, тэдний жижиг бизнесийг хөгжүүлэхэд зориулан бага хэмжээний зээл буюу бичил зээл олгох ажиллагааг хэлдэг. Бичил санхүү гэдэг ойлголт хөгжлийнхөө явцад улам гүнзгийрч зээл, хадгаламж, даатгал гэх мэт олон төрлийн санхүүгийн үйлчилгээг давхар багтаадаг болсон. Түүхийн хуудаснаас сөхвөл бичил зээлийн тухай ойлголт 1930-аад оноос Бангладеш, Бразил гэх мэт цөөн хэдэн улсад бий болж улмаар 1980 оноос дэлхийн түвшинд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн байна. Бичил санхүүгийн үйлчлүүлэгчид нь албан ёсны санхүүгийн байгууллагын үйлчилгээг төдийлөн авч чаддаггүй, орлого багатай, ядуу иргэд юм. Эдгээр иргэд нь ихэнхдээ хувиараа хөдөлмөр эрхлэх боломжтой байдаг. Тухайлбал, манай орны хувьд хөдөө орон нутагт цөөн тооны мал маллах, түргэн үйлчилгээний цэг ажиллуулах, лангуу түрээслэх, ганзагын наймаа эрхлэх, цайны газар ажиллуулах, хүнсний ногоо тарих, бага хэмжээний тариалан эрхлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх, бага хэмжээний зочид буудал, зоогийн газар, дэлгүүр ажиллуулах гэх мэт бусад олон төрлийн үйл ажиллагааг нэрлэж болно. Бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч олон төрлийн байгууллага байдаг. Үүнд, албан ёсны зуучлагчид-арилжааны банк, ББСБ, ХЗХ, даатгалын компани, санхүүгийн лизингийн компани, барьцаат зээлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага, хагас албан ёсны зуучлагчид-төрийн бус байгууллага, Засгийн газрын сан, бусад албан бус эх үүсвэрүүд хамрагддаг. Ихэнх тохиолдолд бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь хүн амын орлого багатай иргэдийг дэмжих зорилготой төрийн бус байгууллагууд байдаг. Бичил санхүүгийн харилцагчдыг онцлогоор нь бизнесийн харилцагчид-бизнесийн үйл ажиллагаа явуулж түүнийгээ өргөжүүлэх, илүү ашиг олохыг эрмэлздэг хүмүүс, бусад харилцагчид-ихэвчлэн хувийн хэрэглээ, ахуй байдлаа дээшлүүлэхийг хүсдэг ажил эрхлэгчид, албан хаагчид, суралцагчид, тэтгэврийн иргэд гэж хуваадаг. Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудын хэмжээнд бичил санхүүгийн зах зээл хурдацтай хөгжиж байна. Судалгаагаар бичил зээлээр амьдралын түвшингээ дээшлүүлсэн ядуу иргэдийн тоо дэлхийн хэмжээгээр 1997 онд 7.6 сая хүн байсан бол 2005 онд 33.8 сая хүрч өссөн мэдээ байна. Бичил санхүүгийн үйл ажиллагаа нь

иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ шинээр ажлын байр бий болгох замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, шинэ технологи, үйлдвэрлэл, бүтээгдэхүүн бий болгох, бичил болон том бизнесүүдийг холбож өгөх зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Манай улсад бичил санхүүгийн хөгжил эхэн үедээ Засгийн газар болон донор байгууллагуудаас хязгаарлагдмал хүрээнд хэрэгжүүлж ирсэн төсөл, арга хэмжээгээр хязгаарлагдаж байлаа. Бичил санхүү нь 1998 оноос эхлэн ядуурлыг бууруулах, хуримтлалтай болгох, орлогоо нэмэгдүүлэх хүчтэй арга хэрэгсэл болон хөгжиж эхэлжээ. Бичил санхүүгийн үйл ажиллагааг зөвхөн банкууд биш банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоод болон бусад төрийн бус, олон нийтийн байгууллагууд эрхэлж төв суурин газар болон хөдөө орон нутагт үйлчилгээ үзүүлж эхэлсэн. Манай улсын бичил санхүүгийн хөгжлийн гол үйл явцыг товчлон дурдвал, 1994 онд Монгол улсын засгийн газар, Дэлхийн банктай хамтран ядуурлыг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн, 1996 онд бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч гол байгууллагуудын нэг хадгаламж зээлийн анхны хоршоо байгуулагдсан, 1997 онд Нэгдсэн Үндэсний байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс (НҮБХХ) Монгол улсын төрийн бус 6 байгууллагаар дамжуулан “Микростарт” төслийг хэрэгжүүлж эхэлсэн, 1999 онд анхны ББСБ болох “ХАС” байгуулагдсан, 2002 онд анхны “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа”-ны тухай хууль батлагдсан, 2004 онд Монгол улсад “Бичил зээл ба бизнес” үндэсний чуулган зохион байгуулагдсан, 2005 оныг Монгол улсын Засгийн газраас “Бичил санхүүгийн жил” болгон зарласан, 2006 онд бичил санхүүгийн үйл ажиллагааг хянан зохицуулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хороог байгуулсан байна. Манай оронд үйл ажиллагаа явуулж байгаа бичил санхүүгийн байгууллага бичил бизнес эрхлэгчдэд үйлчилгээ үзүүлэхээс гадна мөн орлого багатай иргэд, төрийн болон олон нийтийн албан хаагчид, хувийн хэвшлийн ажилчид, тэтгэврийн болон ажилгүй иргэд, оюутан залууст үйлчилгээ үзүүлж байна. Манай улс Мянганы хөгжлийн зорилгод хүн амын ядуурлыг 2015 онд 1990 онтой харьцуулахад хоёр дахин бууруулах зорилтыг биелүүлэх үндсэн арга хэрэгсэл нь бичил санхүүгийн үйлчилгээ, ялангуяа бичил зээлийн үйлчилгээ болохыг тодорхойлсон байдаг.

Монгол улсад 2007 оны эцсийн байдлаар 137 Хадгаламж зээлийн хоршоо, 181 Банк бус санхүүгийн байгууллага, 16 банк бичил санхүүгийн үйл ажиллагаа явуулж байгаа нь санхүүгийн салбарын нийт зээлийн 20 гаруй хувь, ДНБ-ий 10 гаруй хувийг тус тус эзэлж байна. Монголбанкнаас 2007 онд явуулсан санал асуулгад оролцсон иргэдийн 54.3 хувь нь бичил зээл авч бизнесийн үйл ажиллагаа явуулах боломжтой гэж хариулсан нь өмнөх онуудын (2005 онд 59.1 хувь, 2006 онд 57.1 хувь) түвшинд байна. Санал асуулга явуулсан гурван жилийн дунджийг авч үзвэл, иргэдийн хамгийн их буюу 28.3 хувь нь бичил зээлээр худалдаа наймаа, 10.7 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг байна. Түүнчлэн мал аж ахуй (дунджаар 8.2 хувь), үйлчилгээ буюу зоогийн газар ажиллуулах (7.5 хувь), хүнсний ногоо тарих (6.9 хувь), газар тариалан (6.6 хувь) эрхлэх үйл ажиллагааны төрлүүд багтаж байна.

Харин аялал зуучлал (3.2 хувь), зочид буудлын бизнес (1.4 хувь) бичил зээлдэгчдийн дунд төдийлөн хөгжөөгүй байна. Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн хамгийн их буюу 33.0 хувь нь 3 сая төгрөгөөс дээш мөнгөөр бичил бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд тохиромжтой гэж үзжээ. Мөн 20.2 хувь нь 1 саяас 2 сая төгрөг хүртэлх мөнгөөр бичил бизнес эрхлэхэд боломжийн гэж хариулсан байна. Эндээс манай орны хувьд өнөөгийн байдлаар 1 сая төгрөгөөс дээш мөнгөөр бичил бизнес эрхлэхэд хамгийн тохиромжтой гэж дүгнэж болохоор байна. Бичил бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд хамгийн тохиромжтой хугацаа бол 9 сараас 1 жил хүртэлх хугацаа гэж иргэдийн ихэнх буюу 63.2 хувь нь хариулсан нь өмнөх онуудын (2005 онд 60.8 хувь, 2006 онд 61.2 хувь) хандлагыг давтсан байна. “Монгол дахь бичил санхүүгийн дэд салбарын судалгаа”-нд өгүүлснээр 1998 онд нийт айл өрхийн 1 хувь нь зээл авч байсан бол 2004 онд 26 хувь болж өсчээ. 2007 оны санал асуулгын дүнгээр энэ тоо 40 гаруй хувь хүртэл өссөн байж болох магадлалтай байна. Иргэдийн дийлэнх нь банк, санхүүгийн байгууллагаас 1-5 удаа бичил зээл авч бизнесийн үйл ажиллагаа явуулж байна. Банк, санхүүгийн байгууллагаас бичил зээл авсан иргэдийн талаас дээш хувь нь бизнес явуулах өөрийн эх үүсвэртэй болж чадсан нь бичил санхүүгийн үйл ажиллагааны нааштай үр дүнг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 50 гаруй хувь нь бичил зээл авах боломжтой бөгөөд 40 орчим хувь нь 1-5 удаа бичил зээл авч бизнес эрхэлж байсан байна. Манай улсад бичил санхүүгийн хөгжил багагүй амжилт олсон нь судалгааны дүнгээс харагдаж байна. Цаашид бичил санхүүгийн үйл ажиллагааг боловсронгуй болгохын тулд дараахь алхмуудыг хийх шаардлагатай юм. Үүнд,

- Бичил санхүү, бичил бизнесийн ач холбогдлын талаархи ойлголтыг иргэдэд улам дэлгэрүүлэн сурталчлах,
- Санхүүгийн дэд салбарын төвлөрлийн эрсдэлийг бууруулах,
- Хөдөө орон нутагт тухайн орон нутгийн онцлогтой уялдуулан бичил санхүүгийн үйл ажиллагааг хөгжүүлэх,
- Засгийн газраас бичил санхүүгийн нэгдсэн бодлого явуулж, түүнийг сурталчлах үйл ажиллагааг идэвхжүүлэх,
- Хууль зүйн орчинг улам боловсронгуй болгож, хяналт, эрх зүйн зохицуулалт хийх ажлыг түргэвчлэх,
- Бичил санхүүгийн шинэ үйлчилгээг хөгжүүлэх алхмыг түргэтгэх,
- Донор орнуудын оролцоог улам нэмэгдүүлэх, төсөл хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх,
- Бичил санхүүгийн үйл ажиллагаанд төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх,
- Бичил бизнесээс том бизнес рүү уриан дор иргэдийн бичил бизнес эрхлэх идэвхийг нэмэгдүүлж, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлж өгөх г.м.

Эдгээрийг хэрэгжүүлснээр ядуурлыг бууруулах, шинээр ажлын байр бий болгох замаар ажилгүйдлийг багасгах зэрэг олон талын ач холбогдолтойгоос гадна эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах болно.

2.4. Банкны хяналт шалгалт

Тайлант онд банкуудын үйл ажиллагаа эрчимжиж, санхүүгийн зуучлалд гүйцэтгэх үүрэг нэмэгдлээ. Манай улсын санхүүгийн салбарыг бүрдүүлж байгаа үндсэн байгууллагууд нь банкууд бөгөөд банкны салбарын нийт актив санхүүгийн салбарын нийт активын 95 орчим хувийг эзэлж байна. “Төв банк (Монголбанк)-ны тухай хууль”-д заасан санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтын хүрээнд Монголбанкнаас банкуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу 2007 онд хяналт тавин ажиллалаа.

Банкуудын эдийн засагт гүйцэтгэх үүрэг нэмэгдэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэхийн хэрээр тэдгээрт тавих хяналт шалгалтын орчинг улам боловсронгуй болгох асуудал тулгарч байгаа бөгөөд банкууд өөрсдийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүдийг зөв тодорхойлон удирдаж, зохистой удирдлагыг сайжруулан, цаашдын үйл ажиллагааныхаа чиг хандлагыг тодорхойлох асуудалд зүй ёсоор анхаарлаа төвлөрүүлж байна.

“Банкны салбарын бүтцийн өөрчлөлт, хөгжлийн талаархи богино хугацааны үзэл баримтлал”-д тусгасан стратегийн шинж чанартай зорилтууд болох санхүүгийн зуучлалын цар хүрээ болон чанарыг дээшлүүлэх, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн банкны салбарт итгэх итгэлийг хөхүүлэн дэмжих, банк санхүүгийн таатай орчныг бүрдүүлэх, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалах арга замыг боловсронгуй болгох, банк санхүүгийн байгууллагаар дамжуулан хууль бус үйл ажиллагаа явуулах боломжийг хаах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг асуудалд Монголбанк анхаарч ажиллав.

Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг сайжруулах, өсөлтийг дэмжих чиглэлээр Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний үр дүнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын банкны салбарт итгэх итгэл дээшилж, улмаар банкны салбарын үйл ажиллагаа ихээхэн өргөжиж, санхүүгийн зуучлал гүнзгийрч, ашигт ажиллагаа нь сайжирсан.

Хяналт шалгалтын хүрээнд хяналт шалгалтын орчны үнэлгээ хийлгэх, зохистой удирдлагыг сайжруулах, зохистой харьцааны үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох зэргээр хяналт шалгалтын бодлогыг сайжруулах, цаашдын чиг хандлагыг тодорхойлох, улмаар санхүүгийн тогтвортой байдлыг хангахад гол анхаарал хандуулж ажиллалаа.

Аж ахуйн нэгжүүдийн бизнесийн цар хүрээ өргөжиж банкны үйл ажиллагаанаас гадна даатгал, бичил зээл, лизингийн үйлчилгээг давхар эрхлэх болсон нь тухайн бизнес группын санхүүгийн нийт эрсдэлийг зөв тодорхойлох зорилго бүхий нэгдсэн хяналт шалгалтыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран хэрэгжүүлж эхлэх нь зүйтэй гэж үзэж эхний ээлжийн алхмуудыг хэрэгжүүллээ.

Хяналт шалгалтын үндсэн зорилго

Монголбанкны Хяналт шалгалтын газар нь Төв банкны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, Төрийн мөнгөний бодлогын хүрээнд тусгагдсан зорилтуудыг биелүүлэх үндсэн зорилготойгоор үйл ажиллагаа явуулдаг билээ. Улсын Их Хурлаас батлан гаргасан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2007 онд баримтлах үндсэн чиглэлд Хяналт шалгалттай холбоотой дараахь асуудлууд тусгагдсан билээ. Үүнд:

Санхүүгийн байгууллагуудад хяналт шалгалтыг нэгдсэн байдлаар хийж гүйцэтгэх эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлэн банкуудад тавьдаг хяналт шалгалтыг олон улсын жишигт бүрэн нийцүүлнэ. Үүнд:

- Эрсдэлийн удирдлагад чиглэсэн хяналт шалгалтын заавар, журмыг боловсронгуй болгоно.
- Өмчийн болон ашиг сонирхлын хувьд харилцан хамааралтай санхүүгийн байгууллагуудыг нэгдсэн байдлаар хянан шалгах асуудлыг боловсруулж холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- Санхүүгийн мэдээллийн албыг байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлнэ.

Банкны эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. Үүнд:

- Хадгаламжийн даатгалын эрх зүйн үндсийг бүрдүүлэх асуудлыг боловсруулж шийдвэрлүүлнэ.
- Монголбанкны зохистой удирдлагыг боловсронгуй болгох, арилжааны банкуудад тавих хяналтыг сайжруулах, өрсөлдөөн, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих чиглэлээр Төв банкны тухай болон Банкны тухай хуулиудыг боловсронгуй болгох санал боловсруулж шийдвэрлүүлнэ.
- Монголбанк иргэний эрх зүйн харилцаанд оролцох эрх зүйн орчныг бий болгож, ил тод байдлыг хангана.

Хяналт шалгалтын тогтолцоо

Монголбанкнаас банкуудад хяналт шалгалт хийж байгаа өнөөгийн тогтолцоо нь олон улсын банк санхүүгийн байгууллагуудад тавигддаг хяналтын нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, шилдэг туршлагад тулгуурласан, үр ашигтай бүтцээр явагдаж байгаа бөгөөд цаашид боловсронгуй болгох зорилгоор Монголбанкнаас шаардлагатай өөрчлөлтүүдийг хийж ирсэн. Сүүлийн жилүүдэд банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны хүрээ өргөжин, шинэ техник технологи, үйлчилгээ нэвтрэхийн хэрээр банкинд учирч болзошгүй эрсдэлүүд нэмэгдэж байна. Иймээс хяналт шалгалтыг үр дүнтэй явуулахын тулд заавар журмын хэрэгжилтийн хяналтаас эрсдэл дээр тулгуурласан хяналт шалгалтад чиглүүлж, учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, тодорхойлох арга хэрэгслийг боловсруулах, банкинд харилцагчдын

зүгээс тавих хяналтыг дээшлүүлэхэд чиглэгдсэн хяналт шалгалтыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байна. Уг ажлын хүрээнд банкны үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг олон улсын, ялангуяа Базелийн хяналт шалгалтын хорооноос гаргасан стандартад нийцүүлэх ажил тогтмол хийгдэж байна.

1. Банкуудад хийгдэж байгаа хяналт шалгалтын талаар

Тайлант онд газар дээрх шалгалтын хүрээнд банкуудын санхүү, төлбөрийн чадварын байдал, үйл ажиллагаанд Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан шалгалтын удирдамжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа 14 банкинд иж бүрэн шалгалтыг хугацаанд нь хийж гүйцэтгэн, шалгалтын дүнг Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, биелэлтэнд нь хяналт тавин ажиллаж байна. Иж бүрэн шалгалтын хүрээнд шалгалтанд бэлтгэхээс эхлэн банкны санхүү төлбөрийн чадвар, удирдлага зохион байгуулалт, тайлан тэнцлийн бүхий л үзүүлэлтийг хамруулан шалгалт хийх, шалгалтын акт материал бэлтгэх, нэгдсэн танилцуулга хийх, төлбөр зөрчил, хууль тогтоомж зөрчсөн асуудалд улсын байцаагчийн акт тогтоох, банкны удирдлагуудад шалгалтын үр дүнг танилцуулж, зөвшөөрүүлэх арга хэмжээ авлаа. Газар дээрх хяналт шалгалтын явцад 2007 онд дээрх үндсэн үзүүлэлтүүдээс гадна санхүүгийн нэгдлийн хувьд нэгдсэн тайлан тэнцлийг гаргаж, зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тооцох, зохистой удирдлагын зарчмын хэрэгжилтийг шалган, үнэлгээ дүгнэлт өгөх, “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль”-ийн хэрэгжилтийн байдлыг шалгаж, заавар зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг шинээр хийж эхэлсэн. Үүнд давхардсан тоогоор 91 хянан шалгагч нийт 1365 хүн өдрийг банкинд хяналт шалгалт хийхэд зарцуулжээ. Мөн банк хоорондын зээл, хадгаламжийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн шалгалт хийлээ.

Банкинд зайнаас хяналт тавих үйл ажиллагаагаар банкнаас ирүүлсэн мэдээлэл, тэдгээрийн динамик үзүүлэлт болон ашигт ажиллагаа, активын чанарыг илэрхийлэх үзүүлэлтүүдэд үндэслэн санхүү төлбөрийн чадварын байдалд дүгнэлт өгч, холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажиллалаа.

Түүнчлэн шалгалтын явцад банкны үйл ажиллагаанд тавих дотоод, гадаад аудитын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, удирдлагын бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, боловсон хүчний сургалтын системийг сайжруулах зэрэгт онцгой анхаарал тавин ажиллаж байна.

2. Хяналт шалгалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар авсан арга хэмжээ

Хяналт шалгалтын газар нь банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтын хүрээнд банкуудад газар дээр болон зайнаас хяналт шалгалт хийн, холбогдох журам заавруудыг шинэчлэн боловсронгуй болгохын зэрэгцээ тэдгээрийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн, зохистой түвшинд хүргэхийн тулд тодорхой чиглэлүүдээр зөвлөмж, аргачлалуудыг гарган хүргүүлээ. Олон улсын санхүүгийн байгууллага болон хандивлагч

орнуудаас манай орны эдийн засгийн өсөлтийг хангах, нийгмийн шинж чанартай асуудлууд болох орон сууц, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх төслийн хөрөнгийг банкуудаар дамжуулан олгох талаар төрийн холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллан, шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж, төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүрэлдэхүүнд орж ажилласан.

Монголбанкнаас санал болгосны дагуу “Санхүүгийн салбарын үнэлгээний хөтөлбөр”-ийг бүрэн хэмжээгээр Олон улсын валютын сан болон Дэлхийн банк хамтран 2007 онд Монгол улсад анх удаа хэрэгжүүллээ. Энэхүү хөтөлбөр нь Базелийн банкны хяналт шалгалтын хорооноос батлан гаргасан “Базелийн банкны үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчим”-д үндэслэн санхүүгийн салбарын өнөөгийн байдал болон хууль эрх зүйн орчны талаар үнэлгээ өгч, ололттой болон дутагдалтай талуудыг танин мэдэж, олон улсын түвшинд хүрэхэд цаашид хийх шаардлагатай ажлын талаар зөвлөгөө өгөх зорилготой юм. “Санхүүгийн салбарын үнэлгээний хөтөлбөр”-ийн урьдчилсан тайлангаас үзвэл Монгол улстай нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувьд ойролцоо түвшний улс орнуудтай харьцуулахад манай улсын санхүүгийн салбар харьцангуй сайн үнэлгээтэй байна.

Хяналт шалгалтын газар нь олон улсын стандарт, зааврыг дагаж мөрдөхөөс гадна тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр холбогдох хууль, журамд тусгаж байдаг. Базелийн хорооноос батлан гаргасан өөрийн хөрөнгийн стандарт шинэчлэгдсэн, Монгол улсад ипотекийн зах зээл үүсч бий болсонтой холбоотойгоор “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох, түүнд хяналт тавих журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 10-р сарын 30-ны өдрийн 491 тоот тушаалаар шинэчлэн баталсан. Үүнд банкны зах зээлийн эрсдэлийн удирдлагад тавигдах шаардлагыг олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох, өөрийн хөрөнгийн тооцоог илүү оновчтой болгох, орон сууцны урт хугацаатай зээлийн хоёрдогч зах зээлийг дэмжих бодлогын хүрээнд Монголын ипотекийн корпорацийн гаргасан үнэт цаасны өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг тооцох эрсдэлийн жинг бууруулсан зэрэг өөрчлөлтүүд орсон.

Банкны хяналт шалгалтын үндсэн зорилго нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, харилцагчдын хөрөнгийг хамгаалах явдал юм. “Хадгаламжийн даатгал”-ын хуулийн төслийг 2005 онд харилцагчдын хөрөнгийг хамгаалах зорилготой Сангийн яам, ХЗДХЯамтай хамтран боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжигдсэн бөгөөд төсөл УИХ-ын хурал дээр хэлэлцэгдэж эхлээд байна.

Монголбанкнаас Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-тай хамтран банкуудтай мэдээлэл солилцох явцыг боловсронгуй болгох, хянан шалгагч нарын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн зохистой байдлыг хангах замаар банкны хяналт шалгалтыг сайжруулах зорилготой Удирдлагын мэдээллийн системийн төслийг 2007 оноос хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү төсөл хэрэгжсэнээр банкуудтай мэдээлэл солилцох явц бүрэн автоматжих юм. Мөн уг төслийн хүрээнд мэдээллийн технологийн хяналт шалгалтын тогтолцоог бий болгох, банкны зохистой удирдлагыг сайжруулах ажлууд хийгдэж байна.

“Санхүүгийн тогтвортой байдлын асуудлыг хариуцсан зөвлөл”-ийг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын бүрэлдэхүүнтэйгээр 2007 онд байгуулсан. Зөвлөл нь санхүүгийн салбарын эрүүл, тогтвортой байдлыг магадлан хянах зорилготой юм.

Тайлант онд Хяналт шалгалтын газраас дараахь журам, заавар, судалгааг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- 2006 оны 12 дугаар сард батлагдсан “Банкны зохистой удирдлагын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг байнга хянаж, банкуудад заавар, зөвлөгөө өгч ажиллаж байна.
- CAMELS-ийн үнэлгээний эрсдэл тооцоох хувийн жингийн үзүүлэлтүүдийг эконометрик загваруудыг ашиглан судалгаа хийсэн. Үр дүнг холбогдох заавар, журамд тусгах ажил хийгдэж байна.
- Банкуудын том зээлдэгч нарын талаар болон тэдгээрийн санхүү, төлбөрийн чадварт судалгаа хийн улирлын тайланд тусган харуулж байна.

Удирдлага зохион байгуулалт

Төв банк нь удирдлага, 6 газар, 2 бие даасан алба, 9 хэлтсийн харьяаллын алба, 1 тусгай тасаг, 1 төлбөр тооцооны төв, орон нутаг дахь Монголбанкны 17 салбар, Лондон дахь төлөөлөгчийн газар бүхий бүтэц зохион байгуулалтаар үйл ажиллагаа явуулж байна.

Монголбанкинд хүүхэд асрах болон жирэмсний чөлөөтэй ажилтныг оролцуулаад нийт 317 ажилтан ажиллаж байгаагийн 49.5 хувь нь эмэгтэй, 50.5 хувь нь эрэгтэй ажилтан байна. Нийт ажилтнуудын 71 хувь нь Төв аппаратад ажиллаж байна.

Тайлант онд гадаад, дотоодын сургалтанд 96 ажилтан 89 удаагийн сургууль, курс семинарт хамрагдсанаас шинээр байгуулагдсан Санхүүгийн мэдээллийн алба, Эрсдэлийн удирдлагын алба, мөнгөний бодлого, хяналт шалгалт, бүртгэлийн чиглэлийн сургалтанд ажилтнуудыг түлхүү хамруулах бодлого баримталж хуулийн хэлтсээс 3 ажилтан 4 удаа, Эрсдэлийн удирдлагын албаны 5 ажилтан 7 удаа, Санхүүгийн мэдээллийн албаны 2 ажилтан 6 удаа, МБСГ-ын 10 ажилтан 13 удаа, ХШГ-ын 17 ажилтан 21 удаа, БТМТГ-ын 17 ажилтан 12 удаагийн семинарт тус тус оролцсоноос гадна орон нутаг дахь Монголбанкны салбарын 17 удирдах ажилтныг ХБНГУ-д мэргэжил дээшлүүлэх сургалтанд суралцууллаа. Мөн удирдах болон бусад ажилтнууд гадаад дотоодын нийт 26 хурал уулзалт, зөвлөгөөнд оролцсон.

Өмнө нь Монголбанкинд ажиллаж байсан 5 ажилтан гадаад, дотоодын байгууллагад ажиллаж байгаад буцаж ирж ажилд томилогдсон.

Австрали, Япон улсуудад 6 ажилтан удаан хугацааны сургалтанд суралцаж сургуулиа амжилттай төгсөж ажилдаа эргэж томилогдсоноор Монголбанкны хэмжээгээр 1 доктор, докторын зэрэг горилон суралцаж буй 5, 56 магистрын зэрэгтэй ажилтнууд ажиллаж байна.

Ажилтнуудын мэргэжил, мэдлэгийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн түвшинд хүргэх, сурч боловсрох эрхийг хангаж олон улсын байгууллага, өндөр хөгжилтэй орнуудын Засгийн газрын шугамаар зохион байгуулагдаж байгаа сургалтанд хамруулахыг дэмжиж ажилласнаар Монголбанкттай сургалтын гэрээ байгуулсны үндсэн дээр 21 мэргэжилтэн АНУ, Австрали, Япон зэрэг орнуудад суралцаж байна.

Нийт ажиллагсдын 76 хувь нь банк, санхүүгийн нарийн мэргэжлийн инженер, эдийн засагч мэргэжилтэй мэргэжлийн боловсон хүчин байгаа бол үйлчилгээний албан тушаалтнуудын 38 орчим хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна. Тайлант онд бүх ажилтнуудыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж, Төрийн албаны хууль, холбогдох бусад эрхийн акт, журам зааврын дагуу ажилтнуудад эмчилгээний нөхөн олговор, буцалтгүй тусламж зэрэгт Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 15 гаруй сая төгрөгийг зарцуулсан нь ажилтнуудыг эрүүл саруул байлгах, амьдрал ахуйг дэмжиж тэтгэхэд чухал ач холбогдолтой боллоо.

Монголбанкны ахмад настанд хүндэтгэл үзүүлэх, нэмэгдэл тэтгэвэр тэтгэмж олгох тухай журмын дагуу ахмадуудад 2 удаа хүндэтгэл үзүүлсэн.

Эрсдэлийн удирдлага

Монголбанк нь өөрийн үйл ажиллагааны үндсэн зорилготойгоо уялдуулсан эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогыг боловсруулах зорилт тавин ажиллаж байна.

Монголбанкыг эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогоор хангах, ялангуяа Монголбанкны үйл ажиллагаанд учирч болзошгүй санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлон тогтоож, хяналт тавих үүрэг бүхий Эрсдэлийн удирдлагын албыг 2007 оны 1 дүгээр сард байгуулав. Өнгөрсөн хугацаанд тус албанаас улсын гадаад валютын нөөцийн удирдлага болон гадаад валютын үйл ажиллагаатай холбоотой эрсдэлүүдийг тодорхойлох, түүнээс сэргийлэхэд голлон анхаарч ажилласан.

Эрсдэлийн удирдлагын албанаас улсын гадаад валютын нөөцийн удирдлагын зорилготой нийцүүлэн нэн тэргүүн ээлжинд найдвартай байдлыг хангах, нөөцийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах, үр өгөөжийг нэмэгдүүлэх гэсэн зарчмын хүрээнд гадаад валютын нөөцийн урт хугацаанд баримтлах ерөнхий чиглэлийг тодорхойлов. Ерөнхий чиглэлд эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшинд гадаад валютын нөөцийн активын бүтэц, гадаад валютын бүтэц, урт хугацаат хөрөнгө оруулалтын зохистой хугацаа, багцын бүтэц, хөрөнгө оруулалтын боломжит хэрэгслүүдийг тус тус тодорхойлж өгөв. Мөн урт хугацаат хөрөнгө оруулалтын багцыг байгууллагын эрсдэл хүлээх боломжинд тохирсон хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийг хамарсан, хөрвөх чадвар сайтай, ойлгоход хялбар, дахин нягтлах боломжоор хангагдсан жишиг багцтай уялдуулан хэрэгжүүлж байна.

ХБНГУ-ын Бундесбанкны мэргэжилтнүүдтэй хамтран хөрөнгө оруулалтуудын зах зээлийн үнэлгээг хийх, гадаад валютын нөөцийн зах зээлийн эрсдэл, зээлийн эрсдэл зэргийг өдөр тутам тооцож хяналт тавих ажлыг тус тус эхлүүлэн тогтмолжуулаад байна.

Дотоод аудит

Монголбанкны Дотоод аудитын газраас 2007-2011 онд хийх аудитын урт хугацааны төлөвлөгөө, 2007 оны ажлын төлөвлөгөөний дагуу Монголбанкны газар, хэлтэс албад, орон нутаг дахь салбар нэгжүүдэд Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд явуулж буй эсэхэд хяналт тавьж, шалгалт хийн, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, арилгах, илэрсэн зөрчил дутагдлын мөрөөр холбогдох арга хэмжээ авах талаар шийдвэр гаргуулах, санал зөвлөмж болон үүрэг даалгавар өгөх зэргээр ажиллалаа.

Тайлант онд төв, орон нутгийн газар, хэлтэс, алба, салбар нэгжид бүрэн болон хэсэгчилсэн байдлаар шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээг цаг тухай бүр авч, хэрэгжилтэнд нь хяналт тавьж

ирлээ. Шалгалтыг эрсдэл ихтэй, эрсдэл үүсч болзошгүй талбарт чиглүүлэн явуулав.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа

Терроризмтэй тэмцэх зорилгоор улс орнууд банк санхүүгийн байгууллагуудын оролцоог ихээхэн нэмэгдүүлж, түүнтэй нийцсэн тогтоол, зөвлөмж, конвенцүүдийг гаргаж байгаа билээ. Терроризмын санхүүжилтийг илрүүлж, түүний урсгалыг хаах замаар терроризмтэй тэмцэхэд илүү үр дүнд хүрнэ гэж улс орнууд үзэж байна. Манай улс 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-тай болсноор дэлхийн улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл хэрэгт нэгдэн орох эхлэлд бодит алхам боллоо. Энэхүү хуулиар банк, санхүүгийн байгууллагууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, дотоод бодлого, журамтай болж, сэжигтэй гэж үзсэн гүйлгээ, дансны талаар мэдээлэх үүргийг хүлээсэн. Үүний дагуу тухайн хуулийг хэрэгжүүлэх төв байгууллага болох Санхүүгийн мэдээллийн албыг Монголбанкны бүтцэд байгуулсан бөгөөд хуулиар түүний үйл ажиллагааг тодорхойлсон.

Санхүүгийн мэдээллийн алба нь банк болон банк бус санхүүгийн байгууллагуудаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй гүйлгээний тухай мэдээллийг хүлээн авч тэдгээрт дүн шинжилгээ хийх бөгөөд гэмт хэргийн шинжтэй мэдээллийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж шалгуулах үндсэн үүрэгтэй байгууллага бөгөөд Монголбанкинд тусгай статус, чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Тухайн алба 2006 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Монголбанкны бүтцэд албан ёсоор байгуулагдсан. Тус алба 2007 оны турш мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монголбанкны бодлого, холбогдох заавар, журмыг боловсруулахад түлхүү анхаарч ажилласан бөгөөд мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ, мэдээлэл хүлээн авах, дамжуулах үйл явцыг түргэн шуурхай болгож дотоод, гадаадын эрх бүхий хууль хяналтын байгууллагатай хамтын ажиллагааг өрнүүлэхэд чухал ач холбогдол өгч байна.

Санхүүгийн мэдээллийн алба 2007 онд арилжааны банкууд, тэдгээрийн ажилтнуудад зориулж хэд хэдэн сургалт, сурталчилгааны ажлыг хийсэн бөгөөд өөрсдийн ажилтнуудын ч мэдлэг боловсролыг дээшлүүлэх үүднээс багагүй хөрөнгө оруулалт хийлээ.

Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Ази номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг зэрэг олон улсын байгууллагуудаас техник туслалцааг өргөн хүрээтэй авч ашиглаж байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон санхүүгийн луйвар, залилан мэхлэх гэмт хэргийн арга хэлбэр, типологийн талаар судалгаа хийж банкуудад мэдээлэх, анхааруулж сэрэмжлүүлэх ажлыг тогтмол зохиож ирлээ.

2006 оны 12 дугаар сард Ази номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (APG)-ээс Монгол улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй хэрхэн тэмцэж байгааг үнэлэх зорилгоор олон улсын шинжээчид Монгол улсад

хүрэлцэн ирж тухайн салбарын талаар дэлгэрэнгүй тайлан бичсэн. 2007 оны 7 дугаар сард Ази номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн жилийн хурлаар шинжээчдийн хийсэн дээрх үнэлгээний тайланг гишүүн орнууд хэлэлцэж баталсан байна. Тайланг APG –гийн олон нийтэд нээлттэй цахим хуудас (www.apgml.org) дээр байрлуулсан бөгөөд сонирхсон хүмүүс үзэж болно.

Төлбөр тооцооны системийн хөгжлийн зорилт, түүний хэрэгжилт, бүртгэлээр тавих хяналт

Бэлэн бус төлбөр тооцоо

Банкууд картын хэрэглээг ихэд дэмжиж худалдааны цэгүүдэд ПОС терминал буюу карт уншигч машиныг үнэ төлбөргүйгээр суурилуулж байна. Мөн бэлэн мөнгөний хэрэглээг багасгах зорилгоор банкууд өөрийн салбар нэгжүүдэд ПОС терминалыг суурилуулан, түүгээр дамжуулан харилцагчдын төлбөр тооцоо, ялангуяа орон сууц, нийтийн үйлчилгээний байгууллагуудын төлбөр тооцоог гүйцэтгэдэг. Шинээр гаргасан картын тоо болон картаар хийх гүйлгээний тоо өсч байна. Тайлант онд карт эзэмшигчдийн тоо 538.9 мянгад хүрч, нийт 4.4 сая удаагийн 651.5 тэрбум төгрөгийн картын гүйлгээ хийгджээ.

Тайлант оны эцсээр картын хоёр сүлжээ ажиллаж байгаа бөгөөд банкууд тэдгээрээр дамжуулан картын төлбөрийг хүлээн авч байна. Цаашид төлбөр тооцоог сүлжээний харьяаллыг харгалзахгүйгээр гүйцэтгэх, төлбөрийн карт гаргах, хүлээн авах, боловсруулах үйл ажиллагааг жигдрүүлэх зорилгоор Монголбанкнаас картын нэгдсэн сүлжээ байгуулахыг зорин ажиллаж байна.

Төв банк их дүнтэй банк хоорондын төлбөр тооцооны системийг бодит цагийн горимд шилжүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Ингэснээр төлбөрийн системийн эрсдэлийг удирдах, санхүүгийн зах зээлийг дэмжих, мөнгөний бодлогын хэрэгжилт сайжрах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг банкуудад олгоно. Түүнчлэн ирээдүйд гадаад валютын болон үнэт цаасны төлбөр тооцоог гүйцэтгэх шинэ системийг олон улсын стандартын дагуу бодит цагийн горимоор хөгжүүлэх дэд бүтэц буй болно.

Банк хоорондын төлбөр тооцоо

Манай улсын эдийн засаг өргөжин тэлэхийн хэрээр банк хоорондын тооцоогоор дамжин хийгдэх гүйлгээ нэмэгдсээр байна. Банк хоорондын тооцоонд оролцож буй нийт төлбөрийн дүн ба ДНБ-ий харьцаа 2007 онд 4.3 болж өмнөх оноос өсчээ. Энэ нь иргэд, байгууллагын банкинд итгэх итгэл улам сайжирч, банкаар хийгдсэн бэлэн бус гүйлгээ эрс нэмэгдэж буйг илтгэж байна.

Банк хоорондын гүйлгээ 2 ба 4 дүгээр улирлуудад хамгийн их хийгддэг бөгөөд энэ нь оны төгсгөлд оны хаалтын тооцооны гүйлгээнүүд хийгддэг болон 2 дугаар улиралд цаг агаар дулаарч барилга болон уул уурхайн салбарууд идэвхжиж иргэд, албан байгууллагуудын банкуудаар дамжуулах гүйлгээ

нэмэгддэгтэй холбоотой юм. Харин хамгийн бага гүйлгээг 1 дүгээр улиралд хийж байгаа нь оны эхээр гүйлгээнүүд харьцангуй бага, төсвийн санхүүжилт дөнгөж хийгдэж эхэлдэгтэй холбоотой юм.

Хүснэгт 3.1. Банк хоорондын гүйлгээний тоо, улирлаар, мянган ширхэгээр

	2002	2003	2004	2005	2006	2007
1 улирал	222.2	406.4	586.3	620.2	689.7	758.7
өсөлт (%)	22.9	82.9	44.3	5.8	11.2	10
2 улирал	287.1	611.7	793.5	797.5	851.5	968.3
өсөлт (%)	25.6	113.1	29.7	0.5	6.8	13.7
3 улирал	295.6	561.9	617.3	541.6	762.8	829.1
өсөлт (%)	56.9	90.1	9.9	-12.3	40.8	8.7
4 улирал	405.9	636.8	727.1	391	910.6	1098.5
өсөлт (%)	68.3	56.9	14.2	-46.2	132.9	20.6
Бүгд	1210.8	2216.8	2724.2	2350.3	3214.6	3654.6
өсөлт (%)	44.3	83.1	22.9	-13.7	36.8	13.7

Сараар авч үзвэл, 1, 2, 7, 11 дүгээр саруудад гүйлгээний тоо болон гүйлгээний дүн буурч байгаа бол бусад саруудад өссөн байна. Гүйлгээ буурч байгаа саруудын ажлын хоног бусад саруудаас бага байсантай холбоотой байв.

Банк хоорондын төлбөр тооцоонд оролцогчдын төлбөрийн системийг шинэчлэх, сайжруулах зорилгоор 2006 оны 2 дугаар сарын 1-ний өдөр Монголбанк өөрийн Төлбөр тооцооны төвийг ашиглалтанд оруулсан. Банк хоорондын их дүнтэй гүйлгээ болон банк хоорондын бага дүнтэй гүйлгээний дүнгийн хязгаарыг нэг сая төгрөгөөр тогтоосон бөгөөд 2007 онд банк хооронд нийт 3.7 сая удаагийн гүйлгээгээр 14.3 их наяд төгрөгийн гүйлгээ хийгджээ. Үүний 401.9 тэрбум төгрөг буюу 2.8 хувь нь бага дүнтэй гүйлгээ, 13.9 их наяд төгрөг буюу 97.2 хувь нь банк хоорондын их дүнтэй гүйлгээ байв. Харин бага дүнтэй гүйлгээ гүйлгээний тоогоор нийт гүйлгээний тоонд дийлэнх буюу 83.0 хувийг эзэлж байна.

Тайлант онд бага дүнтэй нэг гүйлгээний дүн 120-150 мянган төгрөгийн хооронд, их дүнтэй нэг гүйлгээний дүн 20-25 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байв.

Хүснэгт 3.2. Банк хоорондын гүйлгээний дүн, улирлаар / тэрбум төг./

	2002	2003	2004	2005	2006	2007
1 улирал	471.5	850.2	1,086.4	1,481.8	1,787.6	2,358.7
өсөлт (%)	13.9	80.3	27.8	36.4	20.6	31.9
2 улирал	582.0	1,000.4	1,429.3	1,809.4	2,742.8	3,421.2
өсөлт (%)	33.2	71.9	42.9	26.6	51.6	24.7
3 улирал	718.2	986.8	1,400.2	2,057.2	2,145.7	3,312.1
өсөлт (%)	45.1	37.4	41.9	46.9	4.3	54.3
4 улирал	972.3	1,249.5	1,746.3	2,222.7	2,847.4	5,230.1
өсөлт (%)	81.6	28.5	39.8	27.3	28.1	83.7
Бүгд	2,744.0	4,087.0	5,662.1	7,571.1	9,523.5	14,322.2
өсөлт (%)	45.9	48.9	38.5	33.7	25.8	50.4

Банк хоорондын гүйлгээний дүнгийн хамгийн их буюу 29.3 хувийг Төрийн сан, 14.1 хувийг Худалдаа хөгжлийн банк, 13.7 хувийг ХААН банк, 11.6 хувийг Голомт банк, 5.4 хувийг Улаанбаатар хотын банк, 4.8 хувийг Хадгаламжийн банк, 4.4 хувийг Анод банк, 4.3 хувийг Монгол Шуудан банк, 12.4 хувийг бусад банк эзэлж байна. Үүнийг өмнөх онтой харьцуулж үзвэл Худалдаа хөгжлийн банкных 0.5 нэгж, Улаанбаатар хотын банкных 1.9 нэгж, Хадгаламжийн банкных 1.7 нэгж, Монгол Шуудан банкных 0.7 нэгж, бусад банкуудынх 0.2 нэгжээр тус тус буурсан байхад Төрийн сангийнх 4.7 нэгж, ХААН банкных 0.2 нэгж, Голомт банкных 0.1 нэгжээр тус тус нэмэгдсэн байна.

Мэдээллийн технологи

Монголбанкны Мэдээллийн технологийн газраас мэдээллийн технологийн ололтыг түлхүү нэвтрүүлэн банк хоорондын төлбөр тооцооны системийг хөгжүүлэх, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг дээшлүүлэх, мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгон үр дүнд нь зардал, цаг хэмнэхийн төлөө ажиллаж байна.


Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн Монголбанкны гадаад, дотоод төлбөр тооцоог үнэн зөв, түргэн шуурхай гүйцэтгэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, банк хоорондын төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах зорилгоор Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн системд шаардлагатай нэмэлт өөрчлөлт, програм, модулиудыг хийж байна.

Олон улсын төлбөр тооцооны СВИФТ системийн техник технологийн өөрчлөлт хийх төлөвлөгөөний хүрээнд “Бүтцийн шинэчлэлт” гэсэн гол ажлыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэн, програм хангамжийн шинэ хувилбарууд, нууцлалын шинэ төхөөрөмжийг суурилуулж нэвтрүүллээ. СВИФТ-ийн бүсийн зохицуулагчийн технологийн үзүүлэх сургалтыг Монголын банкуудыг хамруулан зохион байгуулав. Сургалтанд нийт 15 банкны 32 ажилтан оролцов.




Зураг 3.1.

Банк
хоорондын
төлбөр
тооцоо, ДНБ



Зураг 3.2.

Банк
хоорондын
гүйлгээний
тоо, сараар




Зураг 3.3.

Банк
хоорондын
гүйлгээний тоо,
их болон бага
дүнгээр

Зураг 3.4.

Банк
хоорондын
гүйлгээний
дүн, сараар




Зураг 3.5.


Нэг гүйлгээний
дундаж
гүйлгээний
дүн, 2007 он,
сараар



Зураг 3.6.


Банк
хоорондын
гүйлгээний дүн,
их болон бага
дүнтэйгээр






Зураг 3.7.

Банкуудын гүйлгээний дүн



Зураг 3.8.

2006-2007 оны банк хоорондын гүйлгээний дүнд банкуудын эзлэх хувь



Төв банкны хэрэгжүүлж буй бодлого, үндсэн чиг үүргийн талаархи мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, түргэн шуурхай хүргэж байх зорилгоор Монголбанкны вэб хуудсанд зохих нэмэлт өөрчлөлтүүдийг хийв.

Монголбанкны дотоод үйл ажиллагааг шуурхай, боловсронгуй болгох ажлын хүрээнд Монголбанкт хамтын ажиллагаатай олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын талаархи мэдээ мэдээллийн систем, Монголбанкны удирдлагын мэдээллийн систем, Монголбанкны номын сангийн, цаг бүртгэлийн, хүний нөөцийн гэх зэрэг онлайн горимд вэб хандалтаар ажиллах програм хангамжуудыг боловсруулан ашиглалтад оруулав.

Хууль зүйн орчин

2007 онд УИХ-аас баталсан “Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хууль”-аар тус сангийн хөрөнгийг Монголбанк дахь тусгай дансанд байршуулан хөрөнгийн үлдэгдэлд хүү төлөх бөгөөд энэ хүүний хэмжээг Засгийн газар, Монголбанкны хоорондын гэрээгээр зохицуулж байх болжээ.

“Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”- шинээр батлагдаж, төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, тухайлбал, санхүүгийн талаар дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд тэдгээрийн санхүүгийн эх үүсвэрийн тогтвортой байдал хангагдах боломж бүрдэж байна.

Энэ үүднээс санхүүгийн байгууллагын чиг үүргийг тодорхой болгох, банк болон банк бус санхүүгийн байгууллагатай тохирсны үндсэн дээр жижиг, дунд үйлдвэрт зориулсан санхүүжилтийг бий болгох, урт хугацааны, хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн баталгаа гаргах, гадаадын болон олон улсын байгууллагын санхүүжилт бүхий төсөл, тусламжийн арга хэмжээнд хамруулах зэрэг арга хэмжээг авахаар тусгажээ.

Гадаад хамтын ажиллагаа

Монголбанк Монгол улсын зээлжих зэрэглэлийг ахиулан бататгах талаар 2007 онд идэвхтэй ажиллалаа.

Олон улсын зэрэглэл тогтоогч байгууллага Стандарт энд Пүүрс (Standard & Poor's) 2007 оны 12 дугаар сард Монгол Улсын гадаад болон дотоод валютын урт хугацааны зээлжих зэрэглэлийг “В+” байсныг “ВВ-” болгон ахиулж “тогтвортой” гэсэн дүгнэлт өгсөн байна. Мөн дэлхийд нэр хүнд бүхий зэрэглэл тогтоогч байгууллага болох Фич компани Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “В+ тогтвортой” гэж байсныг “В+ эерэг” болгон сайжруулж, богино хугацааны зээлжих зэрэглэлийг “В”-ээр, дээд хязгаарыг “В+” –ээр тогтоосон.

Монгол улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд инфляциас бусад нь эерэг байсан нь зэрэглэл сайжрахад гол нөлөө үзүүлжээ. Гадаадад ажил эрхэлж буй ажилчдын урсгал шилжүүлэг болон гадаад худалдаа ашигтай гарсны үр дүнд энэ жил төлбөрийн тэнцлийн урсгал дансны ашиг ДНБ-ий 7 хувьтай гарсан.

Түүнчлэн Монгол улсыг түүхэндээ анх удаа гадаад зээлдүүлэгч (цэврээр) боллоо гэж Фич үнэлсэн байна.

Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд зэрэглэл тогтоолгосноор гадаад зах зээлд гарах үүд хаалгыг нээж өгдөг билээ. Үндэсний томоохон аж ахуйн нэгж, байгууллагууд зэрэглэлээ тогтоолгон, гадаад зах зээлээс санхүүгийн хямд эх үүсвэр татах ажлыг эхлүүлээд байна.

Монгол улс болон БНХАУ-ын хооронд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үүднээс хоёр улсын банкуудын найдвартай, шуурхай төлбөр тооцооны системийг бий болгох зорилгоор банкуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх тухай Монголбанк, БНХАУ-ын Ардын банк /Төв банк/ хооронд төлбөр тооцооны гэрээг 2004 онд байгуулсан ба энэхүү гэрээний хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэн, цаашдын шийдвэрлэх асуудлыг тодорхойлох зорилгоор “Монгол Хятадын хил худалдааны төлбөр тооцооны банк хоорондын дугуй ширээний уулзалт”-ыг жил бүр хоёр улсад ээлжлэн зохион байгуулдаг билээ.

Монгол улс болон БНХАУ-ын банк хоорондын 3 дахь удаагийн зөвлөлдөх уулзалтаар Монголбанк Хятадын Ардын банктай хамтран Монголын арилжааны банкуудад зориулан “Хятадын төлбөр тооцооны тогтолцоо” сэдэвт сургалтыг БНХАУ-ын Бээжин хотод 2007 оны 4 дүгээр сард Хятадын Ардын банкны Мэргэжил дээшлүүлэх дээд сургуулийн сургалтын төвд зохион байгуулсан.

Монгол улс болон БНХАУ-ын банкуудын 4 дэх удаагийн уулзалт 2007 оны 12 дугаар сард БНХАУ-ын Хайнан мужид зохиогдлоо. Уулзалтаар хоёр орны төв банкуудын хамтын ажиллагаа болон хил худалдааны төлбөр тооцооны асуудлын талаар хэлэлцлээ.

Монгол улс болон БНХАУ-ын хооронд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих зорилгоор хоёр улсын банкуудын хооронд хэрэгжиж байгаа “Хил худалдааны төлбөр тооцооны гэрээ” амжилттай хэрэгжиж байгааг хоёр тал харилцан санал нэгтэй дүгнэсэн. Сүүлийн жилүүдэд хоёр талын төлбөр тооцооны гүйлгээний тоо болон мөнгөн дүн эрс нэмэгдэж, төлбөр тооцоонд гарч байсан зузаатгал, картын хэрэглээ болон бусад саад бэрхшээлтэй асуудлуудыг амжилттай шийдвэрлэж эхэлсэн зэргээс дээрхи дүгнэлтийг хийсэн.

Зүүн өмнөд Азийн Төв банкуудын Холбоо (ЗӨАТБХ)-ны Ерөнхийлөгч нарын “Ази бүс нутгийн валютын ханш, хөрөнгийн урсгалын зохицуулалт” гэсэн сэдэвт 42 дахь бага хурал болон ЗӨАТБХ-ны Ерөнхийлөгч нарын Зөвлөлийн 24 дэх уулзалт Тайландын Бангкок хотноо 2007 оны 7 дугаар сард зохион байгуулагдав. Энэхүү бага хурал, уулзалтанд ЗӨАТБХ-ын гишүүн 16 банк, ажиглагч төв банкууд, Олон улсын валютын сангийн удирдах захирал болон гүйцэтгэх захирлууд, Олон улсын төлбөр тооцооны банкны орлогч захирал нар оролцлоо.

Ихэнх гишүүн орнууд хөрөнгийн хил дамжсан урсгал эдийн засагт зохих үр ашгаа өгч байгааг болон түүнтэй зэрэгцээд санхүүгийн даяаршил нь эрсдэлийг асар өндөр болгож байгааг Төв банкны Ерөнхийлөгч нар бага

хурлын үеэр тэмдэглэв. Хөрөнгө оруулагчдын эрсдэлд амтших үйл явц, худалдааны шинж чанартай хөрөнгө оруулалтын өсөлт нь ойрын болон дунд хугацаанд санхүүгийн даяаршсан зах зээл дээр цочмог өөрчлөлтүүд авчирч болзошгүй байгааг тэд илэрхийлжээ. Хөрөнгийн урсгалын өсөлтөөс үүдэн макро эдийн засгийн тэнцвэргүй байдал бий болохоос сэргийлэхийн тулд гадаад валютын интервенцийн зохистой стратеги баримтлах хэрэгтэй гэж Бага хурлаас үзлээ.

Дэлхийн эдийн засгийн ирээдүйн төлөв байдлын тухайд, даяаршсан эдийн засаг 2007, 2008 онд хурдацтай өссөөр байх бөгөөд үүнд Хятад, Энэтхэг, Орос зэрэг улсуудын зах зээлийн өсөлт, еврогийн бүс нутаг, Японы эдийн засгийн өсөлт гол хувь нэмэр оруулна гэж Ерөнхийлөгч нар тэмдэглэв. Гэвч дэлхий дахины эдийн засгийн өсөлт нь өөрийн эрсдэлийг дагуулж болохыг тухайлбал нэгдүгээрт, газрын тосны нийлүүлэлтийн хязгаарлалт үнийн өсөлтөөс шалтгаалсан инфляцийн дарамт, хоёрдугаарт, хэрэв орон сууцны зах зээл цаашид муудах тохиолдолд АНУ-ын өсөлт багасах, гуравдугаарт, шинэ тулгар зах зээлд орох багцын хөрөнгө оруулалт, худалдааны санхүүжилтийн өсөлтөөс шалтгаалсан санхүүгийн тогтворгүй байдлаар илэрч болзошгүй гэж онцолсон юм.

Монголбанк, ЗӨАТБХ-той хамтран “Тэнцлийн аргачлалыг макро эдийн засгийн үнэлгээ, шинжилгээнд хэрэглэх арга нэвтрүүлэх нь” сэдэвт олон улсын семинарыг Улаанбаатар хотноо 2007 оны 7 дугаар сард зохион байгуулсан. Сургалтанд ОУВС, Европын Төв банк, ЗӨАТБХ-ны гишүүн орнуудын Төв банкны төлөөлөгчид оролцлоо.

Монгол улсын эдийн засгийн төлөв байдал, банк болон санхүүгийн зах зээлийг гадаадын бизнесийн орчинд таниулж сурталчлах, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор сэтгүүлд мэдээлэл, нийтлэлийг өргөн хэвлүүллээ.

Улсын зээлжих зэрэглэлийг ахиулан бататгах ажлыг Монголбанк зохион байгуулснаар нэг үе буурах төлөвтэй байсан зэрэглэл тогтоогч байгууллагуудын сонирхлыг сэргээлээ.

Банкны сургалтын төвийн үйл ажиллагаа

Банкны сургалтын төв нь 2007 онд өөрийн гол үүрэг болох сургалт семинарыг төлөвлөгөөний дагуу тогтмол явуулж ирсэн ба сургалт семинарыг чанартай, үр өгөөжтэй зохион байгуулахад гол анхаарлаа хандуулан ажиллалаа. Энэ онд дотоод, гадаад сургалт семинарт давхардсан тоогоор нийт 912 хүн хамрагдан оролцсон байна.

Банкны сургалтын төв нь энэ онд 30 сэдэв бүхий 41 удаагийн дотоод, гадаад сургалт семинарыг зохион байгуулахаар төлөвлөснөөс тайлангийн хугацаанд 33 сэдвээр 51 удаагийн сургалт семинар зохион байгууллаа. Банкны сургалтын төв нь 2007 онд өмнөө тавьсан зорилтоо амжилттай биелүүлэв.

Банкны сургалтын төвөөс сургалт семинарын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд сургалт семинарын үргэлжлэх хугацааг сунган зохион байгуулахыг хичээн ажилласны дүнд нийт 3368 хүн/өдрийн сургалт

семинарыг зохион байгуулсан нь өмнөх оныхоос 18.8 хувь буюу 541.5 хүн/өдрөөр нэмэгдсэн байна.

Банкны сургалтын төвөөс дотоодод зохион байгуулсан сургалт

Банкны сургалтын төв нь арилжааны банкуудын ажилтнуудын эрэлт, хэрэгцээ шаардлагыг хангахуйц сургалт семинарыг зохион байгуулахын тулд оны эхэнд арилжааны банкуудаас санал авч 2007 оны сургалтын төлөвлөгөөг хамтран боловсруулж, уг төлөвлөгөөний дагуу сургалт семинарыг зохион байгуулав. Банкуудын хүний нөөцийн болон сургалтын менежерүүдтэй хамтран ажилласан нь сургалтын чанар, өгөөжийг дээшлүүлэх гол хүчин зүйл болсон байна. Банкны сургалтын төв энэ онд 32 сэдэв бүхий 45 удаагийн /2977.5 хүн/өдөр/ сургалт семинарыг дотооддоо зохион байгуулж, нийт 841 хүнийг хамруулжээ.

Төвийн бүсийн аймгуудын банкны ажилтнуудад зориулсан “Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх” 6 өдрийн сургалтыг Орхон аймагт зохион байгуулж, 5 аймгийн 23 банкны ажилтныг хамруулав. Мөн Дархан-Уул, Завхан, Орхон зэрэг аймгуудад зээлийн ажилтнуудад зориулсан сургалтуудыг бие даан зохион байгууллаа.

Сургагч багшаар 2007 онд 14 хүнийг дотооддоо бэлтгэж, тэдгээрийн ур чадварыг дээшлүүлэх, гадаад орнуудын сургалтын байгууллагын үйл ажиллагаатай танилцуулж туршлагаас нь суралцуулах зорилгоор ХБНГУ-д сургалт аяллыг зохион байгуулав.

Тайлант хугацаанд шинээр Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, Мортгеж, Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүд, Салбарын удирдлага, Залуу удирдах ажилтныг хөгжүүлэх сургалт, Шинээр бизнес эрхлэгчдийн санхүүжүүлэлт сэдэвт сургалтуудыг зохион байгууллаа.

Гадаад түнш байгууллагуудын туслалцаа дэмжлэгээр Ирланд, Герман, Люксембург, Бельги зэрэг орнуудаас банкны мэргэжилтнүүдийг урин ирүүлж 25 удаагийн сургалт семинарыг зохион байгуулсан нь арилжааны банкуудын хувьд ажилтнуудаа гадаадад сургах зардал хэмнэсэн арга хэмжээ боллоо.

Гадаад орнуудад зохион байгуулсан сургалт

Банкны сургалтын төв 2007 онд арилжааны банкуудын үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн менежментийг хөгжүүлж олон улсын стандарт түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Германы банкны салбарын хөгжилтэй танилцуулах, банкуудын удирдах ажилтнууд, хүний нөөцийн менежерүүд, мэргэжлийн хүмүүст зориулсан 5 удаагийн сургалтыг ХБНГУ-д зохион байгуулав.



4.1 Монгол Улсын эдийн засгийн тойм

Дэлхийн зах зээл дээр 2007 онд алт болон зэсийн үнэ өндөр хэвээр байсан нь манай орны эдийн засагт эерэг нөлөө үзүүлэв. Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий өсөлт урьдчилсан байдлаар жилийн 9.9 хувьд хүрэв. Үндэсний статистикийн хорооны мэдээгээр нэг хүнд ногдох ДНБ 1729.6 мянган төгрөг болжээ.

Эдийн засгийн дундаж өсөлт 2004-2006 онд 8.8 хувь байсан бөгөөд тайлант онд 9.9 хувь болж өмнөх оныхоос 1.3 нэгжээр өндөр байна. Энэхүү өсөлтөнд хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй (ДНБ-ий 20.6 хувийг бүрдүүлсэн), уул уурхай, олборлох үйлдвэр (ДНБ-ий 27.4 хувийг бүрдүүлсэн), бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ (ДНБ-ий 7.6 хувийг бүрдүүлсэн), тээвэр, агуулахын аж ахуй, холбоо (ДНБ-ий 9.1 хувийг бүрдүүлсэн) зэрэг салбарын үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ өргөжсөн нь голлох нөлөө үзүүлжээ. Мөн боловсруулах үйлдвэрлэл болон барилгын ажил эрчимтэй өссөн, санхүүгийн зуучлал өргөжсөн, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ сайжирсан нь эдийн засгийн өсөлтөнд зохих хувь нэмэр оруулжээ.

Тайлант онд боловсруулах үйлдвэрлэл 32.3 хувиар нэмэгдэж, өсөлтийн хурдаараа бусад салбарыг тэргүүлж байна. Барилга 22.4 хувь, тээвэр, агуулахын аж ахуй, холбоо 18.6 хувь, хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй 15.8 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ 15.4 хувь, санхүүгийн зуучлал 13.7 хувиар тус тус өсчээ.

Хүснэгт 4.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн, түүний өсөлт (2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг)

	2004	2005	2006	2007*
ДНБ	2,591,592.8	2,779,578.2	3,017,425.7	3,316,498.9
өсөлт (%)	10.6	7.3	8.6	9.9
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	547,642.2	608,335.1	654,148.2	757,340.1
өсөлт (%)	18.6	11.1	7.5	15.8
Уул уурхай, олборлох үйлдвэр	548,261.9	608,208.9	646,310.2	657,236.4
өсөлт (%)	34.3	10.9	6.3	1.7
Боловсруулах үйлдвэр	126,261.5	101,962.9	115,585.3	152,962.3
өсөлт (%)	-1.4	-19.2	13.4	32.3
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	79,328.2	80,021.1	83,634.8	86,273.1
өсөлт (%)	6.3	0.9	4.5	3.2
Барилга	50,747.7	58,835.2	61,827.5	75,681.5
өсөлт (%)	-4.4	15.9	5.1	22.4
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	220,643.6	226,961.1	261,759.7	301,994.9
өсөлт (%)	-2.6	2.9	15.3	15.4
Зочид буудал, зоогийн газар	16,342.8	19,135.0	21,022.1	21,278.2
өсөлт (%)	14.4	17.1	9.9	1.2

	2004	2005	2006	2007*
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	251,425.0	309,100.0	346,429.2	410,868.1
өсөлт (%)	10.7	22.9	12.1	18.6
Санхүүгийн зуучлал	87,147.2	99,966.8	96,776.1	110,028.8
өсөлт (%)	21.7	14.7	-3.2	13.7
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	199,469.5	217,120.3	228,863.4	238,925.1
өсөлт (%)	5.1	8.8	5.4	4.4
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	64,651.5	66,847.2	67,154.5	67,221.7
өсөлт (%)	4.0	3.4	0.5	0.1
Боловсролын салбарын үйл ажиллагаа	89,361.1	84,915.7	88,685.5	90,922.0
өсөлт (%)	-7.7	-5.0	4.4	2.5
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	36,859.3	37,966.5	41,515.4	42,276.4
өсөлт (%)	2.9	3.0	9.3	1.8
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	27,229.5	28,323.0	30,027.1	33,479.4
өсөлт (%)	13.8	4.0	6.0	11.5
Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ	-69,426.2	-79,858.5	-109,673.2	-149,010.8
өсөлт (%)	26.4	15.0	37.3	35.9
Бараа, үйлчилгээний татвар	307,180.5	311,737.9	383,359.9	419,021.7
өсөлт (%)	17.6	1.5	23.0	9.3
Тооцооны зөрүү	8,467.5			

* Урьдчилсан байдлаар

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл (2005 оны үнээр) 155.4 тэрбум төгрөг буюу 10.0 хувиар өсчээ. Үүнд боловсруулах үйлдвэрийнх 152.5 тэрбум төгрөг буюу 37.7 хувиар нэмэгджээ. Харин уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл 3.8 тэрбум төгрөг буюу 0.4 хувиар буурсан байна. ДНБ-д боловсруулах үйлдвэрийн эзлэх хувийн жин 0.7 нэгжээр өсч 4.1 хувь болсон бол уул уурхай, олборлох үйлдвэрийнх 2.6 нэгжээр багасч 27.4 хувьд хүрчээ.

ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувийн жин 19.5 хувиас 20.6 хувь болж өссөн нь мал аж ахуйн салбарын өсөлттэй холбоотой. Тайлант онд малын тоо толгой 5.5 сая толгой буюу 15.7 хувиар нэмэгдэж 40.3 сая болжээ. Малын тоо малын төрөл тус бүрээр өссөн бөгөөд зүй бусаар хорогдсан малын тоо өмнөх оноос 182.3 мянган толгой буюу 38.3 хувиар багассан байна.

Тариалангийн бүс нутгуудад 2007 оны зун агаар хэт халснаас таримал ургамлын ургацад муугаар нөлөөлсөн байна. Хураасан үр тариа 23.8 мянган тонн буюу 17.2 хувиар буурч, харин хүнсний ногоо 6.0 мянган тонн буюу 8.6 хувиар нэмэгдсэн байна. Нэг га талбайгаас 9.2 центнер үр тариа, 99.9 центнер төмс хураасан нь 2006 оныхоос тус бүр 1.8 центнерээр багасчээ.

Тайлант онд жилийн инфляци 15.1 хувь болсон бөгөөд энэ нь 2000 оноос хойш хамгийн өндөр үзүүлэлт юм. Хэрэглээний үнийн ерөнхий индекс өсөх гол шалтгаан нь нийлүүлэлтийн хүчин зүйлстэй холбоотой байв.

Газрын тосны дэлхийн зах зээлийн үнэ өсөхөд геополитикийн ээдрээтэй байдал, нийлүүлэлтийн хомсдол, америк долларын ханшийн уналт гол хөшүүрэг болсон гэж эдийн засагчид дүгнэжээ. Дэлхийн нийт дулаарал, газрын тосны үнийн өсөлт, хөгжиж буй орнуудад бий болсон эрэлтийн өсөлт нь хүнсний зарим бүтээгдэхүүний үнэ, тухайлбал буудайн үнэ нэмэгдэхэд хүргэсэн билээ. Энэ үйл явц манай эдийн засагт мөн нөлөөлсөн болно. Тайлант онд А-80 бензиний дундаж үнэ өмнөх жилийн дундаж үнээс 4.6 хувь, А-93 бензинийх 8.5 хувиар тус тус нэмэгджээ. А80 болон А93 бензиний үнэ 2007 оны 11 дүгээр сард хамгийн их буюу 11.3-12.0 хувиар нэмэгдсэн байна. Жилийн хугацаанд А-80 бензиний үнэ 27.4 хувь, А-93 бензинийх 23.9 хувиар тус тус өсөв. ОХУ нефть бүтээгдэхүүнийхээ экспортын татварын хэмжээг хэд хэдэн удаа нэмсэн нь нефть бүтээгдэхүүний дотоодын үнэ өсөхөд хүргэжээ. Нефть бүтээгдэхүүний үнийн өсөлтийг дагаад бусад бараа бүтээгдэхүүний үнэ мөн өслөө. Тайлант онд мах, махан бүтээгдэхүүний үнэ өсөхөөс гадна гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн явдал инфляцийг өсөхөд хүргэв. Гурил, гурилан бүтээгдэхүүний үнийн өсөлтөнд дэлхийн зах зээл дээрх улаан буудайн үнэ өссөн, ОХУ улаан буудайн экспортын татвараа нэмсэн зэрэг бодит хүчин зүйлс нөлөөлж байв.

Тайлант хугацаанд УИХ болон Засгийн газраас үнийн өсөлтийг хязгаарлах тодорхой арга хэмжээ авч ажилласан болно. Стратегийн хүнсний бүтээгдэхүүн болох гурилын хангамжийг сайжруулах, үнийг нь тогтворжуулах зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулан, 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл импортлох хүнсний буудайг нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-аас чөлөөлсөн байна. УИХ-ын тус тогтоолд импортлох 40 мянган тонн гурилын НӨАТ-ыг тэглэх тухай заажээ. Үүнээс гадна гурил, хүнсний буудайн нөөц бүрдүүлэхэд Монгол Улсыг хөгжүүлэх сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 51.6 тэрбум төгрөг зарцуулахыг Засгийн газарт зөвшөөрсөн байна. Импортлох 40 мянган тонн буудайн гурилыг 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл гаалийн албан татвараас чөлөөлөв. Буудайн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдээс гурил үйлдвэрлэдэг болон Тариалан эрхлэлтийг дэмжих санд нийлүүлсэн буудайн тонн тутамд 60 мянган төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэрлэсэн байна.

Тайлант онд улсын нэгдсэн төсөв 102.0 тэрбум төгрөг, урсгал тэнцэл 482.2 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Нэгдсэн төсвийн ашиг ДНБ-ий 2.2 хувь болсон байна. Татварын орлого нэмэгдсэнээр төсөв ийнхүү ашигтай гарчээ. Үүнд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар буюу алт, зэсийн үнийн өсөлтөөс хамаарсан гэнэтийн ашгийн татвараар төсөвт 353.7 тэрбум төгрөг төвлөрсөн байна. Энэ нь өмнөх оныхоос 176.2 тэрбум төгрөг буюу 1 дахин их байна.

Татварын хуулиудад татварын суурийг өргөтгөх, татвар тэгш шударга байх зарчмыг хэрэгжүүлэх, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих, татварын ачааллыг бууруулах, салбараар ялгаварласан аливаа хөнгөлөлт, чөлөөлөлтийг

багасгах агуулгатай өөрчлөлтийг оруулан мөрдөж эхэлжээ. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг шатлал бүрт 5 нэгжээр бууруулсан бөгөөд жилийн орлогын хэмжээг 3 тэрбум төгрөг болон түүнээс дээш гэж тогтоосон байна. Хүн амын орлогын албан татварын шатлалыг нэг болгож хувийг нь 10 хувь болгож, НӨАТ-ын хувийг 15 хувь байсныг 10 хувь болгож буурууллаа. Улмаар тайлант онд аж ахуйн нэгжийн албан татварын орлого 1.4 хувь, хүн амын албан татварын орлого 7.7 хувиар тус тус багассан бол нэмэгдсэн өртгийн албан татварын орлого өмнөх оныхоос 9.1 хувиар өссөн байна.

Гаалийн ерөнхий газрын статистик мэдээгээр 2007 онд манай улсын нийт экспорт 1949.1 сая ам. доллар, нийт импорт 2170.1 сая ам. доллар болж, гадаад худалдааны тэнцэл 220.0 сая ам. долларын алдагдалтай гарлаа. Нийт экспортын талаас илүү хэсэг буюу 66.8 хувийг бүрдүүлсэн эрдэс бүтээгдэхүүний экспорт өмнөх оныхтой харьцуулснаар 407.4 сая ам. доллар буюу 45.6 хувиар нэмэгдсэн нь нийт экспортын өсөлтийг тодорхойлжээ. Сүүлийн жилүүдэд нийт экспортод эрдэс бүтээгдэхүүний эзлэх хувийн жин өсч байгаа нь зэсийн баяжмалаас гадна цайрын баяжмалын экспорт өсч байгаатай холбоотой. Зэсийн баяжмалын экспорт биет хэмжээгээр 2006 оныхоос 8.2 мянган тонн буюу 1.4 хувь, үнийн дүнгээр 176.1 сая ам. доллар буюу 27.7 хувиар өсчээ. Нийт импортод эрдэс бүтээгдэхүүн, машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн импорт зонхилж байна. Эрдэс бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 152.6 сая ам. доллар буюу 33.9 хувиар өсч, нийт импортод эзлэх хувийн жин нь 27.8 болжээ.

Тайлант онд гадаад валютын цэвэр нөөц өмнөх оныхоос 41.9 хувиар нэмэгдэж 975.3 сая ам. долларт хүрсэн нь манай орны импортын 24 долоо хоногийн хэрэгцээг хангахаар байна.

Засгийн газраас тайлант онд нийгмийн халамжийн арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 69000 төгрөг, 10 дугаар сарын 1-ний өдрөөс 90000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоожээ. Мөн 10 дугаар сарын 1-ний өдрөөс Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээ болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг тус бүр 20 хувиар нэмэгдүүлсэн байна. Хүн амын өсөлтийг дэмжих, хүүхдийн хөгжлийг хангах зорилгоор 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт жилд 100 мянган төгрөг олгож эхэлсэн.

Аж үйлдвэр

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр тайлант онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 67.8 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэр, 24.3 хувийг боловсруулах аж үйлдвэр, 7.9 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж тус бүр бүрдүүлжээ. Уул уурхай, олборлох аж үйлдвэрт хамгийн өндөр хувь буюу 88.1 хувийг металлын хүдэр олборлолт, боловсруулах аж үйлдвэрт 31.0 хувийг төмрийн үйлдвэрлэл, 28.9 хувийг хүнсний бүтээгдэхүүн, ундааны үйлдвэрлэл, 23.9 хувийг нэхмэлийн үйлдвэрлэл, харин цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжид 88.0 хувийг цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл тус тус эзэлж байв.

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 2007 онд өмнөх оныхоос 2005 оны зэрэгцүүлэх үнээр 10.0 хувиар өссөнөөс боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэл 37.7 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж 3.7 хувиар тус бүр нэмэгджээ. Тус салбаруудын өсөлтийг тодорхойлсон дэд салбарыг авч үзвэл, хүнсний бүтээгдэхүүн, ундааны үйлдвэрлэл 37.5 тэрбум төгрөг буюу 31.1 хувь, нэхмэлийн үйлдвэрлэл 14.8 тэрбум төгрөг буюу 13.2 хувь, төмрийн үйлдвэрлэл 102.6 тэрбум төгрөг буюу 2.1 дахин, цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл 5.3 тэрбум төгрөг буюу 3.2 хувиар тус тус өсчээ. Харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн үйлдвэрлэл 0.4 хувиар багассан байна. Үүнд металлын хүдэр олборлолт 37.6 тэрбум төгрөг буюу 4.4 хувиар буурчээ.

Тайлант онд 2.6 их наяд төгрөгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулсан нь өмнөх оныхоос 23.2 хувиар илүү байна. Үүнээс 1.8 их наяд төгрөгийн бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд нийлүүлжээ. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулалт нийт борлуулалтын дүнд 69.9 хувь, боловсруулах аж үйлдвэрийнх 22.3 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн борлуулалт 7.8 хувийг тус тус эзэлж байна. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулалтын 84.5 хувь, боловсруулах аж үйлдвэрийн 42.8 хувь нь гадаадын зах зээлд ногдож байна. Үүнд металлын хүдэр олборлолтын бүтээгдэхүүний 86.8 хувь, нэхмэлийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 82.7 хувь, төмрийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 69.1 хувийг тус бүр гадаадын зах зээлд борлуулжээ.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 41.5 хувийг Улаанбаатар хотод, 44.4 хувийг Орхон аймагт борлуулсан байна. Өмнөх онтой харьцуулснаар Улаанбаатар хотод борлуулсан нийт бүтээгдэхүүн 9.4 хувь, харин Орхон аймагт 39.8 хувиар тус тус нэмэгджээ. Улаанбаатар хотын борлуулалтын хувийн жин 5.3 нэгжээр багасч, харин Орхон аймгийнх 5.3 нэгжээр өсчээ. 2007 оны байдлаар Орхон аймагт борлуулсан аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний эзлэх хувийн жин бусад хот, аймагтай харьцуулснаар хамгийн өндөр байна.

Хөдөө аж ахуй

Тайлант онд 40.3 сая мал, үүнд 18.3 сая ямаа, 17.0 сая хонь, 2.4 сая үхэр, 2.2 сая адуу, 260.6 мянган тэмээ тоологдов. Малын тоо 2006 оныхоос 5.4 сая буюу 15.7 хувиар өсөв. Тус өсөлтийг малын төрлөөр нь авч үзвэл ямаа 2.9 сая, хонь 2.2 сая, үхэр 257.9 мянга, адуу 124.7 мянга, тэмээ 7.1 мянган толгойгоор тус тус өсчээ. Нийт мал сүрэгт хонь 42.2 хувь, ямаа 45.6 хувийг тус тус эзэлж байна. Малын тоо толгойн өсөлт бог малын өсөлтөөр хангагджээ.

Мал тооллогын дүнгээр бүх аймаг болон Улаанбаатар хот малаа 2006 оныхоос 9.3-566.9 мянган толгой буюу 2.9-33.0 хувиар өсгөсөн байна. Хөвсгөл (3425.3 мянга), Өвөрхангай (3190.2 мянга), Завхан (3000.0 мянга), Архангай (2912.6 мянга), Увс (2653.5 мянга) зэрэг аймгууд малын тоогоороо тэргүүлж байна.

Малтай нэг өрхөд дунджаар 176 толгой мал, үүнд 1 тэмээ, 10 адуу, 11 үхэр, 74 хонь, 80 ямаа ногдож байна.

Тайлант онд 13.1 сая эх мал буюу эх малын 88.8 хувь төллөжээ. Төллөлтийн хувь өмнөх оныхоос 1.6 нэгжээр сайжирчээ. Нийт 12.8 сая төл бойжсон бөгөөд бойжилтын хувь 1.8 нэгжээр өсч, 97.1 хувь болжээ.

Тариалсан нийт талбай 202.7 мянган га болсон нь өмнөх оноос 40.7 мянган га буюу 25.1 хувиар их байна. Үүнд төмс тариалсан талбай 0.7 мянган га буюу 6.9 хувь, хүнсний ногооны талбайн хэмжээ 0.2 мянган га буюу 4.3 хувь, тэжээлийн ургамал тариалсан талбай 1.1 мянган га буюу 28.3 хувиар нэмэгджээ. Харин үр тариа тариалсан талбайн хэмжээ 4.4 мянган га буюу 3.5 хувь, буудайны талбай 1.3 мянган га буюу 1.1 хувиар тус тус багасчээ.

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр тайлант онд 114.8 мянган тонн үр тариа, 109.6 мянган тонн буудай, 76.5 мянган тонн хүнсний ногоо, 114.5 мянган тонн төмс хурааж, 930.4 мянган тонн өвс хадлан болон 34.5 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн нь 2006 оныхоос үр тариа 23.8 мянган тонн буюу 17.2 хувь, буудай 18.2 мянган тонн буюу 14.2 хувь, өвс хадлан 52.9 мянган тонн буюу 5.4 хувиар тус тус багасч, харин хүнсний ногоо 6.1 мянган тонн буюу 8.6 хувь, төмс 5.4 мянган тонн буюу 5.0 хувь, гар тэжээл 0.5 мянган тонн буюу 1.5 хувиар өсчээ.

Нэг га талбайгаас хураасан үр тариа дунджаар 9.2 центнер болсон нь өмнөх оныхоос 1.8 центнер буюу 16.4 хувиар бага байна. Нэг га талбайгаас авсан төмс 1.8 центнер буюу 1.8 хувиар буурч, 99.9 центнер болжээ.

Барилга

Урьдчилсан гүйцэтгэлээр барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2007 онд 314.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 47.5 тэрбум төгрөг буюу 17.8 хувиар их байна. Нийт барилга угсралт, их засварын ажлын 93.1 хувийг дотоодын барилгын байгууллага хийж гүйцэтгэв.

Нийт барилга угсралт, их засварын ажлын 26.8 хувийг орон сууцны барилга, 15.3 хувийг орон сууцны бус барилга (үйлдвэрийн, худалдаа үйлчилгээний, эмнэлэг, сургууль, соёлын г.з.), 41.9 хувийг инженерийн барилга байгууламж, 15.9 хувийг их засварын ажил тус бүр эзэлж байна. Мөн дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн нийт барилга угсралт, их засварын ажлын 54.7 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Нийт 228.5 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэснээс орон сууцны барилга 31.3 хувь, орон сууцны бус барилга 13.4 хувь, инженерийн барилга, байгууламж 36.1 хувь, их засварын ажил 19.1 хувийг тус тус эзэлж байна.

Тээвэр, холбоо

Тайлант онд тээврийн бүх төрлийн хэрэгслээр 23.3 сая тонн ачаа, давхардсан тоогоор 209.9 сая зорчигч тээвэрлэсэн бөгөөд 2006 оныхоос ачаа тээвэрлэлт 686.2 мянган тонн буюу 2.9 хувиар багасч, зорчигч тээвэрлэлт 14.5 сая хүн буюу 7.4 хувиар өссөн байна.

Тээврийн салбарын нийт орлого 341.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 30.0 тэрбум төгрөг буюу 9.6 хувиар нэмэгджээ. Тус хугацаанд авто тээврийн орлого 30.0 тэрбум төгрөг буюу 65.1 хувь, агаарын тээврийнх 10.7 тэрбум төгрөг буюу 12.9 хувь, усан замын тээврийн орлого 16.5 сая төгрөг буюу бараг 5 дахин өссөн байна. Харин төмөр замын тээврийн орлого 10.7 тэрбум төгрөг буюу 5.8 хувиар багасчээ.

Авто тээврээр тээсэн ачаа өмнөх оныхтой харьцуулснаар 17.7 мянган тонн буюу 0.2 хувиар өсч 9.2 сая тонн болжээ. Зорчигч тээвэрлэлт 14.3 сая хүн буюу 7.5 хувиар өсч 205.0 сая зорчигч болов.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа 14.1 сая тонн болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 703.6 мянган тонн буюу 4.8 хувиар багассанд дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлт 992.2 мянган тонн буюу 22.2 хувиар буурсан нь нөлөөлжээ. Харин зорчигч тээвэрлэлт 0.2 сая хүн буюу 3.5 хувиар нэмэгджээ.

Агаарын тээврийн ачаа тээвэрлэлт 0.3 мянган тонн буюу 14.2 хувиар буурч, зорчигч тээвэрлэлт 23.3 мянган хүн буюу 6.4 хувиар өсчээ.

Авто техникийн улсын үзлэг, тооллогын дүнгээр 2007 онд 162.0 мянган тээврийн хэрэгсэл байгаагаас 110.1 мянган ширхэг буюу 68.0 хувь нь суудлын машин байна. Суудлын машины 63.1 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

Шуудан холбооны нийт орлого 246.8 тэрбум төгрөгт хүрч жилийн хугацаанд 73.3 тэрбум төгрөг буюу 42.2 хувиар өсөв. Хүн амаас орсон орлогын тус орлогод эзлэх хувийн жин 3.0 нэгжээр өсч 2007 онд нийт орлогын 82.4 хувийг бүрдүүлжээ. Үүрэн телефон холбооны орлого 64.6 тэрбум төгрөг буюу 52.6 хувь, телефон утас, телеграф, телефаксын холбооны орлого 3.3 тэрбум төгрөг буюу 8.2 хувиар тус тус өсч нийт орлогын хэмжээ нэмэгдэхэд нөлөөлжээ.

Тайлант онд үүрэн телефон эзэмшигчдийн тоо 405.0 мянган хүн буюу 52.6 хувиар өсч 1.2 саяд хүрсэн байна. Харин утасгүй телефоны тоо 19.1 мянга буюу 43.2 хувиар буурч 25.1 мянган ширхэг, суурин телефоны цэг 13.7 мянган цэг буюу 8.4 хувиар багасч 150.0 мянга болжээ.

Үүрэн телефон холбооны дөрөвдөгч оператор “Жимобайл” 2007 онд шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Шигтгээ 7. Хедоник регрессийг ашиглан шинэ орон сууцны үнэнд нөлөөлөгч хүчин зүйлсийг илрүүлэх нь: Улаанбаатар хотын жишээн дээр

Энэхүү судалгааны ажлаар шинэ орон сууцны үнэнд нөлөөлөгч хүчин зүйлсийг хедоник регрессийг ашиглан судалсан. Үнэ хэмжилтийн хедоник загвар нь тухайн хөрөнгийн үнэ түүний ялгаатай шинж чанаруудаас хамаарна гэсэн таамаглалд суурилдаг. Иймээс орон сууцны үнэ нь тоон (өрөөний тоо) болон чанарын (халаалтын хэлбэр) үзүүлэлтийг худалдан авагч хэрхэн үнэлж байгаагаас хамаарах юм.

Шинж чанаруудын ялгаатай байдлаас хамааран үнэ хэрхэн ялгаатай тогтож байгааг шууд ажиглахад хүндрэлтэй учир хедоник регресс нь холбогдох шинж чанарууд бүхий орон сууцнуудын үнийг түүвэрлэн эконометрик шинжилгээ хийснээр тэдгээрийн нэгжийн зах зээлийн үнийг шууд бус аргаар тооцдог.

Энэхүү судалгаанд дараахь хедоник орон сууцны үнийн функцыг ашигласан.

$$[1] \quad P_H = P(X \in S, CT, C, A, R)$$

Энд P_H - Шинэ орон сууцны 1 м.кв-ын үнэ;

- S- Бүтцийн шинж чанар: энэхүү шинжийг 3 өрөө байрны талбайн хэмжээгээр төлөөлүүлсэн;
- CT- Барилгын төлөв байдал: энэхүү шинжийг а) орон сууцны нийт айлын тоо, b) тухайн барилгын чанар (барьсан компанийн нэр хүнд, c) барилгын компаниас тус шинэ орон сууцаа сурталчилдаг байсан эсэхийг дамми хувьсагчдаар төлөөлүүлсэн;
- C- Хотын дүүрэг, бүсийн ангилал: энэхүү шинжийг а) 6 дүүргийн хаана баригдаж байгаа эсвэл b) аль бүсчлэл (1-ээс 5-р бүс)-д оршиж байгааг дамми хувьсагчаар төлөөлүүлсэн;
- A- Тухайн байршлын давуу тал/хялбар дөхөм байдал: энэхүү шинжийг а) хотын төвөөс алслагдсан зай, b) автобусны буудал, тээврийн сүлжээнд ойр эсэх, c) томоохон худалдаа, үйлчилгээ болон амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газарт ойр эсэх; d) орон сууц орчмын аюулгүй байдал зэргийг харгалзсан дамми хувьсагчаар төлөөлүүлсэн;
- R- Дам нөлөөлөл (ая тухтай байдал)-ийг төлөөлөх хүчин зүйл: энэхүү шинжийг а) тухайн орон сууцны эргэн тойронд дуу, шуугиан ихтэй эсэх, b) агаарын бохирдол ихтэй эсэхийг дамми хувьсагчаар төлөөлүүлсэн;

Хедоник регрессийн параметрууд нь хагас-логарифм функцын хэлбэрийг ашиглан үнэлэгддэг. Тус регрессийн шинж чанар ёсоор түүвэрлэгдэх үнийн логарифм нь орон сууцны шинж чанарыг илэрхийлсэн хувьсагчдаас шугаман хамаарна. Иймд хагас логарифм функцын хэлбэр нь дараахь байдлаар тодорхойлогдоно.

$$[2] \quad P_H = e^{Xb+e}$$

Энд P_H - орон сууцны 1 м.кв-ын үнэ, $X \in \{S, CT, C, A, R\}$ - орон сууцны төлөв байдлыг илэрхийлсэн вектор хувьсагчид, b - үл мэдэгдэх хедоник итгэлцүүрүүдийн вектор, e - хедоник регрессийн үлдэгдэл. Хедоник функцын 2 талаас натурал логарифм авбал үнэлэгдэх регрессийн тэгшитгэл нь дараах байдлаар тодорхойлогдоно.

$$[3] \quad \ln P_H = Xb + e$$

буюу

$$\ln(P_i) = a_0 + \sum_{j=1}^1 a_{1j} S_{ij} + \sum_{k=1}^3 a_{2k} CT_{ik} + \sum_{l=1}^2 a_{3l} C_{il} + \sum_{f=1}^4 a_{4f} A_{if} + \sum_{z=1}^2 a_{5z} R_{iz} + e_i,$$

Энд $e \sim N(0, s^2)$, a_0 - сул гишүүн буюу орон сууцны суурь үнэ, a_{1j}, \dots, a_{5z} - нөлөөлөгч хүчин зүйлсийн хедоник итгэлцүүрүүд;

Өгөгдөл нь 2006-2007 оны хооронд Улаанбаатар хотод зарагдсан 118 шинэ орон сууц (3 өрөөтэй)-ны мэдээллээс бүрдэнэ⁵.

Хүснэгт 1. Шинэ орон сууцны үнэнд нөлөөлөгч хүчин зүйлсийн хедоник регрессийн үнэлгээний үр дүн

Хамаарах хувьсагч: LOG(PRICE)- Шинэ орон сууцны үнийн логарифм		
Үнэлгээний арга: Хамгийн бага квадратын арга		
Түүврийн тоо: 118		
Тайлбарлагч хувьсагч	Итгэлцүүр	Магадлал#
С Сул гишүүн	6.22	0.0000*
Орон сууц орчмын аюулгүй байдал (гэрэлтүүлэг, хөл хөдөлгөөн) (DA3)	-0.11	0.0006*
Автобусны буудал, тээврийн сүлжээнд ойр эсэх (DA1)	-0.07	0.0268**
Тус орон сууц сурталчлагддаг байсан эсэх (DCT2)	0.07	0.0240**
Хотын төвөөс алслагдсан зай (LOG(DIS))	-0.16	0.0000*
Хан-Уул дүүрэгт орших эсэх (XU)	0.21	0.0000*
Нэг орон сууцны тайлбайн хэмжээ (LOG(S))	0.28	0.0001*
Дуу, шуугиан ихтэй эсэх (DR1)	-0.06	0.0710***
R^2	0.60	
\bar{R}^2	0.58	
Дутуу оруулсан хувьсагч байгаа эсэх: DA2, DR2	0.34	
Илүүдсэн хувьсагч бий эсэх: log(dis), DR1, DA1	0.00	
White Heteroskedasticity тест	0.12	
Durbin-Watson статистик	1.98	

#- H_0 буюу тухайн хүчин зүйл орон сууцны үнэнд нөлөөгүй гэсэн таамаглал үнэн байх магадлал
*, **, ***- 1%, 5%, 10%-ийн ач холбогдлын түвшинд H_0 таамаглалыг няцааж байна.

⁵ Тус судалгаанд ашигласан эдгээр тоон мэдээллийг "Тэнхлэг зууч" сэтгүүлийн № 1 болон 2, Google Earth програм болон Улаанбаатар хотын 1: 25000 масштабтай газрын зураг ашиглан түүвэрлэв.

Үнэлгээний дүнгээс үзэхэд шинэ орон сууцны үнэд нэг орон сууцны талбайн хэмжээ, шинэ орон сууцыг сурталчилдаг байсан эсэх, орон сууц аль дүүрэгт баригдаж байгаа, хотын төвөөс алслагдсан зай, автобусны буудал, тээврийн сүлжээнд ойр эсэх, орон сууц орчмын аюулгүй байдал, тэр орчимд дуу, шуугиан ихтэй эсэх нь 1-10%-ийн ач холбогдлын түвшинд нөлөөтэй байна. Түүнчлэн үнэлэгдсэн итгэлцүүрүүд нь хүлээгдэж буй утгатайгаа нийцтэй бөгөөд диагностик тестийн үр дүн эдгээр хүчин зүйлсээр шинэ орон сууцны үнийг судлах, таамаглах боломжтой байгааг харуулсан.

Шигтгээ 8. Дэлхийн бараа бүтээгдэхүүн, зах зээлийн тойм

Газрын тос

Газрын тосны дэлхийн зах зээлийн үнэ тайлант онд 60 орчим хувиар өсч нэг баррель (159 литр) нь 95.49 ам. долларт хүрсэн нь өмнөх оны адил хэрэгцээ өссөнөөс голлон шалтгаалжээ. Тухайлбал, эдийн засаг нь үсрэнгүй хөгжиж байгаа Хятад, Энэтхэг улсуудын хэрэгцээ нэмэгдэж, цаашдаа ч өсөх хандлагатай байна. Үүний зэрэгцээ газрын тосны зарим томоохон нийлүүлэгч орнуудын улс төрийн тогтворгүй байдал, америк долларын ханшийн сулралт, харьцангуй хүйтэн цаг агаар зэрэг нь түүний үнэ өсөхөд нөлөөлжээ. Газрын тосны үнийг тогтворжуулах талаар арга хэмжээ авч байгаагийн нэг нь 2007 оны 11 сард ОПЕК-ийн гишүүн орнуудын сайд нарын хурлын шийдвэрийн дагуу газрын тосны нийлүүлэлтийг өдөрт 500 мянган баррелиар нэмэгдүүлэх болсон явдал юм. Энэ нь үнийг бага зэргээр бууруулж байгаа боловч эрэлт хэрэгцээг төдийлөн хангаж чадахгүй байна. Иймээс газрын тосны үнэ 2008 онд ч төдийлөн буурахгүй, харин ч өсөх хандлага байна. Эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, түүний зохистой хэрэглээг бий болгох явдал цаашид ч тулгамдсан зорилт болж байна.

Алт

Америк долларын ханшийн сулралт, газрын тосны өндөр үнэ, АНУ-ын орон сууцны зах зээлийн хямрал болон түүнээс үүдсэн дэлхийн арилжааны зах зээлийн тогтворгүй байдал зэргээс алтны үнэ 2007 онд 35 хувиар өсчээ. Тухайлбал, 2007 оны эхний улиралд алтны үнэ америк долларын ханшийн сулралаас өсч байсан бол 2007 оны хоёрдугаар улиралд дэлхийн Төв банкууд алтаа их хэмжээгээр худалдаж эхэлсэнтэй холбоотойгоор алтны нийлүүлэлт тогтворжиж түүний үнэ бага зэргээр буурч, харьцангуй тогтвортой болов. Гэвч энэ тогтвортой байдал нь удаан үргэлжилсэнгүй. АНУ-ын Төв банк 2007 оны 7 сард тус улсын орон сууцны зах зээл дээр гарсан хямралыг зогсоохын тулд зээлийн хүүгээ гэнэт бууруулж ам. долларын ханшийг эрс сулруулж, алтны үнэ оны сүүлээр түүхэнд байгаагүй дээд хэмжээндээ буюу унци нь 841 ам. доллар болж өсөв.

Зэс

Зэсийн үнэ 2006 онд дэлхийн зах зээлийн хамгийн дээд түвшин буюу тонн нь 8800 ам. долларт хүрч байсан ч Хятад улсын хэрэглээ буурсан нь үнэ аажмаар унахад нөлөөлжээ. Нөгөө талаар зэсийн хэрэглээгээр дэлхийд хоёрт ордог АНУ-ын эдийн засгийн хөгжил удааширч, тухайлбал, орон сууцны зах зээлийн хямралтай холбоотойгоор зэсийн эрэлт багасч, түүний үнэ буурсан байна. Тайлант оны хоёрдугаар улиралд Хятад улсын зэсийн импорт нэмэгдэж, Лондонийн зэсийн арилжааны нөөц багассанаас зэсийн үнэ тонн нь 8000 ам. доллар болтол өссөн боловч оны сүүлээр 6700 ам доллар хүртэл буурчээ.

2008 онд зэсийн үнэ өмнөх онтой адил өндөр хэлбэлзэлтэй байхаар байна. Үүнд, хамгийн их зэсийн хэрэглээтэй АНУ болон Хятад улс гол нөлөө үзүүлэх болно. Хэрэв АНУ-ын орон сууцны зах зээлийн хямрал үргэлжилсээр байвал дэлхийн зэсийн хэрэглээ буурах талтай боловч Хятад улсын зэсийн импорт өмнөх оноос ихсэх хандлагатай гэж судлаачид үзэж байгаа тул цаашид зэсийн үнэ төдийлөн буурахгүй болов уу.

Улаан буудай

Тайлант онд цаг агаарын байдлаас шалтгаалан улаан буудайн ургацын хэмжээ багассанаас гол экспортлогч орнуудын нийлүүлэлт буурсан, нөгөө талаас Пакистан, Энэтхэг зэрэг улсын улаан буудайн дотоод хэрэгцээ өсч, тэдгээрийн импорт нэмэгдсэнээс улаан буудайн дэлхийн зах зээлийн үнэ өмнөх оноос хоёр дахин өссөн байна. Цаашид улаан буудайн экспортлогч орнуудын ургацын хэмжээ дорвитой өсөхгүй бол хэрэглэгч орнуудын хэрэгцээг өмнөх онтой адил хангаж чадахгүй бөгөөд энэ нь түүний үнийг улам ихээр нэмэгдүүлэхэд хүргэж болох талтай.

4.2 Үнэ

ХҮИ-ээр тооцсон үнийн түвшин 2007 онд өсч 15.1 хувьтай гарав. Энэ нь сүүлийн 10 жилд манай эдийн засагт гараагүй үзэгдэл юм. Бензин шатахууны үнийн түвшин өссөн. Улирлын чанартай бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт багассанаар нийлүүлэгч (худалдаалагч) нар зохиомлоор үнэ хөөрөгдөж инфляцийг дэврээх хандлага ажиглагдаж байв. Эдгээрээс гадна 2007 онд хөрш орнуудын үнийн түвшин өсч, импортын бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн нь манай үнийн түвшинд шууд нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс 2007 онд зөвхөн 1 дүгээр сард 0.1 хувиар буурч, бусад саруудад өссөн байна. Хувцас, бөс бараа, гутал болон орон сууц, ус, түлш бүлгийн үнийн бууралт нь 1 дүгээр сарын дефляцийн үндсэн шалтгаан юм. Хэрэглээний үнийн индекс 2, 6, 8 дугаар саруудад хамгийн их өссөн байна. Өмнөх жилүүдэд өвлийн улиралд үнийн түвшин өсөх, хаврын улиралд тогтворжих, зуны улиралд буурах, өвлийн улиралд үнэ эргээд өсдөг зүй тогтол ажиглагддаг байв. Гэвч энэ зүй тогтлыг эвдэн 2007 онд хөрш орнуудын инфляци, түүнээс улбаалсан импортын барааны үнийн өсөлт манай орны үнийн түвшинд сөргөөр нөлөөлсөн билээ.

Нөгөө талаас төрийн албан хаагчдын цалин, нийгмийн халамжийн зардал, Засгийн газрын хөрөнгө оруулалтын өсөлт зэрэг нь үнэ өсөхөд нөлөөлсөн дотоод эдийн засгийн хүчин зүйл болов. Тухайлбал төсвийн нийт зардал/ДНБ харьцаа 2005-2006 онд 33 орчим хувьтай байсан бол тайлант онд 38.4 хувьд хүрчээ. Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсдын сарын дундаж цалин 2007 оны эцсийн байдлаар 205.9 мянган төгрөгт хүрч, өмнөх оноос 49.5 хувиар өсчээ. Цалингийн өсөлтийг хөдөлмөрийн бүтээмжийн өсөлттэй харьцуулан авч үзвэл, 2004-2005 онуудад хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт цалингийн өсөлтөөс илүү байснаа 2006-2007 онуудад эсрэгээр цалингийн өсөлт хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөөс 0.7 болон 30.1 нэгжээр давсан байна. Цалингийн өсөлт хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөөс давсан тохиолдолд инфляци өсөх сөрөг үр дагаварт хүргэдэг. Энэ талаар Монголбанкнаас хэд хэдэн судалгааны ажил, тухайлбал, “Цалин болон орлого, инфляцийн уялдаа” /2006/ сэдвээр хийсэн бөгөөд бодит худалдан авах чадварыг дээшлүүлэхийн тулд цалин хөлсийг нэг дор өндөр хувиар бус дэс дараатайгаар нэмэгдүүлэх нь харьцангуй бага сөрөг үр дагавартай байж болохыг харуулсан билээ.

Хүснэгт 4.2. Хэрэглээний үнийн индекс, жилийн инфляци, салбараар, оны эцсийн байдлаар

	Хэрэглээний үнийн индекс			Жилийн инфляци (хувь)
	Суурь	2006	2007	
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	42.2	43.6	54.4	10.2
Согтууруулах ундаа, тамхи	2.9	3.0	3.1	0.1
Хувцас, бөс бараа, гутал	10.1	10.9	11.2	0.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	10.5	11.4	12.7	1.2
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	3.3	3.6	4.0	0.5
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	1.8	2.2	2.5	0.3
Тээвэр	9.5	10.7	11.8	1.1
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	3.1	2.7	2.4	-0.3
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.7	3.9	4.0	0.1
Боловсролын үйлчилгээ	5.4	6.0	7.2	1.1
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.7	3.0	3.4	0.4
Бусад бараа үйлчилгээ	4.6	4.9	5.1	0.2
Ерөнхий индекс	100.0	106.0	122.0	15.1

Тайлант онд хэрэглээний 287 нэр төрлийн бараа, үйлчилгээний 68.3 хувийнх нь үнэ өсч, 18.5 хувийнх нь үнэ буурч, 13.2 хувийнх нь үнэ тогтвортой байв. ХҮИ-ийг бараа бүтээгдэхүүний ангилал буюу бүлгээр авч үзвэл холбоо мэдээллийн хэрэгслээс бусад бүх дэд бүлгүүдийн үнэ өссөн байна. Холбоо, үүрэн телефоны салбарт бүтээгдэхүүн нийлүүлэгч байгууллагуудын зах зээлийн өрсөлдөөн өндөр байгаа явдал нь бүтээгдэхүүний үнэ буурсан үндсэн шалтгаан юм. Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт жилийн өндөр инфляцийн дийлэнхийг бүрдүүлээ. Жилийн инфляцийн 10.2 нэгжийн өсөлт зөвхөн хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт байлаа. Хүнсний бүтээгдэхүүн дотроо талх, гурил, будаа (4.3 нэгж), мах махан (2.7 нэгж) төрлийн бүтээгдэхүүнүүд хамгийн өндөр үнийн өсөлттэй байв. Түүнчлэн орон сууц, ус цахилгаан, түлш (1.2 нэгж), Тээвэр (1.1 нэгж), боловсролын үйлчилгээ (1.2 нэгж) —ний салбарт үнийн өсөлт өндөр гарчээ.

Шигтгээ 9. Дэлхийн инфляцийн хандлага

Евро бүсийн инфляци 2007 оны 3 дугаар улиралд 1.6 хувь байсан нь өмнөх оныхоос 0.2 нэгжээр илүү байна. Хэрэглээний барааны үнийн өсөлтөнд суурь инфляци 0.7 нэгжээр өссөн нь нөлөөлсөн байна. ХҮИ 2007 оны 9 дүгээр сарын байдлаар 2 хувиас доогуур байсан боловч оны сүүлчээр эрчим хүч болон хүнсний барааны үнэ өссөнөөр төлөвлөж байснаас өндөр гарсан байна. Мөн евро бүсийн инфляци ерөнхийдөө тогтвортой болж байгаа нь үйлдвэрлэлийн хэрэгслийн ашиглалт өссөнтэй холбоотой гэж холбогдох албаны хүмүүс мэдэгдсэн байна.

АНУ-ын Холбооны Нөөцийн Банк инфляцийн түвшинг тогтвортой байлгахын тулд зээлийн хүүгээ 0.5 нэгжээр бууруулсан байна. АНУ-ын хувьд эдийн засгийн өсөлт удааширнаас инфляци буурчээ. Гол хувийн хэрэглээний зардлын дефлятор болон түрээсийн үнэ буурсан нь (түрээсийн үнэ нь өнгөрсөн жилийн суурь инфляцид голлон нөлөөлсөн) жилийн инфляцийг 2 хувиар бууруулсан байна.

Инфляцийн өсөлт зарим орнуудын хувьд үйлдвэрлэл буурснаар, харин заримд нь эрэлт хэт өсч, бодит эдийн засгийн халалт үүссэнээс улбаатай гэж үзэж байна. Индонез, Филиппин, Тайланд, АНУ зэрэг орнуудад үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үүднээс зээлийн хүүгээ бууруулсан байна. Харин Хятад, Энэтхэг, БНСУ эдийн засгийн хэт халалт бий болж, тэдгээр улсын төв банкуудад мөнгөний хатуу бодлого явуулах шаардлага гарчээ. Японы эдийн засгийн өсөлт таамаглаж байснаас өндөр гарсан нь дотоодын эрэлтээс голлон хамааралтай байсан. Үндсэн хэрэглээний үнэ өссөн ч жилийн эцсээр өөрчлөлт гаралгүй суурь инфляци дахин сөрөг гарчээ. Японы албаны хүмүүс газрын үнэ өсч байгаа нь дефляциас гарах найдлага гэж үзэж байна.

Манай улсын гадаад худалдааны гол түнш орнуудын инфляци

Манай улсын эдийн засагт дэлхийн зах зээл, худалдааны гол түнш орнуудын эдийн засагт гарсан өөрчлөлтүүд нь нөлөөлдөг. Тухайлбал, гадаад худалдааны эргэлтэнд томоохон байр суурь эзэлдэг улсуудын инфляци манай орны эдийн засагт импортоор дамжин нөлөөлж байдаг. Жишээ нь импортийн гол нийлүүлэгч орнуудын инфляцийн өсөлт манай орны импортын барааны үнийг нэмэгдүүлдэг бөгөөд энэ нь манайх шиг хэрэглээний үнийн барааны сагс дахь импортын барааны эзлэх хувийн жин өндөр байдаг улсын инфляцийг шууд өсгөх хандлагатай юм. Харин экспортын эрэлтийг бий болгогч орнуудын инфляци өснө гэдэг нь тухайн орны валютаар илэрхийлэгдэж байгаа манай улсын экспортын бүтээгдэхүүний үнийг өсгөх нөхцөлийг бий болгоно.

Экспортын эрэлтийн 70 орчим хувийг бий болгогч Хятад улсын инфляци сүүлийн хэдэн жилд нэлээд тогтвортой байсан боловч 2007 оны 8 дугаар сард хүнсний барааны үнэ өссөнөөс инфляци 6.5 хувьд хүрсэн байна. Гэвч хүнсний бус барааны үнэ бага зэрэг буурсан байна. Монголбанкны зарим судалгаагаар Хятадын инфляцийн өсөлт нэг улирлын хоцролттойгоор манай инфляцид нөлөөлдөг гэсэн тооцоо гарсан.

Монгол улсын импортын хэрэгцээний 37 хувийг бүрдүүлэгч ОХУ-ын инфляци 2000 оноос эхлэн 20.6 хувиас тогтмол буурсаар 2007 оны 3 дугаар улирлын байдлаар 7.5 хувьд хүрч байснаа оны эцсийн байдлаар 9.8 хувь болов. Суурь инфляци болон хүнсний барааны үнийн өсөлт инфляци өсөх гол шалтгаан болжээ.

Хүснэгт 1. Монгол улсын худалдааны түнш орнуудын жилийн инфляци, 2007 оны эцсийн байдлаар, хувиар

АНУ	ОХУ	БНХАУ	БНСУ	ХБНГУ
2.7	8.1	4.7	2.6	2.1

Шигтгээ 10. Дэлхийн эдийн засаг дахь хүү болон ханш

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2007 онд ойролцоогоор 5.2 хувьтай байв. Энэ жил Хятад, Энэтхэг зэрэг хөгжиж буй орнууд эдийн засгийн өсөлтөөрөө тэргүүлсэн бөгөөд ерөнхийдөө төвлөрсөн эдийн засгаас чөлөөт эдийн засагт шилжсэн орнуудын хувьд илүү тааламжтай жил болж өнгөрлөө.

Энэтхэгийн эдийн засгийн өсөлт 8.5 хувь болов. Гадаадаас их хэмжээний хөрөнгө оруулалт орж ирсэн нь Энэтхэг рупийн ханшийг өсгөх гол хүчин зүйл болжээ. Энэхүү ханшийн өсөлт нь Энэтхэгийн экспортод, тэр дундаа хамгийн ашигтай болох гэрээт ажил гүйцэтгэдэг салбарт таагүй нөлөөлсөн байна.

БНХАУ-ын гадаад худалдааны тэнцлийн ашгаас үүсч байгаа мөнгөний нийлүүлэлт үнийн өсөлтийг нэмэгдүүлэн улмаар сүүлийн 10 жилд гарч байгаагүй өндөр инфляцийг бий болгов. Үүний улмаас Хятадын Ардын банк зээлийн хүүгээ 6 удаа нэмсэн. Тухайлбал, 1 жилийн хугацаатай зээлийн хүү 0.18 нэгжээр өсч 7.47 хувь, банкны хадгаламжийн хүү 0.27 нэгжээр нэмэгдэж 4.14 хувьд тус тус хүрэв. Мөн заавал байлгах нөөцийн хувийг 10 удаа нэмж 14.5 хувьд хүргэсэн. Хятад улс инфляцийг өсгөхгүйн тулд өөрийн валютын ам доллартай харьцах ханшийг тун аажмаар чангаруулан гадаад худалдааны тэнцлийн ашгаа бууруулвал АНУ-тай хийдэг худалдааны тэнцэлийн зөрүү багасах боломжтой гэж судлаачид үзэж байна.

АНУ-ын хувьд сүүлийн 6 жилд гарч байгаагүй доогуур 1.9 хувийн эдийн засгийн өсөлттэй гарсан нь тус улсад гарсан санхүүгийн байгууллагуудын ипотекийн зээлийн асуудлаас үүдэлтэй 8 дугаар сард үүссэн зээлийн зах зээлийн хямралтай холбоотой юм. Энэ явдлаас болж Төв банк зээлийн хүүгээ бүтэн 1 нэгжээр буулгав. АНУ-ыг даган Англи болон Канадын төв банкууд зээлийн хүүгээ буурууллаа. Ам. долларын хямрал хувьцаа, бонд болон бусад үнэт цаасны үнийг унагахад нөлөөлсөн бөгөөд сүүлийн 10 жилд ажиглагдаагүй өндөр эрсдэлтэй жил болж өнгөрөв.

АНУ-ын санхүүгийн систем үл хөдлөх хөрөнгийн зах зээл, зээллэгийн асуудлаас болон хямарч байх үед Ойрхи Дорнодын газрын тос олборлогч

зарим орон газрын тосны үнийг ам. доллараар зарлахаа больсон зэрэг нь ам. долларын ханшийг унахад улам нөлөөлөв.

Эрчим хүч болон хүнсний бүтээгдэхүүний үнэ ихээр нэмэгдсэн нь АНУ-д сүүлийн 17 жилд гарч байгаагүй өндөр инфляцийг бий болголоо. Хэрэглээний барааны үнэ 2007 онд 4.1 хувиар өссөн нь 2006 оныхоос 1.6 нэгжээр өссөн байна.

Ам. долларын ханш валютын сагсан дахь 6 валютын эсрэг 10 гаруй хувиар сулрав. Уг сагсанд Английн фунт стерлинг, Японы иен, Канад доллар, Шинэ Зеланд болон Австралын доллар, Евро ордог. Долларын эсрэг евро дангаараа 12.5 хувь чангарч 11 сард 1 евро 1.50 доллартай тэнцэв. Мөн долларын иентэй харьцах ханш 8 дугаар сард огцом унаж 36.4 тэрбум доллартай тэнцэх иений солилцоо 1 өдөрт хийгдсэн нь 1998 оноос хойш гарч байгаагүй явдал болов.

Европын төв банкнаас еврогоор гүйлгээ хийдэг 13 улсын хүрээнд инфляцийг дагаж зээлийн хүүг өсгөхгүй байх бодлого явууллаа. Еврогийн бүс нутагт 11 сард инфляцийн түвшин 3 хувь хүрсэн нь инфляцийг 2 хувиас доош барих Европын төв банкны бодлогоос давжээ.

Зураг 1. Сүүлийн 5 жилийн ам долларын бусад валюттай харьцах ханш



Хүснэгт 1. Дэлхийн улсуудын бодлогын хүүний хүснэгт

Хөгжингүй орнуудын Гол төв банкнуудийн хүү			
Төв банк	Дараагийн уулзалт	Сүүлийн өөрчлөлт	Бодлогын хүү
Канадын Төв Банк	3/4/2008	3/12/2007	4.25
Английн Төв Банк	3/6/2008	12/6/2007	5.50
Японы Төв Банк	2/14/2008	7/4/2006	0.50
Европын Төв Банк	3/6/2008	6/6/2007	4.00
АНУ-ын Төв Банк	3/18/2008	12/11/2007	4.25
Швейцарийн Үндэсний Банк	3/13/2008	9/13/2007	2.75
Австралийн Төв Банк	3/4/2008	11/07/2007	6.75

Ази Номхон Далай			
Улс	Одоогийн бодлогын хүү	Өмнөх	Өөрчлөлт оруулсан
Австрали	6.75	6.50	11/7/2007
БНХАУ	7.47	7.29	12/20/2007
Энэтхэг	7.75	7.50	4/24/2007
Япон	0.25	0.07	7/14/2006
Солонгос	5.00	4.75	8/9/2007
Шинэ Зеланд	8.25	8.00	7/25/2007
Тайван	3.38	3.25	12/20/2007

Европ			
Улс	Одоогийн бодлогын хүү	Өмнөх	Өөрчлөлт оруулсан
Европын Мөнгөний Бодлогын Хороо	4.0	3.8	6/6/2007
Унгар	7.5	7.8	9/24/2007
Исланд	13.8	13.3	11/12/2007
Норвеги	5.3	5.0	12/12/2007
Словак	4.3	4.5	4/24/2007
Швед	4.0	3.8	10/30/2007
Швейцари	2.8	2.5	9/13/2007
Англи	5.5	5.8	12/6/2007

Өмнөд Америк			
Улс	Одоогийн бодлогын хүү	Өмнөх	Өөрчлөлт оруулсан
Бразил	11.3	11.5	9/5/2007

4.3 Хөдөлмөрийн зах зээл, бүтээмж

Хөдөлмөрийн бүтээмж

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр хөдөлмөрийн бүтээмж 2004 онд 2.3 сая төгрөг байснаа жил бүр нэмэгдсээр 2007 онд урьдчилсан гүйцэтгэлээр 4.5 сая төгрөгт хүрчээ. Хөдөлмөрийн бүтээмжийг тооцоходоо нэмэгдсэн өртгийг тухайн жилийн ажиллагсдын дундаж тоонд хувааж тодорхойлсон байна.

Уул уурхай, олборлох үйлдвэрийн 2007 оны хөдөлмөрийн бүтээмж бусад салбаруудтай харьцуулахад хамгийн өндөр буюу улсын дунджаас 6.4 дахин их байна. Мөн үл хөдлөх, хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа, тээвэр, агуулахын аж ахуй, холбоо, санхүүгийн зуучлал, боловсруулах үйлдвэрийн хөдөлмөрийн бүтээмж улсын дунджаас харгалзан 4.9, 2.4, 1.7, 1.3 дахин өндөр гарчээ. Харин хамгийн бага буюу улсын дунджаас 4.2 дахин бага хөдөлмөрийн бүтээмжтэй нь зочид буудал, зоогийн газрын салбар байлаа.

Хүснэгт. 4.3. Хөдөлмөрийн бүтээмж (оны үнээр, мян.төгрөг)

	2004	2005	2006	2007*
Улсын түвшинд	2 308.7	2 919.6	3 792.9	4 530.8
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	1 245.4	1 585.4	1 861.4	2 416.9
газар тариалан	1 467.4	1 358.7	2 739.5	3 091.3
мал аж ахуй	1 222.2	1 571.8	1 742.1	2 316.6
Уул уурхай, олборлох үйлдвэр	11 294.6	16 745.5	27 319.9	29 099.2
Боловсруулах үйлдвэр	2 310.9	3 153.7	4 424.0	5 906.4
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	3 106.1	3 389.6	3 502.6	3 766.6
Барилга	1 558.9	1 551.5	1 460.5	1 754.5
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар	2 755.9	3 010.2	3 462.3	4 012.1
Зочид буудал, зоогийн газар	681.7	760.9	942.7	1 069.9
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	6 491.7	8 059.6	8 833.2	10 708.1
Санхүүгийн гүйлгээ	5 750.3	6 279.3	6 479.9	7 621.0
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	19 154.7	21 752.0	24 105.5	22 292.1
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгал	1 284.7	1 446.0	2 529.8	3 686.9
Боловсрол	1 166.2	1 458.8	2 004.7	2 796.1
Эрүүл, мэнд, нийгмийн халамж	890.3	982.0	1 383.5	2 042.8
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	769.1	963.3	1 481.3	2 136.1

*Урьдчилсан гүйцэтгэл

Эх сурвалж: УСХ

Эдийн засгийн өсөлтөд зонхилох нөлөө үзүүлэгч салбаруудын хөдөлмөрийн бүтээмжийг авч үзвэл, хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн үйлдвэрлэлт тайлант онд 15.8 хувиар өссөн байхад хөдөлмөрийн бүтээмж нь 29.8 хувь, уул уурхай, олборлох үйлдвэр 1.7 хувиар өссөн байхад тус салбарын хөдөлмөрийн бүтээмж 6.5 хувь, боловсруулах үйлдвэрлэл 32.3 хувиар өсөхөд хөдөлмөрийн бүтээмж 33.5 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварын салбарын үйлдвэрлэл 15.4 хувиар нэмэгдэхэд хөдөлмөрийн бүтээмж 15.9 хувиар, тээвэр, агуулахын аж ахуй, холбооны үйлчилгээ 18.6 хувиар өргөжихөд хөдөлмөрийн бүтээмж 21.2 хувиар тус тус нэмэгдсэн байна. Харин үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл

ажиллагааны салбарын үйлдвэрлэл 4.4 хувиар өссөн боловч хөдөлмөрийн бүтээмж 7.5 хувиар багасчээ.

Нэмэгдсэн өртгийг завсрын хэрэглээ, хөдөлмөр /цалин/, үндсэн хөрөнгийн элэгдлийн нийлбэрт харьцуулж тооцсон нийт бүтээмж нь 2002-2003 онд 0.68 төгрөг байснаа 2004 онд 0.78 төгрөг, 2005 онд 0.80 төгрөг, 2006 онд 0.83 болж өссөн боловч тайлант онд 0.78 болж буурав. Нийт бүтээмжийн хэмжээгээр уул уурхай, олборлох үйлдвэр /2.42 төгрөг/, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар /2.39 төгрөг/, хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн /2.17 төгрөг/ салбарууд тэргүүлж байна. Харин боловсруулах үйлдвэр /0.5 төгрөг/, цахилгаан дулааны үйлдвэрлэл, усан хангамж /0.5 төгрөг/, зочид буудал, зоогийн газар /0.46 төгрөг/, барилга /0.28 төгрөг/ зэрэг салбаруудын нийт бүтээмж бага байв.

Үйлдвэрлэлийн гол хүчин зүйлс болох хөдөлмөр, капиталын ашиглалтын үр ашгийг тодорхойлдог үндсэн хүчин зүйлсийн бүтээмж нь тайлант онд өмнөх оноос 0.17 төгрөгөөр буурч 3.53 төгрөг болжээ. Салбаруудаар авч үзвэл, мал аж ахуй /32.10 төгрөг/, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар /12.19 төгрөг/, газар тариалан /10.88 төгрөг/, уул уурхай, олборлох үйлдвэрийн /6.65 төгрөг/ салбарууд үндсэн хүчин зүйлсийн бүтээмжээр тэргүүлж байна.

Ажилгүйдэл


Монгол улсын нийт хүн ам 2007 оны урьдчилсан дүнгээр 2635.1 мянгад хүрч өмнөх оноос 1.6 хувиар өсчээ. 2007 оны эцсийн байдлаар эдгээрээс 29.9 мянга нь аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн албанд ажил идэвхтэй эрж, хайж байгаа ажилгүйдчүүд гэж бүртгүүлсэн нь өнгөрсөн оныхоос 3.0 мянган хүнээр буюу 9.1 хувиар буурсан байна.

Үндэсний статистикийн хорооноос явуулсан хяналтын судалгааны урьдчилсан дүнгээр 2007 онд 50 мянга орчим ажлын байр шинээр бий болгожээ. Тайлант онд 55.4 мянган хүн ажилд зуучлуулж орсон нь өмнөх оноос 28.7 хувь буюу 12.4 мянган хүнээр өссөн байна. Ажилд орсон хүмүүсийн 12.3 хувь нь улсын үйлдвэрийн газар, төсөвт байгууллагад, 87.7 хувь нь компани, бусад байгууллагад оржээ.

Цалин


Үндэсний статистикийн хорооны мэдээгээр аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагсдын сарын дундаж цалин 2007 оны эцэст 205.9 мянган төгрөгт хүрч, өмнөх оныхоос 49.5 хувиар өсчээ.

Сарын дундаж цалинг салбараар авч үзвэл, санхүүгийн зуучлалын үйл ажиллагааны салбарт 412.2 мянган төгрөг, төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын салбарт 258.0 мянган төгрөг, уул уурхай, олборлох аж үйлдвэрт 238.7 мянган төгрөг, боловсролын салбарт 219.6 мянган төгрөг, эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт 206.7 мянган төгрөг байгаа нь улсын дундаж цалингаас өндөр юм. Харин бусад салбарт ажиллагсдын цалин улсын дунджаас доогуур байна.



Зураг 4.1.


Инфляци
(сарын
өөрчлөлт)



Зураг 4.2.

Дундаж
цалин

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



Зураг 4.3.

Хөдөлмөрийн
бүтээмж,
дундаж
цалингийн
өсөлт

Дундаж цалингийн өсөлт 2003 онд хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөөс 3.4 нэгжээр давуу байсан бол 2004-2005 онуудад хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт дундаж цалингаас 28.6 болон 13.2 нэгжээр тус тус илүү болов. 2006-2007 онуудад дундаж цалингийн өсөлт хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөөс 0.7 болон 30.1 нэгжээр давжээ.

4.4 Засгийн газрын санхүү

Монгол улсын нэгдсэн төсвийн орлого 1851.2 тэрбум төгрөг (ДНБ-ий 40.6 хувь), зарлага 1749.2 тэрбум төгрөг (ДНБ-ий 38.4 хувь) болж, нийт тэнцэл 102.0 тэрбум төгрөг (ДНБ-ий 2.2 хувь) болон урсгал тэнцэл 482.2 тэрбум төгрөгийн (ДНБ-ий 10.6 хувь) ашигтай гарчээ.

Хүснэгт 4.4. 2007 оны улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл (тэрбум төгрөгөөр)

	2006 он		2007 он			Хувь	
	Гүйцэтгэл	Хувийн жин	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Жин	2007/2006 /гүйц./	Төлөвлөгөөний биелэлт
Нийт орлого ба тусламж	1360.41	100	1703.98	1851.19	100	136.08	108.64
Урсгал орлого	1354.10	99.54	1698.08	1843.67	99.59	136.15	108.57
Татварын орлого	1128.14	83.31	1348.15	1500.72	81.40	133.03	111.32
Орлогын албан татвар	476.83	35.21	574.03	647.84	43.17	135.86	112.86
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	111.93	8.27	139.60	158.44	10.56	141.55	113.50
Өмчийн татвар	6.91	0.51	7.76	8.13	0.54	117.70	104.79
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	352.72	26.05	351.25	409.96	27.32	116.23	116.72
Гадаад худалдааны орлого	72.07	5.32	94.14	102.48	6.83	142.19	108.86
Бусад татвар	107.67	7.95	181.37	173.86	11.58	161.47	95.86
Татварын бус орлого	225.96	16.69	349.93	342.95	18.60	151.78	98.00
Хөрөнгийн орлого	1.63	0.12	1.80	2.51	0.14	154.53	139.62
Тусламжийн орлого	4.69	0.35	4.10	5.01	0.27	106.89	122.14
Нийт зарлага ба цэвэр зээл	1237.01	100	1815.88	1749.17	100	141.40	96.33
Урсгал зардал	982.35	79.41	1381.53	1361.46	77.83	138.59	98.55
Бараа ба үйлчилгээний зардал	692.49	70.49	667.41	663.53	48.74	95.82	99.42
Зээлийн үйлчилгээний төлбөр	18.08	1.84	24.04	18.32	1.35	101.32	76.22
Татаас ба урсгал шилжүүлэг	271.78	27.67	690.08	679.62	49.92	250.06	98.48
Хөрөнгийн зардал	175.67	14.20	331.92	286.98	16.41	163.36	86.46
Эргэж төлөгдөх цэвэр зээл	78.99	6.39	102.44	100.73	5.76	127.52	98.33
Урсгал тэнцэл	371.75		316.56	482.21		129.71	152.33
Нийт тэнцэл	123.40		-111.90	102.02		82.67	-91.17
Алдагдлыг санхүүжүүлсэн эх үүсвэр	-73.26		111.90	192.51		-262.78	172.04
Гадаад, цэвэр	89.98		56.28	45.25		50.28	80.39
Дотоод, цэвэр	-163.24		55.62	147.27		-90.22	264.78

Төсвийн орлого

Төсвийн нийт орлого ба тусламжийн дүн төлөвлөсөн хэмжээнээс 147.2 тэрбум төгрөг буюу 8.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 490.8 тэрбум төгрөг буюу 36.1 хувиар өсч 1851.2 тэрбум төгрөгт хүрчээ.

Төсвийн нийт орлогын 99.6 хувийг бүрдүүлсэн урсгал орлого 2006 оныхоос 489.6 тэрбум төгрөг буюу 36.1 хувиар өсч, нийт орлого ба тусламжийн дүнгийн өсөлтийг тодорхойлжээ. Урсгал орлогын 81.4 хувийг бүрдүүлсэн татварын орлого 372.6 тэрбум төгрөг буюу 33.0 хувиар нэмэгджээ. Орлогын албан татвар (татварын орлогын 43.2 хувийг бүрдүүлсэн) жилийн хугацаанд 171.0 тэрбум төгрөг буюу 35.8 хувь, дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого (татварын орлогын 27.3 хувийг бүрдүүлсэн) 57.2 тэрбум төгрөг буюу 16.2 хувь, нийгмийн даатгалын шимтгэл ба хураамжийн орлого (татварын орлогын 10.5 хувийг бүрдүүлсэн) 46.5 тэрбум төгрөг буюу 41.5 хувиар өссөн байна.

Орлогын албан татвараар төсөвт орсон орлого 35.8 хувиар нэмэгдсэн нь зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвараар 353.7 тэрбум төгрөг төсөвт төвлөрсний 90.3 хувь буюу 319.5 тэрбум төгрөг нь Эрдэнэт УҮГазраас төлөгдсөн зэсийн үнийн өсөлтийн татварын орлого байна.

Дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 64.2 хувийг бүрдүүлсэн нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 21.9 тэрбум төгрөг буюу 9.1 хувь, онцгой албан татварын орлого (дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 28.4 хувь) 33.6 тэрбум төгрөг буюу 33.6 хувиар нэмэгджээ. Тайлант онд дотоодын бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэн нь нэмэгдсэн өртгийн албан татварын орлого өсөхөд хүргэв. Мөн онцгой албан татварын орлогын ихэнх хувийг бүрдүүлдэг дотоодын архины онцгой албан татвар 42.0 хувь, суудлын машины онцгой албан татвар 48.9 хувь, автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 11.8 хувиар тус тус өссөн нь онцгой албан татварын нийт орлогыг нэмэгдүүлжээ.

Гадаад худалдааны орлого 30.4 тэрбум төгрөг буюу 42.2 хувиар өсч 102.5 тэрбум төгрөгт хүрсэн нь импортын барааны гаалийн албан татварын орлого (гадаад худалдааны орлогын 94.0 хувийг бүрдүүлсэн) 31.0 тэрбум төгрөг буюу 47.5 хувиар нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлжээ. Бусад татварын орлогод ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (61.0 хувийн жинтэй) 61.9 тэрбум төгрөг буюу 139.6 хувиар өсчээ.

Төсвийн зарлага

Тайлант онд төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өмнөх оныхоос 512.1 тэрбум төгрөг буюу 41.4 хувиар өсч, төлөвлөсөн хэмжээнээс 66.7 тэрбум төгрөг буюу 3.7 хувиар бага байна.

Урсгал зардал жилийн хугацаанд 379.1 тэрбум төгрөг буюу 38.6 хувь, хөрөнгийн зардал 111.3 тэрбум төгрөг буюу 63.3 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 21.7 тэрбум төгрөг буюу 27.5 хувиар тус тус өсчээ.

Урсгал зардлыг бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нь авч үзвэл, бараа үйлчилгээний зардал (48.7 хувь) 2006 оны гүйцэтгэлтэй харьцуулснаар 28.9 тэрбум төгрөг буюу 4.2 хувиар буурсан бол татаас ба шилжүүлэг (49.9 хувь) 407.8 тэрбум төгрөг буюу 150.0 хувь, зээлийн үйлчилгээний төлбөр (1.3 хувь) 0.2 тэрбум төгрөг буюу 1.3 хувиар тус тус нэмэгджээ. Мөн цалин хөлс (бараа үйлчилгээний зардлын 44.1 хувь) өмнөх оныхоос 95.8 тэрбум төгрөг буюу 48.7 хувиар нэмэгджээ.

Урсгал зардлын 49.9 хувийг эзэлдэг татаас ба шилжүүлгийн өсөлтөнд бусад урсгал шилжүүлэг 124.8 тэрбум төгрөг буюу 49.7 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Бусад урсгал шилжүүлэгт нийгмийн даатгалын зардал 81.8 тэрбум төгрөг буюу 47.3 хувь болон халамжийн сангийн зардал 39.9 тэрбум төгрөг буюу 53.4 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь Засгийн газраас цалин хөлс болон нийгмийн халамж, үйлчилгээний нөхөн олговрыг нэмэгдүүлсэнтэй холбоотой.

Орон нутгийн төсөв


2007 онд орон нутгийн төсвийн нийт орлого 149.4 тэрбум төгрөг, нийт зардал 145.3 тэрбум төгрөг болж, төсвийн ашиг 4.1 тэрбум төгрөгт хүрчээ.

4.5 Хөрөнгийн зах зээлийн хөгжил

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн үнэт цаасны 253 удаагийн арилжаа тайлант онд явагдаж 307 компанийн 116.1 сая ширхэг хувьцаа, 542.8 мянган ширхэг бонд арилжигдаж, нийт 102.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Нийт гүйлгээний үнийн дүнгийн 60.6 хувь буюу 62.1 тэрбум төгрөгийг хувьцааны арилжааны гүйлгээ, 38.6 хувь буюу 39.6 тэрбум төгрөгийг Засгийн газрын бонд, 0.83 хувь буюу 0.8 тэрбум төгрөгийг компанийн бондын арилжаа тус тус эзэлж байна.


Арилжааны хэмжээг өмнөх оны дүнтэй харьцуулахад хувьцааны арилжааны үнийн дүн 39.2 тэрбум төгрөг буюу 4.1 дахин, Засгийн газрын бондын арилжааны дүн 4.7 тэрбум төгрөг буюу 2 дахин, компанийн бондын арилжааны дүн 0.8 тэрбум төгрөг буюу 1.8 дахин өсчээ. 2007 онд МХБ 80 тэрбум төгрөгийн арилжаа хийх зорилт тавьж ажилласан бөгөөд хоёр он солигдох өдрүүдэд МХБ-ийн үнэт цаасны арилжааны нийт дүн 102 тэрбум төгрөг давлаа.

Үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт татах сонирхолтой аж ахуйн нэгж нэмэгдэж, шинээр болон нэмж үнэт цаас гаргах үйл ажиллагаа идэвхжсэн, хувьцаат компаниудын үнэт цаасны ханш өссөн нь зах зээлийн үнэлгээ өсөхөд гол нөлөө үзүүлжээ. Нээлттэй хувьцаат компани болохоор Оллоо, Хай Би Ойл, Туул сонгино усны нөөц компаниуд шинээр бүртгүүлж хувьцаа гаргаснаас үнэт цаасны анхдагч зах зээлд амжилттай арилжигдлаа. Хөрөнгийн зах зээлд шинээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулахаар Батс, Глобал ассет, Си Си Пи, Фронттиер, Блумсбүри секьюритис зэрэг 5 компани эрх авснаар, МХБ-ийн гишүүн, брокер дилерийн компанийн тоо 30-д хүрэв. Тайлант онд 30 ХК хувьцаа эзэмшигчиддээ 7.4 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилаад




Зураг 4.4.

Төсвийн ашиг, алдагдал (ДНБ-д эзлэх хувиар)



Зураг 4.5.

Нийт орлого ба тусламж



Зураг 4.6

Нийт зардал ба цэвэр зээл

байна. Урьдчилсан дүнгээр МХБ 718.9 сая төгрөгийн орлого олж, 281.9 сая төгрөгийн зардал гарган, 358.1 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

Хүснэгт 4.5. Арилжааны гүйлгээний дүн, сая төгрөгөөр

	Арилжааны үнийн дүн		Өөрчлөлт	
	2006 онд	2007 онд	Үнийн дүнгээр	Хувиар
ЗГ-ын бонд	4,461.5	39,599.3	35,137.8	787.6
Компанийн бонд	960.9	849.9	-111	-11.6
Хувьцаа	12,604.3	62,126.8	49,522.5	392.9

ТОП-20 үнийн индексийн үзүүлэлт өмнөх оны сүүлийн өдөр 2030.81 байсан бол энэ оны сүүлээр 10256.13, тайлант хугацааны дээд үзүүлэлт 13676.95 байна. ТОП-20 үнийн индексийн дундаж үзүүлэлт өмнөх оны дунджаас 5217.7 нэгжээр буюу 4 дахин өсөв. Энэ өсөлтөнд Махимпекс, Шарын гол, МЦХ, Таван толгой, Шивээ овоо, БиДиСек зэрэг ХК-уудын үнэт цаасны ханшийн өсөлт голлон нөлөөлжээ.

Бондын арилжаа

Улсын Их Хурлаас 2007 онд 40000 айлын орон сууц хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор 60 тэрбум төгрөгийн бонд гаргах зөвшөөрлийг Засгийн газарт олгосны дагуу уг бондыг арилжих тодорхой хуваарийг гаргаж МХБ-ээр тогтмол арилжив. Засгийн газрын бондын арилжаа 10 удаа явагдаж 91, 182, 273 хоногийн 408.6 мянган ширхэг 4.5 тэрбум төгрөгийн бонд арилжигдсан байна. Тайлант онд арилжсан Засгийн газрын бондын 27 хувийг Анод банк, 24.8 хувийг Голомт банк, 21.7 хувийг ХААН банк, 21.2 хувийг ХХБ, 4.9 хувийг Монгол шуудан банк, 0.2 хувийг Капитрон банк худалдан авсан байна.

Компанийн бондын арилжаа 2007 онд 55 удаа явагдаж, 134.2 мянган ширхэг бонд арилжигдан 850 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.

Хувьцааны арилжаа

Хувьцааны арилжааны өдрийн дундаж нь хувьцааны тоо ширхгээр 458.9 мянга, үнийн дүнгээр 245.6 сая төгрөг болж байна. Нэгж хувьцааны арилжааны жигнэсэн дундаж ханш 535 төгрөг байгаа нь өмнөх оны дунджаас 366 төгрөг буюу 3.2 дахин өссөн байна. Олон нийтэд хувьцаа нь арилжигдаж буй 360 гаруй компанийн нийт зах зээлийн үнэлгээ өмнөх оны эцэст 131.9 тэрбум төгрөг байсан бол энэ оны эцэст 717.6 тэрбум төгрөгт хүрч, 585.7 тэрбум төгрөгөөр өсчээ. Хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй компанид МЦХ ХК /129.6 тэрбум/, Багануур ХК /92.3 тэрбум/, Говь ХК /13.3 тэрбум/, Нефть ХК /52.4 тэрбум/, Шивээ овоо ХК /52.3 тэрбум/ зэрэг компаниуд орж байна.

Тайлант хугацаанд тоо ширхгээр идэвхтэй арилжигдсан үнэт цаасанд Туул сонгино усны нөөц /13.7 сая ширхэг/, Оллоо /2.7 сая ширхэг/, Женко тур бюро /2.2 сая ширхэг/, Монгол Шилтгээн /0.5 сая ширхэг/ УБ БҮК /0.3 сая ширхэг/, Монинжбар /0.1 сая ширхэг/ ХК-уудын үнэт цааснууд орж байна. Харин арилжигдсан үнийн дүнгээр Туул сонгино усны нөөц /13.7 тэрбум төгрөг/, Оллоо /678.6 сая төгрөг/, Монгол Шилтгээн /655.5 сая төгрөг/,

Женко тур бюро /393.6 сая төгрөг/ УБ БҮК /316.9 сая төгрөг/, НЕФТЬ ИК /144.6 сая төгрөг/ ХК-уудын үнэт цаас идэвхтэй арилжигджээ.

Бүртгэлтэй 384 ХК-аас 307 тайлант хугацаанд компанийн үнэт цаас арилжигдаж 77 компанийн үнэт цаас огт арилжигдаагүй байна. Үнэт цаас нь арилжигдсан компаниудаас 262 компанийн үнэт цаас өсч, 26 компанийн үнэт цаасны ханш буурч, 19 компанийн үнэт цаасны ханш тогтмол байв.

Нийт 116.1 сая ширхэг хувьцаа арилжигдаж 62 тэрбум төгрөгийн гүйлгээ хийснээс анхдагч зах зээл дээр 42 сая ширхэг хувьцааг 32 тэрбум төгрөгөөр, хоёрдогч зах зээл дээр 73.9 сая ширхэг хувьцааг 30 тэрбум төгрөгөөр тус тус арилжлаа. Нийт хийгдсэн гүйлгээний үнийн дүнд анхдагч зах зээлийн арилжаа 51.7 хувийг, хоёрдогч зах зээлийн арилжаа 48.3 хувийг тус тус эзэлж байна.

4.6. Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2007 онд урьдчилсан байдлаар 75.8 сая ам. долларын, хөрөнгө ба санхүүгийн данс 176.0 сая ам. долларын ашигтай гарснаар нийт төлбөрийн тэнцэл 288.0 сая ам. долларын ашигтай гарлаа.

Урсгал дансны хөдөлгөөн

Тайлант онд гадаад худалдааны тэнцэл 11.3 сая ам. долларын, үйлчилгээ 45.7 сая ам.долларын, цэвэр орлогын хэмжээ 79.5 сая ам. долларын тус тус алдагдалтай гарсан хэдий ч урсгал шилжүүлэг 212.3 сая ам.долларын ашигтай гарснаас урсгал данс 75.8 сая ам. долларын ашигтай гарлаа.

Урсгал дансны динамик өөрчлөлтөөс үзэхэд урсгал данс 2004-2006 онуудын 1-2 дугаар улиралд сөрөг, 3-4 дүгээр улиралд эерэг байна.

Гадаад худалдаа

Төлбөрийн тэнцэл дэх гадаад худалдааны эргэлт 2007 онд өмнөх оныхоос 34.9 хувиар нэмэгдэж, 3916.1 сая ам.долларт хүрлээ.

Хүснэгт 4.6. Худалдааны тэнцэл (сая ам. доллар)

Үзүүлэлт	2006 он	2007 он	Жилийн өөрчлөлт	
			мөнгөн дүн	хувиар
Экспорт	1545.2	1952.4	407.2	26.4
Импорт	1356.7	1963.7	607.0	44.7
Худалдааны эргэлт	2901.9	3916.1	1014.2	34.9
Худалдааны тэнцэл	188.5	-11.3	-199.8	-106.0

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар⁶ тооцсон манай улсын нийт импорт⁷ 2006 онтой харьцуулахад 44.7 хувиар нэмэгдэн 1963.7 сая ам.доллар, экспортын хэмжээ⁸ 26.4 хувиар нэмэгдэн 1952.4 сая ам.долларт тус тус хүрч, гадаад худалдааны тэнцэл 11.3 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Гадаад худалдааны тэнцэл ийнхүү алдагдалтай гарсан нь импортын хурдацтай өсөлттэй холбоотой байв.

Гаалийн ерөнхий газрын статистикийн мэдээгээр валютын төлбөртэй гадаад худалдааны эргэлт 2007 онд 3615.8 сая ам. долларт хүрч 2006 оныхоос 35.6 хувь буюу 949.1 сая ам. доллараар өсчээ. Үүнд нийт экспорт 2006 онтой харьцуулахад 28.4 хувиар өсч 1858.2 сая ам. доллар, нийт импорт 44.1 хувиар өсч 1757.6 сая ам. долларт хүрчээ. Валютын төлбөртэй гадаад худалдааны тэнцлийн ашиг өмнөх оныхоос 126.9 сая ам. доллар буюу 55.8 хувиар буурч 100.6 сая ам. доллар болов.

Хүснэгт 4.7. Валютын төлбөртэй гадаад худалдаа (сая ам. доллараар)

	2004	2005	2006	2007	Өөрчлөлт	
					мөнгөн дүн	хувиар
Экспорт	734.1	962.7	1,447.1	1,858.2	411.1	28.4
Импорт	721.3	882.0	1,219.6	1,757.6	538.0	44.1
Худалдааны эргэлт	1,455.4	1,844.7	2,666.7	3,615.8	949.1	35.6
Худалдааны тэнцэл	12.8	80.6	227.5	100.6	126.9	-55.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Манай улсын экспортолсон алтны хэмжээ Тайлант онд 2006 оныхоос 24.7 хувиар буурч 11.6 тонн болжээ. Экспортолсон алтны хэмжээ буурсан тул алтны экспортоос олох валютын орлого өмнөх оныхоос 13.0 хувиар багасч 234.9 сая ам. доллар болжээ. Алтны экспорт мөнгөн дүнгээр нийт валютын төлбөртэй экспортын орлогын 12.6 хувийг бүрдүүлсэн байна.

Манай нэг тонн зэсийн баяжмалын экспортын үнэ 2006 онтой харьцуулахад 26.0 хувиар өсч дунджаар 1335.2 ам. долларт хүрчээ. 2007 онд манай улсын экспортолсон зэсийн баяжмалын хэмжээ өмнөх оныхоос 1.4 хувиар өсч 607.8 мянган тонн, экспортын орлого нь 811.5 сая ам. доллар болжээ. Зэсийн экспорт валютын төлбөртэй экспортын орлогын 43.7 хувийг бүрдүүлсэн байна.

⁶ ОУВС-гийн төлбөрийн тэнцэл тооцох аргачлал


⁷ Төлбөрийн тэнцлийн шинэчилсэн аргачлалын дагуу Гаалийн ерөнхий газраас авсан импортын үнийн дүнг С.И.Ф нөхцөлөөс Ф.О.Б нөхцөлд шилжүүлж итгэлцүүрийг 11.0 хувиар тооцов. Үүнээс 10 хувь нь тээврийн үйлчилгээ, үлдсэн 1 хувь нь даатгалын үйлчилгээний зардалд ордог болно.

⁸ Гаалийн ерөнхий газрын экспортын үнийн дүн дээр татваргүй барааны орлого нэмэгдсэн болно.




Зураг 4.7.

Урсгал дансны бүтэц



Зураг 4.8.

Урсгал данс (сая ам.доллараар)



Зураг 4.9.

Худалдааны тэнцэл

Хүснэгт 4.8. Алт, зэсийн баяжмалын экспорт, нефтийн бүтээгдэхүүний импорт

	2004	2005	2006	2007	Өөрчлөлт	
					ам. дол.	хувиар
Алтны экспорт	243.2	331.4	270.1	234.9	-35.2	-13.0
Зэсийн баяжмалын экспорт	284.3	326.2	635.4	811.5	176.1	27.7
Нефтийн бүтээгдэхүүний импорт	206.1	292.4	410.1	559.5	149.5	36.5
Биет хэмжээгээр (тонноор)						
Алтны экспорт (тонноор)	19.3	23.8	15.4	11.6	-3.8	-24.7
Зэсийн баяжмалын экспорт (мянган тонн)	562.6	587.1	599.5	607.8	8.2	1.4
Нефтийн бүтээгдэхүүний импорт (мянган тонн)	562.2	549.5	637.3	793.6	156.3	24.5

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Монгол улс 2007 онд нийтдээ 4577.5 тонн ноолуур, 264.3 мянган ширхэг ноолууран бүтээгдэхүүн экспортолж 192.0 сая ам. долларын орлого олжээ. Ноолуур, ноолууран бүтээгдэхүүний экспортын орлого 2006 оныхоос 16.2 хувиар өсч тайлант оны валютын төлбөртэй экспортын орлогын 10.3 хувийг бүрдүүлжээ.

Тайлант онд алт, зэсийн баяжмал, ноолуур, ноолууран бүтээгдэхүүний экспорт нийт валютын төлбөртэй экспортын 66.6 хувийг эзэлж байна.

Нефтийн бүтээгдэхүүн импортын хэмжээ 2007 онд өмнөх оныхоос 24.5 хувь буюу 156.3 мянган тонноор өсч 793.6 мянган тоннд хүрчээ. Нефтийн бүтээгдэхүүний импорт валютын төлбөртэй импортын 31.8 хувийг бүрдүүлэв.

Гадаад худалдааны нөхцөл

Манай улсын нийт импортын үнийн индекс 2007 онд өмнөх оныхоос 11.1 нэгжээр буурч 190.3 болсон хэдий ч экспортын үнийн индекс 56.8 нэгжээр өсч 283.8 болж гадаад худалдааны ерөнхий индекс 36.4 нэгжээр сайжирч 149.1 гарав.


Тайлант онд цагаан будаа /4.8 хувь/, улаанбуудайн дээд гурил /28.1 хувь/, талх амтлаг зүйлс /8.9 хувь/, автобензин /9.3–10.1 хувь/, дизель /5.9 хувь/, онгоцны түлш /6.8 хувь/ зэрэг импортын бараа бүтээгдэхүүний импортын үнэ өмнөх оныхоос, нэмэгдсэн хэдий ч машины эд анги /8.1 хувь/, мотоцикль /21.4 хувь/, нийлэг мяндсан давуу /12.0 хувь/, шингэн зүйлсийн насос /83.2 хувь/, телефон, утасны аппаратууд /63.3 хувь/, ган бүтээгдэхүүн /30.3 хувь/ зэрэг импортын бараа бүтээгдэхүүний үнэ буурсан тул импортын үнийн индекс 11.1 нэгжээр буурчээ.

Малын өлөн гэдэсний экспортын үнэ тайлант онд 11.9 хувиар, үхрийн хөлдүү махных 1.9 хувиар буурсан ч молибдений баяжмалын экспортын үнэ 66.8 хувиар, жоншны үнэ 26.5 хувиар, зэсийн баяжмалын үнэ 26.0 хувиар, боловсруулаагүй нефтийн үнэ 12.0 хувиар, хонины ноосны үнэ 29.7 хувиар, ноолуурын үнэ 11.8 хувиар, боловсруулаагүй алтны экспортын үнэ 20.0 хувиар өссөн зэргээс нийт экспортын үнийн индекс 56.8 нэгжээр өсчээ.




Зураг 4.10.

Худалдааны нөхцөл




Зураг 4.11.

Экспорт, импортын үнийн индекс



Зураг 4.12.

Экспортын импортыг нөхөх итгэлцүүр



Зураг 4.13.

Үйлчилгээний тэнцэл



Зураг 4.14.

Хөрөнгө ба санхүүгийн данс (сая ам. доллараар)

Цэвэр орлого

Хамтарсан үйлдвэрүүдээс гадаадад шилжүүлсэн ногдол ашгийн хэмжээ 107.7 сая ам. доллар болсон, засгийн газар болон хувийн хэвшил нийтдээ гадаадын зээл болон хадгаламж, харилцахын хүүд 19.0 сая ам. долларыг төлж 49.7 сая ам. долларын хүүний орлого олсон болон ажиллагсдын цалин хөлс 3.8 сая ам. доллар болж нэмэгдсэн зэрэг нь цэвэр орлогын данс 79.5 сая ам. долларын алдагдалтай гарахад голлон нөлөөлсөн байна.

Урсгал шилжүүлэг

Монгол улсын Засгийн газар 2007 оны урьдчилсан байдлаар нийт 109 сая ам. доллартай тэнцэх техник туслалцааны хөрөнгийг¹⁴ ашигласан, Монгол иргэдийн эх орон руугаа гуйвуулсан мөнгөний хэмжээ 174.3 сая ам. долларт хүрч, гадагш шилжүүлсэн гуйвуулгын хэмжээ 90.3 сая ам. доллар, цэвэр урсгал шилжүүлэг 212.3 сая ам. долларын ашигтай гарав.

Хүснэгт 4.10. Ажиллагсдын гуйвуулга (сая ам. доллар)

	2006	2007	Жилийн өөрчлөлт	
			мөнгөн дүн	хувиар
Ажилчдын гуйвуулга (цэвэр)	77.1	83.9	6.9	8.9
Гаднаас орж ирсэн	153.6	174.3	20.7	13.5
Гадагш шилжүүлсэн	76.5	90.3	13.8	18.0

Хөрөнгө ба санхүүгийн данс

Хөрөнгө ба санхүүгийн данс 2007 онд 176.0 сая ам. долларын ашигтай гарсан нь өмнөх онтой харьцуулахад 51.3 хувиар нэмэгдсэн байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2006 оноос 38.1 сая ам. доллараар нэмэгдэж цэвэр дүнгээр 327.7 сая ам.долларт хүрчээ. Санхүүгийн хөрөнгө оруулалт 74.9 сая ам.доллар байна. Манай улсаас бусад хөрөнгө оруулалтын хэлбэрээр 2007 онд 226.6 сая ам. доллар гарчээ.

Монгол улсын Засгийн газрын шугамаар олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас 2007 онд нийт 81.9 сая ам. долларын урт болон дунд хугацааны зээл авснаас Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк болон Японы Засгийн газраас авсан зээл нийт зээлийн 60.2 хувийг эзэлж байна.

Монгол улсын Засгийн газар 2007 онд 29.4 сая ам. долларын үндсэн өр, 14.9 сая ам. долларын хүүгийн төлбөр, нийт 44.3 сая ам. долларын гадаад зээлийн үндсэн өр, хүүг барагдуулсан байна.

¹⁴ *ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠵᠠᠰᠦᠭᠡᠨ ᠭᠠᠰᠠᠷ 2᠐᠐7 ᠤᠨ ᠤᠷᠦᠳᠦᠴᠢᠯᠠᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯᠠᠷ ᠨᠢᠶᠢᠲᠤ 1᠐9 ᠰᠢᠶ᠋ᠠ ᠠᠮ. ᠳᠣᠯᠠᠷᠠᠶᠢ ᠲᠡᠨᠴᠡᠬᠡ ᠲᠡᠬᠡᠨ ᠲᠤᠰᠡᠭᠡᠨ ᠭᠠᠰᠠᠷ ᠪᠣᠯᠠᠨ ᠬᠤᠪᠢᠶᠢᠨ ᠬᠡᠪᠢᠰᠢᠯ ᠨᠢᠶᠢᠳᠡᠭᠡ ᠭᠠᠳᠠᠶ᠋ᠳᠠᠨ ᠵᠡᠭᠡᠯ ᠪᠣᠯᠠᠨ ᠬᠠᠳᠠᠭᠠᠯᠠᠮᠵᠢ, ᠬᠠᠷᠢᠯᠢᠴᠢᠬᠠᠶᠢᠨ ᠬᠡᠭᠦᠳᠡ 19.0 ᠰᠢᠶ᠋ᠠ ᠠᠮ. ᠳᠣᠯᠠᠷᠢᠶᠢᠭᠢ ᠲᠡᠯᠵᠢ 49.7 ᠰᠢᠶ᠋ᠠ ᠠᠮ. ᠳᠣᠯᠠᠷᠢᠶᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠶᠢ ᠣᠷᠯᠣᠭᠣ ᠣᠯᠰᠢᠨ ᠪᠣᠯᠠᠨ ᠠᠵᠢᠯᠢᠭᠠᠭᠰᠠᠳᠠᠨ ᠴᠠᠯᠢᠨ ᠬᠡᠯᠰ 3.8 ᠰᠢᠶ᠋ᠠ ᠠᠮ. ᠳᠣᠯᠠᠷ ᠪᠣᠯᠵᠢ ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠰᠢᠨ ᠵᠡᠷᠭᠡ ᠨᠢ ᠴᠡᠪᠦᠷ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ ᠳᠠᠨᠰ 79.5 ᠰᠢᠶ᠋ᠠ ᠠᠮ. ᠳᠣᠯᠠᠷᠢᠶᠢ ᠠᠯᠳᠠᠭᠳᠠᠯᠠᠲᠠᠢ ᠭᠠᠷᠠᠬᠠᠳ ᠭᠣᠯᠣᠨ ᠨᠡᠯᠡᠯᠡᠰᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨ.*

Хавсралт 1. Төлбөрийн тэнцлийн хураангуй – 2007 он (сая ам. доллараар)

Үзүүлэлт	2007				Жилийн дүн (Урьдчилсан)
	I улирал	II улирал	III улирал	IV улирал	
I. Урсгал Тэнцэл (А+Б+В)	57.3	35.3	-14.4	-2.3	75.8
А. Бараа ба үйлчилгээний худалдаа(а+b)	14.4	-14.4	-59.6	2.5	-57.0
а. Бараа (1-2)	55.2	-7.6	-72.2	13.3	-11.3
1. Экспорт Ф.О.Б.	372.0	465.8	464.2	650.4	1952.4
1.1. Зэсийн баяжмал	138.8	211.6	231.9	229.2	811.5
1.2. Мөнгөжөөгүй алт	99.8	45.0	38.6	51.5	234.9
1.3. Бусад	133.5	209.2	193.6	369.7	906.0
2. Импорт Ф.О.Б	-316.9	-473.4	-536.4	-637.1	-1963.7
б. Үйлчилгээ (1+2+3+4+5+6)	-40.7	-6.8	12.7	-10.8	-45.7
1. Тээвэр /цэвэр/	-10.0	-7.7	-19.1	-37.5	-74.2
2. Аялал /цэвэр/	-5.5	22.5	45.8	47.9	110.7
Үүнээс: Жуулчлал / цэвэр/	1.4	20.1	47.0	51.9	120.4
3. Харилцаа холбооны үйлчилгээ /цэвэр/	1.9	1.4	0.8	0.0	4.1
4. Барилгын ажил /цэвэр/	-13.2	-0.5	-4.4	-1.8	-19.9
5. Даатгалын үйлчилгээ /цэвэр/	-3.8	-5.6	-6.9	-8.1	-24.4
6. Бусад үйлчилгээ /цэвэр/	-10.1	-17.0	-3.6	-11.2	-42.0
Б. Цэвэр орлого (а+б)	7.5	-7.8	-18.3	-60.9	-79.5
а. Ажиллагсдын цалин хөлс /цэвэр/	0.5	0.2	1.0	2.0	3.8
б. Хөрөнгө оруулалтын орлого /цэвэр/	7.0	-8.0	-19.3	-62.9	-83.2
В. Урсгал шилжүүлэг (а+б+в)	35.3	57.5	63.5	56.0	212.3
а. Засгийн газрын шилжүүлэг /цэвэр/	20.9	33.1	31.0	23.2	108.2
б. Ажилчдын гуйвуулга	14.0	21.4	24.1	24.4	83.9
1. Хүлээн авсан	26.4	41.4	53.0	53.5	174.3
2. Шилжүүлсэн	12.4	19.9	28.9	29.1	90.3
в. Бусад шилжүүлэг /цэвэр/	0.4	3.0	8.3	8.4	20.1
II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл (А+Б)	57.7	-75.0	24.4	169.0	176.0
А. Хөрөнгийн данс	0.0	0.0	0.0	0.0	0.0
Б. Санхүүгийн данс (а+б+в)	57.7	-75.0	24.4	169.0	176.0
а. Шууд хөрөнгө оруулалт /цэвэр/	21.3	52.3	82.1	172.1	327.7
б. Санхүүгийн хөрөнгө оруулалт	74.8	0.0	1.3	-1.2	74.9
1. Актив	0.0	0.0	0.0	-1.2	-1.2
2. Пассив	74.8	0.0	1.3	0.0	76.0
в. Бусад хөрөнгө оруулалт	-38.4	-127.3	-59.1	-1.8	-226.6
1. Худалдааны зээл /цэвэр/	-2.1	-26.9	-44.7	60.4	-13.2
2. Зээл /цэвэр/	-64.9	-64.8	21.6	0.4	-107.6
2.1 Урт хугацааны зээл	7.6	17.1	11.2	39.5	75.5

2.1.1 Актив	-0.1	0.0	0.0	1.0	0.9
2.1.1.1 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.1.2 Бусад сектор	-0.1	0.0	0.0	1.0	0.9
2.1.2 Пассив	7.7	17.1	11.2	38.5	74.6
2.1.2.1 Ашиглалт	17.1	62.6	20.8	60.5	160.9
2.1.2.1.1 Засгийн газар	9.7	27.0	13.5	31.7	81.9
2.1.2.1.2 Бусад сектор	7.4	35.6	7.3	28.8	79.1
2.1.2.2 Үндсэн өрийн төлбөр	9.4	45.5	9.6	21.9	86.3
2.1.2.2.1 Засгийн газар	5.0	7.7	7.3	9.4	29.4
2.1.2.2.2 Бусад сектор	4.4	37.7	2.3	12.5	56.9
2.2 Богино хугацааны зээл	-72.4	-82.0	10.4	-39.1	-183.1
2.2.1 Актив	-73.3	-96.8	-15.2	-38.2	-223.5
2.2.2 Пассив	0.9	14.9	25.6	-1.0	40.4
2.2.2.1 Ашиглалт	5.4	19.3	42.1	12.8	79.6
2.2.2.2 Үндсэн өрийн төлбөр	4.5	4.5	16.5	13.7	39.3
3. Бэлэн мөнгө ба харилцах /цэвэр/	29.4	-30.4	-34.2	-42.1	-77.3
4. Бусад цэвэр актив	-0.8	-5.2	-1.9	-20.6	-28.4
III. Залруулга	50.5	162.7	62.2	-239.3	36.1
IV. Нийт Төлбөрийн Тэнцэл (I+II+III)	165.5	123.0	72.2	-72.6	288.0
V. Цэвэр нөөцийн өөрчлөлт (А+Б-В)	-165.5	-123.0	-72.2	72.6	-288.0
А. Мөнгөжсөн алтны өөрчлөлт	-54.8	18.7	18.8	44.4	27.1
Б. Бусад цэвэр активийн өөрчлөлт	-112.3	-142.6	-92.6	26.9	-320.6
В. ОУВС-гийн зээлийн өөрчлөлт	-1.5	-0.9	-1.7	-1.3	-5.4

Санамж :

Экспортын улирлын өсөлт /ФОВ/, хувиар	61.5	21.8	-1.1	40.4	26.4
Импортын улирлын өсөлт /ФОВ/, хувиар	48.4	34.6	30.0	68.1	44.7
Экспортолсон бараа, үйлчилгээний ДНБ-нд эзлэх хувийн жин	79.4	57.1	47.6	90.4	64.9
Импортолсон бараа, үйлчилгээний ДНБ-нд эзлэх хувийн жин	76.9	58.5	52.0	90.1	66.3
Урсгал дансны ашиг, алдагдал ДНБ-д эзлэх хувь	9.9	3.4	-1.1	-0.3	1.9
Гадаад валютын цэвэр нөөц, өссөн байдлаар /сая ам.доллар/	852.8	975.7	1045.5	975.3	975.3
Хэдэн долоо хоногийн импорт хангах нөөц	31.4	29.1	28.6	24.0	24.0
Нэрлэсэн үнээр тооцсон ДНБ (төлөвлөсөн) /сая ам. доллар/	579.6	1049.7	1356.3	908.4	3894.1

Шигтгээ 11. Аж ахуйн нэгжүүдийн гадаад төлбөр тооцооны судалгаа

Монголбанк аж ахуйн нэгжүүдийн гадаад төлбөр тооцооны судалгааг 2001 оноос эхлэн гүйцэтгэж, хамрах хүрээг нь нэмэгдүүлсээр ирсэн. Энэхүү судалгааны гол зорилго нь төлбөрийн тэнцлийн хамрах хүрээг өргөтгөх, төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэгдлээ.

Судалгааны дүнд манай улсын төлбөрийн тэнцлийн статистикийн богино хугацаат хөрөнгийн урсгал, гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой үзүүлэлтүүдийг сайжруулж мэдээллийн санг шинэчлэв. Төлбөрийн тэнцлийн анхан шатны мэдээллийн тогтвортой эх үүсвэрийг буй болгох, хамрах хүрээг өргөтгөж төлбөрийн тэнцлийн статистик мэдээллийн чанарыг сайжруулах, төлбөрийн тэнцлийн хүрээнд мэдээлэл солилцох цахим системийг буй болгох зорилгоор ээлжит судалгааг 2007 оны 7 дугаар сард гүйцэтгэв.

Үндэсний статистикийн хорооноос 2006 онд зохион байгуулсан аж ахуй нэгж, байгууллагын тооллогоор 500.0 сая төгрөг болон түүнээс дээш борлуулалтын орлоготой гэж бүртгэгдсэн 765 аж ахуйн нэгжээс 60.1 хувь буюу 460 аж ахуйн нэгжийг түүвэрлэн авч судалгаанд хамрууллаа. Судалгааны эцэст 52.6 хувийн хариу ирүүлсэн нь манай улстай эдийн засаг, эрх зүйн ижил төстэй орчин бүхий бусад орнуудад аж ахуйн нэгжийн судалгаа явуулж байсан дүнтэй харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт юм.

Энэ удаагийн судалгааны дүнд төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын тайланд мэдээллийг нь хамруулах 22 аж ахуйн нэгжийг сонгон авч, 2008 оноос мэдээлэл солилцох гэрээ байгуулан ажиллахаар төлөвлөж байна. Түүнчлэн энэхүү судалгааг гүйцэтгэснээр төлбөрийн тэнцлийн статистикийн үйлчилгээ, орлого, богино хугацаат хөрөнгө, урт болон дунд хугацаат зээл, худалдааны зээл, лизинг, франчайзинг зэрэг үзүүлэлтүүдийн хамрах хүрээг өргөтгөх, улмаар Монгол Улсын хөрөнгө оруулалтын позицын тайланг анх удаа гаргах боломжтой болов. Түүнчлэн импортын барааны тээвэр, даатгалын зардал, хувийн гуйвуулга болон үйлчилгээний дансны зарим үзүүлэлтүүдийн тооцооллын үндэслэлийг сайжруулах боломж бүрдэж байна.

Шигтгээ 12. Монгол улсын гадаад худалдаанд хөрш орнуудын эзлэх байр суурь

Монгол улсын валютын төлбөртэй импорт 2007 онд мөнгөн дүнгээр өмнөх оноос 43.4 хувиар өсч 1748.7 сая ам. долларт, валютын төлбөртэй экспорт 28.9 хувиар өсч 1865.2 сая ам. долларт хүрч валютын төлбөртэй гадаад худалдааны тэнцэл 116.5 сая ам. долларын ашигтай гарч валютын төлбөртэй гадаад худалдааны эргэлтийн хэмжээ өмнөх оныхоос 35.5 хувиар өсч 3613.9 сая ам. долларт хүрчээ.

Хүснэгт 1. Гадаад худалдаа

	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007
Нийт импорт	614.5	630.1	659.0	787.4	1,021.1	1,184.4	1,485.6	2,117.3
Валютын төлбөртэй импорт	332.8	374.2	470.6	538.5	721.3	882.1	1,219.6	1,748.7
Нийт бараа солилцоо	3.1	1.6	0.4	0.2	0.5	0.1	0.2	0.7
Нийт Тусламжийн бараа бүтээгдэхүүн	84.9	81.9	46.1	41.8	52.5	29.1	40.3	42.2
Нийт ХО-ын бараа бүтээгдэхүүн	69.3	61.9	27.4	99.3	95.0	152.6	146.1	172.8
Нийт Зээлийн бараа бүтээгдэхүүн	25.0	25.0	30.2	25.5	52.0	36.9	16.4	39.7
Гад.захиалагчийн материал, эд зүйлс	76.4	59.8	81.4	77.5	98.7	72.2	56.3	32.1
Бусад	23.1	25.6	2.9	4.5	1.1	11.3	6.8	81.1
БНХАУ-аас импорт	109.5	120.1	132.8	172.4	224.9	295.0	403.8	661.9
БНХАУ-ын импортын хувь хэмжээ	17.8%	19.1%	20.2%	21.9%	22.0%	24.9%	27.2%	31.3%
БНХАУ-аас Валютын төлбөртэй импорт	89.1	94.4	117.4	150.3	187.4	237.1	334.4	551.0
БНХАУ-аас Валютын төлбөртэй импортын хувь хэмжээ	26.8%	25.2%	24.9%	27.9%	26.0%	26.9%	27.4%	31.5%
БНХАУ-аас Тусламжийн бараа бүтээгдэхүүн	8.0	7.9	7.7	3.6	7.8	9.3	6.4	6.6
БНХАУ-аас Зээлийн бараа бүтээгдэхүүн	3.3	5.9	1.0	1.0	12.2	11.4	11.1	24.0
БНХАУ-аас ХО-ын бараа бүтээгдэхүүн	9.2	11.9	6.8	17.5	17.6	37.1	51.9	80.3
ОХУ-аас импорт	206.2	221.1	224.6	257.0	341.9	417.9	547.8	732.1
ОХУ-ын импортын хувь хэмжээ	33.6%	35.1%	34.1%	32.6%	33.5%	35.3%	36.9%	34.6%
ОХУ-аас Валютын төлбөртэй импорт	164.5	181.5	199.2	207.3	319.9	344.4	471.5	655.9
ОХУ-аас Валютын төлбөртэй импортын хувь хэмжээ	49.4%	48.5%	42.3%	38.5%	44.4%	39.0%	38.7%	37.5%
ОХУ-аас Тусламжийн бараа бүтээгдэхүүн	6.8	7.9	3.2	4.3	0.5	3.0	7.3	8.1
ОХУ-аас Зээлийн бараа бүтээгдэхүүн	0.4	0.4	11.2	1.9	4.0	3.6	1.3	1.7
ОХУ-аас ХО-ын бараа бүтээгдэхүүн	34.5	31.3	11.0	43.4	17.6	66.8	67.7	66.3
Бусад нийт импорт	298.8	288.9	301.6	358.1	454.3	471.4	534.0	723.3
Хувь хэмжээ	48.6%	45.8%	45.8%	45.5%	44.5%	39.8%	35.9%	34.2%
Бусад Валютын төлбөртэй импорт	79.1	98.3	154.0	180.9	213.9	300.5	413.7	541.8
Хувь хэмжээ	23.8%	26.3%	32.7%	33.6%	29.7%	34.1%	33.9%	31.0%

Нийт экспорт	466.1	521.5	500.9	615.9	869.7	1,064.9	1,542.8	1,888.9
Валютын төлбөртэй экспорт	326.0	400.5	391.0	493.5	734.0	962.6	1,447.1	1,865.1
Бараа болиллоо	21.0	20.9	19.9	7.5	4.0	2.2	1.0	0.2
Захиалагчийн бараа	95.7	94.7	87.6	108.0	128.8	91.6	79.5	9.5
Төлбөрт зориулсан бараа бүтээгдэхүүн	5.1	2.0						
Бусад төлбөргүй экспорт	18.4	3.4	2.4	6.9	2.8	8.5	15.2	14.1
БНХАУ-д экспорт	267.1	231.6	208.9	284.2	407.2	512.4	1,046.5	1,400.1
Хувь хэмжээ	57.3%	44.4%	41.7%	46.2%	46.8%	48.1%	67.8%	74.1%
ОХУ-д экспорт	45.1	43.8	43.1	37.5	20.6	27.2	45.1	57.3
ОХУ-ын төлбөрт зориулсан экспорт	5.1	2.0	-	-	-	-	-	-
Хувь хэмжээ	9.7%	8.4%	8.6%	6.1%	2.4%	2.6%	2.9%	3.0%
Бусад Валютын төлбөртэй экспорт	13.8	125.1	139.0	171.7	306.2	423.0	355.4	407.7
Хувь хэмжээ	4.2%	31.2%	35.6%	34.8%	41.7%	43.9%	24.6%	21.9%
Гадаад худалдааны тэнцэл	-148.4	-108.6	-158.1	-171.5	-151.5	-119.5	57.2	-228.4
Валютын төлбөртэй гадаад худалдааны тэнцэл	-6.8	26.2	-79.6	-45.1	12.7	80.5	227.5	116.3
МУ, БНХАУ-ын хоёр талын гадаад худалдааны тэнцэл	157.6	111.4	76.1	111.9	182.3	217.3	642.7	738.2
МУ, БНХАУ-ын хоёр талын вал.төлб. гадаад худалдааны тэнцэл	178.0	137.2	91.6	133.9	219.8	275.2	712.1	849.1
МУ, ОХУ-ын хоёр талын гадаад худалдааны тэнцэл	-161.1	-177.3	-181.6	-219.5	-321.3	-390.7	-502.7	-674.8
МУ, ОХУ-ын хоёр талын вал.төлб. гадаад худалдааны тэнцэл	-119.4	-137.7	-156.2	-169.8	-299.3	-317.2	-426.4	-598.6
Нийт гадаад худалдааны эргэлт	1,080.6	1,151.6	1,159.9	1,403.3	1,890.8	2,249.2	3,028.4	4,006.2
Валютын төлб.гад. худ.эргэлт	658.7	774.7	861.6	1,032.0	1,455.3	1,844.6	2,666.6	3,613.8
МУ, БНХАУ-ын Гадаад худалдааны нийт эргэлт	376.6	351.7	341.7	456.6	632.1	807.4	1,450.3	2,062.0
Хувь хэмжээ	34.8%	30.5%	29.5%	32.5%	33.4%	35.9%	47.9%	51.5%
МУ, БНХАУ-ын Вал.төлб.Гадаад худалдааны нийт эргэлт	356.2	326.0	326.3	434.6	594.6	749.5	1,380.9	1,951.1
Хувь хэмжээ	54.1%	42.1%	37.9%	42.1%	40.9%	40.6%	51.8%	54.0%
МУ, ОХУ-ын Гадаад худалдааны нийт эргэлт	251.4	264.9	267.7	294.5	362.6	445.2	592.9	789.4
Хувь хэмжээ	23.3%	23.0%	23.1%	21.0%	19.2%	19.8%	19.6%	19.7%
МУ, ОХУ-ын Вал.төлб.Гадаад худалдааны нийт эргэлт	204.6	223.3	242.3	244.8	340.6	371.7	516.6	713.2
Хувь хэмжээ	31.1%	28.8%	28.1%	23.7%	23.4%	20.1%	19.4%	19.7%

Үг нэмэлт: Үг нэмэлт Үг нэмэлт


Монгол Улс, БНХАУ-ын гадаад худалдаа

БНХАУ-аас импортолсон валютын төлбөртэй бараа бүтээгдэхүүний хэмжээ мөнгөн дүнгээр өмнөх оныхоос 64.8 хувиар өсч 551.0 сая ам. долларт, БНХАУ-д экспортолсон бараа бүтээгдэхүүний хэмжээ 33.8 хувиар өсч 1400.1 сая ам. долларт тус тус хүрч хоёр талын валютын төлбөртэй гадаад худалдааны тэнцэл 849.1 сая ам. долларын ашигтай гарчээ.

Хоёр талын валютын төлбөртэй гадаад худалдааны эргэлтийн хэмжээ өмнөх оныхоос 41.3 хувиар өсч 1951.2 сая ам. долларт хүрч нийт валютын төлбөртэй гадаад худалдааны эргэлтийн 54.0 хувийг бүрдүүлэв. БНХАУ-аас импортолсон валютын төлбөртэй бараа бүтээгдэхүүн нь нийт валютын төлбөртэй импортын 31.3 хувийг, БНХАУ-д экспортолсон валютын төлбөртэй бараа бүтээгдэхүүн нь нийт валютын төлбөртэй экспортын 74.1 хувийг тус тус эзэлж байна.

Манай улстай хийсэн гадаад худалдааны эргэлт БНХАУ-ын нийт гадаад худалдааны эргэлтийн 0.12 хувийг бүрдүүлж байна.

Зураг 1. Монгол, БНХАУ-ын худалдааны нөхцөл




БНХАУ-аас оруулж ирсэн бараа бүтээгдэхүүний импортын үнийн индекс 2007 оны байдлаар өмнөх оноос 19 хувиар буурч 102, БНХАУ-д экспортолсон ашигт малтмалын зах зээлийн үнэ өсч экспортын үнийн индекс өмнөх оныхоос 44.0 хувиар өсч 207, БНХАУ-тай хийсэн гадаад худалдааны нөхцөлийн индекс өмнөх оныхоос 1.5 дахин өсч 203.7-д тус тус хүрэв.

Монгол Улс, ОХУ-ын гадаад худалдаа

Манай улсын ОХУ-аас импортолсон валютын төлбөртэй бараа бүтээгдэхүүний хэмжээ мөнгөн дүнгээр өмнөх оныхоос 39.1 хувиар өсч 655.9 сая ам. долларт, ОХУ-д экспортолсон валютын төлбөртэй бараа бүтээгдэхүүний хэмжээ өмнөх оныхоос 27 хувиар өсч 57.3 сая ам. долларт хүрч, тус улстай хийсэн валютын төлбөртэй гадаад худалдаа 598.6 сая ам. долларын алдагдалтай гарчээ.

Хоёр талын валютын төлбөртэй гадаад худалдааны эргэлтийн хэмжээ өмнөх оноос 38.1 хувиар өсч 713.2 сая ам. долларт хүрсэн нь нийт валютын төлбөртэй гадаад худалдааны эргэлтийн 19.7 хувийг эзэлж байна. ОХУ-аас импортолсон валютын төлбөртэй бараа бүтээгдэхүүн нь нийт валютын төлбөртэй импортын 37.5 хувийг, тус улсад экспортолсон валютын төлбөртэй бараа бүтээгдэхүүн нийт валютын төлбөртэй экспортын 3.0 хувийг тус тус бүрдүүлж байна. Манай улсын ОХУ-тай хийсэн гадаад худалдааны эргэлтийн хэмжээ ОХУ-ын нийт гадаад худалдааны 1.3 хувьтай тэнцэж байна.

Зураг 2. Монгол улс, ОХУ-ын гадаад худалдааны нөхцөл




Тайлант онд жонш /33.3 хувь/, ямааны ноолууран бүтээгдэхүүн /91.4 хувь/, тэмээний ноосон бүтээгдэхүүн /24.4 хувь/ зэрэг экспортийн бараа бүтээгдэхүүний үнэ өссөнөөс манай улсаас ОХУ-д экспортолдог бараа бүтээгдэхүүний үнийн индекс өмнөх оныхоос 22.6 хувиар нэмэгдэж 122.6-д хүрэв. Гэвч улаан буудайн дээд гурил /34.1 хувь/, нефтийн бүтээгдэхүүн /7.9 хувь/, өргөгч, ачигч, машин механизм /95 хувь/ зэрэг ОХУ-аас оруулж ирдэг бараа бүтээгдэхүүний импортын үнэ өсч ОХУ-аас оруулж ирдэг бараа бүтээгдэхүүний импортын үнийн индекс өмнөх оныхоос 2.7 дахин нэмэгдэж 270 болов. Эдгээрээс хоёр талын гадаад худалдааны нөхцлийн индекс тайлант онд өмнөх оныхоос 54.7 хувиар буурч 45.3 болов.

Шигтгээ 13. Макро эдийн засагт мөнгөн гуйвуулгын үзүүлэх нөлөө

Бодит эдийн засаг, банк санхүүгийн салбарт хувийн мөнгөн гуйвуулгын үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох зорилгоор “Хувийн мөнгөн гуйвуулгын зарцуулалтын судалгаа” санал асуулгыг арилжааны 13 банктай хамтран 2007 оны 3 дугаар сард гадаадаас мөнгө хүлээн авдаг 1345 үйлчлүүлэгчдийн дунд явуулав.

Түүвэр судалгааны дүнгээс үзэхэд, судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх буюу 44.8 хувь нь Өмнөд Солонгост, 19.4 хувь нь АНУ-д, 9 хувь нь Европын орнуудад ажиллаж амьдарч байгаа Монгол иргэдээс гуйвуулга хүлээн авчээ.

Зураг 1. Мөнгөн гуйвуулгын бүтэц, орноор



Хүснэгт 1. Хувийн мөнгөний гуйвуулгын зарцуулалт

	Гуйвуулгын зарцуулалт /хувиар/						
	Гэр бүл, хамаатан садандаа	Өдөр тутмын хүнсэнд	Орон сууцандаа засвар хийх	Орон сууц авах	Хөрөнгө оруулалт хийхэд	Өр зээлээ төлөх	Бусад
1 Өмнөд Солонгос	33.1	13.8	4.7	16.4	11.8	12.2	7.9
2 Япон	32.9	15.2	4.1	14.1	7.7	11.1	14.7
3 АНУ	30.1	15.9	6.0	12.3	13.6	8.4	13.6
4 Англи	28.6	23.0	4.4	10.6	8.4	8.4	16.3
5 Европын орнууд	29.4	16.7	4.5	4.5	12.6	15.2	16.8
6 Бусад	26.2	23.4	9.5	10.6	5.5	8.4	16.2
Нийт хамрагдагсад	662.0	343.0	112.0	284.0	235.0	235.0	248.0

Тэмдэглэл: Судалгаанд хамрагдагсад давхар харцуулт өгсөн.

Хүлээн авсан гуйвуулгын 47.4 хувийг өрхийн хэрэглээндээ зарцуулан, үлдсэн хэсгээр нь хөрөнгө оруулалт хийдэг болох нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг үл хөдлөх хөрөнгө буюу орон сууц худалдан (22.9 хувь) авах, худалдаа наймаа хийх (32.8 хувь), хөдөө аж ахуй, уул уурхайн (7.6 хувь) чиглэлд зарцуулах сонирхол давамгайлж байна.

Судалгаанд оролцсон иргэдийн 29.8 хувь нь хөрөнгө оруулалт хийх, орон сууц авах, засвар хийхэд, 66 хувь нь тодорхой хэмжээгээр хадгаламж хийх сонирхолтой байгаа нь эдийн засагт хуримтлал үүсэх, хөрөнгө оруулах хандлага өсөх бүрэн боломжтойг харуулж байна. Судалгаанд оролцогсдын 39 хувь нь сар бүр мөнгө хүлээн авдаг ба 56 хувь нь нэг удаад 500 ам. доллараас дээш хэмжээний мөнгө хүлээн авч байгаа нь эдийн засагт дахь хэрэглээ, хөрөнгө оруулалтад ихээхэн ач холбогдолтой болохыг илтгэж байна.

Шигтгээ 14. Гадаад хөрөнгө оруулалтын тайлан

Аливаа улсын гадаад хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийг харуулдаг гадаад хөрөнгө оруулалтын позицитайланг 1998 онд 37 улс гаргадаг байсан бол 2006 оны эцэст 105 улс гаргадаг болсон байна.

Манай улсын эдийн засагт гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, гадаад санхүүжилт нэмэгдэхийн хэрээр энэхүү тайланг гаргах шаардлага тавигдаж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 5 дугаар сарын 219 тоот тушаалаар “Гадаад хөрөнгө оруулалтын позицитайланг боловсруулах заавар”-ыг батлан мөрдөж байна.

Монголбанкны гадаад цэвэр нөөцийн мэдээ, арилжааны банкуудын нэгдсэн тайлан, тус газраас 2007 онд хийсэн аж ахуйн нэгжийн түүвэр судалгааны үр дүн зэрэг мэдээлэл дээр үндэслэн Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позицитайланг 2006 оны тайланг Монголбанкнаас урьдчилсан байдлаар гаргасан.

Энэхүү тайлангаар 2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар манай улсын гадаадын орнуудад өгөх өглөг нь гадаад активын дүнгээс давж, **гадаад хөрөнгө оруулалтын позици (ГХОП) хасах 889.6 сая ам. доллар байна.**

МОНГОЛБАНКНААС 2007 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БА ТЕХНИКИЙН ШИНЖТЭЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ

5

Д/д	сар, өдөр	дугаар	нэр	Агуулга
1.	02.12	91	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	<p>Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006 оны 19 дүгээр тушаалаар баталсан “Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны түр журам”-ын 5.5 дахь хэсгийн “17:00 цагаас өмнө хүлээн авч гүйлгээнд оруулна” гэсний дараа “Яаралтай гэсэн тодотголтой төгрөгийн болон валютын гүйлгээний шимтгэлийг 100 000 (нэг зуун мянган) төгрөгөөр ногдуулна” гэж,</p> <p>Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006 оны 19 дүгээр тушаалаар баталсан “Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам”-ын 5.4 дэх хэсэгт “Төлбөр тооцооны төв нь санхүүгийн дундын сүлжээгээр дамжуулах 2.1.7-д заасан хэлбэрийг мөрдөхийг шаардах бөгөөд шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд 5 дахин нэмэгдүүлсэн хэмжээний гүйлгээний шимтгэлтэйгээр болон богиносгосон цагаар үйлчилнэ” гэж тус тус нэмж оруулжээ.</p>
2.	03.05	118	Заавал байлгах нөөцийн хувь хэмжээ, журамд өөрчлөлт оруулах тухай	Монголбанкнаас мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулах зорилгоор банкны бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд ногдох заавал байлгах нөөцийн хэмжээг тогтоож, биелэлтэд нь хяналт тавих харилцааг боловсронгуй болгох зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 181, 2005 оны 397 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгож, “Заавал байлгах нөөц тогтоож, хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталлаа.
3.	03.20	134	Журам хүчингүй болсонд тооцох тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2003 оны 576 тоот тушаалаар баталсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тооцох журам”-ыг хүчингүй болгов.
4.	04.23	204	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2002 оны 84 дүгээр тушаалаар баталсан “Дотоодын банкуудтай валютын арилжааны хэлцэл, хадгаламжийн гэрээ байгуулах журам”-ын 2.5-д Хадгаламжийн хүүний төвшинг хугацаанаас нь хамааруулж 1 сар хүртэлх хугацаагаар байрлуулах бол тухайн өдрийн АНУ-ын Холбооны нөөцийн сангаас SWIFT-ийн сүлжээгээр ирүүлсэн овернаитын хүүнээс 0.20 хувийн маржийг хасч тогтоох, 1 сараас дээш хугацаагаар бол 0.25 хувийг хасч тогтоох тухай нэмж, тус журмын 4.6-г “Нийт худалдсан ба худалдан авсан валютын мэдээг өдөр бүр энэ журмын хавсралт 3-ын дагуу гаргаж өдрийн 15.00 цагаас өмнө Монголбанкны Валютын газарт хүргүүлнэ” гэж өөрчлөв.
5.	07.02	311	Журам шинэчлэн батлах тухай	Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд Монголбанкнаас гаргаж буй үнэт цаасны арилжаатай холбогдох харилцааг боловсронгуй болгох зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 461 дүгээр тушаалыг хүчингүй болгож, “Төв банкны үнэт цаасны арилжааны журам”-ыг шинэчлэн баталлаа.
6.	07.02	312	Журам батлах тухай	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс сэргийлэхэд банкны хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулахаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, түүнтэй тэмцэхэд харилцагчийг таньж мэдэх талаар банкны баримтлах журам”-ыг батлав.

7.	07.02	313	Журам батлах тухай	“Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-аар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд сэжигтэй гүйлгээг илрүүлэх, сэжигтэй гүйлгээний талаарх мэдээлэл, түүний нууцлалыг хадгалах, хамгаалах, түүнчлэн сэжигтэй гүйлгээний болон бэлэн мөнгөний гүйлгээний тайланг Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий бусад байгууллагад дамжуулах талаарх банк, түүний удирдлага, ажилтнуудын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлов.
8.	10.30	491	Журам шинэчлэн батлах тухай	Банкны тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг банк хэрхэн биелүүлж байгааг тооцох зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Монголбанкнаас тогтоож, түүний биелэлтэд хяналт тавих, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагааг сайжруулах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2004 оны 227 тоот тушаалыг хүчингүй болгож, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталлаа.
9.	11.21	547	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 312 дугаар тушаалаар баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, түүнтэй тэмцэхэд харилцагчийг таньж мэдэх талаар банкны баримтлах журам”-д харилцагчийн тухай албан ёсны баримт бичиг, харилцагч гэсэн нэр томъёоны тайлбар болон тус журмын 2.10-т “Данстай харилцагч бүрийн иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг банк өөртөө авч хадгалах бөгөөд данстай харилцагчийн иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээн дэх мэдээлэл өөрчлөгдөх бүр түүнийг шинэчилнэ” гэж, тус журмын 2.2-т гүйлгээ хийх болон санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлэхээс өмнө энэ журмын 1.5, 1.6-д зааснаас үл хамааран харилцагчаас гаргуулж авах мэдээллийн жагсаалтыг тус тус нэмж оруулав.
10.	11.21	547	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 313 дугаар тушаалаар баталсан “Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-ын 3.1.4-д 20 сая төгрөг буюу түүнээс дээш дүнтэй сэжигтэй гүйлгээг БМГТ-гийн зэрэгцээ СГТ-гийн дагуу СМА-д мэдээлнэ гэж, 3.1.5-д 20 сая төгрөгөөс бага боловч сэжигтэй гүйлгээ илэрвэл харилцагчийн тухай мэдээллийг боломжтой бүх мэдээллийн эх үүсвэрт үндэслэн СГТ-г бөглөж СМА-д мэдээлнэ гэж тус тус нэмж оруулав. Тус журмын 2.1-ийг “Банк нь харилцагчийг буюу гүйлгээг мөнгө угаах, эсхүл терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж үзэх хангалттай үндэслэл байгаа бол эсхүл хууль тогтоомжид хориглоогүй мэдээлэл өгөхөөс илт татгалзсан харилцагчийн тухай СГТ-г бөглөж 24 цагийн дотор СМА-нд мэдээлнэ” гэж, 3.1-д Банк СМА-нд 7 хоногийн дотор мэдээлэх гүйлгээний жагсаалтыг өөрчлөв. Тус журамд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулж 2007 оны 313 дугаар тушаалаар баталсан тус журмын 1, 2 дугаар хавсралтыг хүчингүй болгож, 2007 оны 547 тоот тушаалаар СМА-нд ирүүлэх “Бэлэн мөнгөөрх гүйлгээний тайлан”, “Бэлэн мөнгөөрх гүйлгээний тайланг бөглөх заавар”, “Сэжигтэй гүйлгээний тайлан”, “Сэжигтэй гүйлгээний тайланг бөглөх заавар” гэсэн 4 хавсралт баталж, түүгээр гүйлгээний тайланд оруулах мэдээлэл, тайланг бөглөх процессыг тодорхойлж өгөв.

Захирлуудын Зөвлөлийн хүлээх үүрэг

Санхүүгийн тайланг бэлтгэх нь Захирлуудын Зөвлөлийн хүлээх үүрэг байна.

Монголбанкны санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн бэлтгэсэн болно. Захирлуудын Зөвлөл нь 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны үйл ажиллагаа, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үр дүн ба мөнгөн гүйлгээг энэхүү санхүүгийн тайланд үнэн зөвөөр илэрхийлэхийг баталгаажуулах үүрэгтэй.

Захирлуудын Зөвлөл нь Банкны санхүүгийн байдлыг үнэн зөв илэрхийлэх нягтлан бодох бүртгэлийг зөв зохистой хөтөлж явуулдаг бөгөөд санхүүгийн тайлан нь Тодруулга 3 ба Тодруулга 4-т тусгагдсан шаардлагуудад нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Банкны хөрөнгийг хамгаалах, залилан, бусад зөрчил, дутагдлаас сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг авах нь Захирлуудын Зөвлөлийн үүрэг байдаг.

3-34 дугаар хуудсанд үзүүлсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ зохих бодлогыг баримталж, үндэслэлтэй бөгөөд зохистой шийдэл, тооцооллыг ашиглаж, бүхий л холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг дагаж мөрдсөн гэж Захирлуудын Зөвлөл үзэж байна.

Захирлуудын Зөвлөлийн шийдвэрийн дагуу гарын үсэг зурсан:



А. Батсүх
Ерөнхийлөгч, Монголбанк

Улаанбаатар, Монгол улс
2008 оны 7 дугаар сарын 3



Ernst & Young Mongolia Audit LLC

Suite 401
4th Floor Bodi Tower
Sukhbaatar Square
Ulaanbaatar, Mongolia

Tel: +976 11 314032
+776 11 312005
Fax: +976 11 312042
www.ey.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Монголбанкны гишүүдэд

Бид Монголбанкны 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тайлан тэнцэл, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн дараахь санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор Банкны удирдлагын хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь Банкны удирдлагын хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлага орно.

Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гарган, өөр аливаа нэг этгээдэд биш зөвхөн та бүхэнд тайлагнах нь бидний хариуцлага юм. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Тэдгээр эрсдлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг.



Ernst & Young Mongolia Audit LLC

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (үргэлжлэл)

Аудиторын хариуцлага (үргэлжлэл)

Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой үзүүлсэн байна.

Бид өөрсдийн дүгнэлтээ өөрчлөлгүйгээр, та бүхний анхаарлыг эдгээр санхүүгийн тайлангуудын Тодруулга 19 буюу Банк нь Монгол Улсын Төв Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн заалтад нийцээгүй болохыг тодорхойлсон тодруулгад хандуулж байна.

Ernst & Young Mongolia Audit LLC

Улаанбаатар хот, Монгол Улс
2008 оны 7 дугаар сарын 3-ны өдөр

МОНГОЛБАНК

2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	Тодруулга	2007 сая төгрөг	2006 сая төгрөг
Хүүний орлого	3	48,414	18,779
Хүүний зардал	4	(18,895)	(8,072)
Хүүний цэвэр орлого		29,519	10,707
Алт, үнэт металлын арилжааны цэвэр ашиг	5	29,831	2,309
Валютын ханшийн зөрүүний цэвэр ашиг/(алдагдал)	6	26,959	(7,487)
Үйл ажиллагааны бусад орлого		1,879	1,204
Үйл ажиллагааны нийт орлого		88,188	6,733
Болзошгүй алдагдлын зардал	7	(39,451)	-
Үйл ажиллагааны цэвэр орлого		48,737	6,733
Үйл ажиллагааны зардал	8	(4,890)	(4,667)
Үйл ажиллагааны бусад зардал	10	(36,719)	(5,199)
Тайлант жилийн ашиг/(алдагдал)		7,128	(3,133)

Хавсргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ ТАЙЛАН ТЭНЦЭЛ

	Тодруулга	2007 сая төгрөг	2006 сая төгрөг
АКТИВ			
Бэлэн мөнгө		23,197	20,792
Алт ба үнэт металл	11	365,295	167,870
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	12	831,192	612,859
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд	13	-	11,195
Санхүүгийн хөрөнгө оруулалт - Борлуулахад бэлэн	14	115,748	60,701
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	15	64,582	115,967
Дотоодын банкуудад олгосон зээл	16	19,292	18,373
Сангийн яаманд олгосон зээл	17	29,604	35,822
Үндсэн хөрөнгө	18	18,093	18,276
Бусад актив	19	2,416	19,464
НИЙТ АКТИВ		1,469,419	1,081,319
ПАССИВ			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө		364,074	245,099
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	13	-	11,272
Гаргасан үнэт цаас	20	103,425	70,845
Гадаад өр төлбөр	21	149,502	150,633
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж	22	603,332	405,129
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	23	171,027	148,542
Бусад пассив	24	38,346	16,683
НИЙТ ПАССИВ		1,429,706	1,048,203
ДҮРМИЙН САН БА НӨӨЦ			
Дүрмийн сан	25	5,000	5,000
Хуримтлагдсан ашиг		5,130	4,561
Ерөнхий нөөцийн сан	26	15,704	11,145
Бусад нөөц	27	13,879	12,410
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		39,713	33,116
НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		1,469,419	1,081,319

Хавсргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН

	← Дүрмийн сан сая төгрөг	Ул хуваарилах Ерөнхий нөөц (Тодруулга 26) сая төгрөг	Бусад нөөц (Тодруулга 27) сая төгрөг	Хуваарилах Хуримтлагдсан ашиг сая төгрөг	Нийт сая төгрөг
2006 оны 1 дүгээр сарын 1-нээр	5,000	11,145	21,317	(350)	37,112
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын					
цэвэр алдагдал буюу өөрийн хөрөнгөд шууд хүлээн зөвшөөрсөн нийт зардал	-	-	(67)	-	(67)
Тайлант жилийн алдагдал	-	-	-	(3,133)	(3,133)
Тайлант жилийн нийт орлого ба зарлага	-	-	(67)	(3,133)	(3,200)
Нийгмийн хөгжлийн санд шилжүүлсэн	-	-	-	(796)	(796)
Валютын ханшийн бодит бус алдагдлыг шилжүүлсэн	-	-	(8,840)	8,840	-
2006 оны 12 дугаар сарын 31-нээр	5,000	11,145	12,410	4,561	33,116
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын					
цэвэр алдагдал буюу өөрийн хөрөнгөд шууд хүлээн зөвшөөрсөн нийт зардал	-	-	1,469	-	1,469
Тайлант жилийн алдагдал	-	-	-	7,128	7,128
Тайлант жилийн нийт орлого ба зардал	-	-	1,469	7,128	8,597
Нийгмийн хөгжлийн санд шилжүүлсэн	-	-	-	(2,000)	(2,000)
Ерөнхий нөөцөд шилжүүлсэн хуримтлагдсан ашиг	-	4,559	-	(4,559)	-
2007 оны 12 дугаар сарын 31-нээр	5,000	15,704	13,879	5,130	39,713

Хавсрагсан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСТАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2007 сая төгрөг	2006 сая төгрөг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Тайланг жилийн ашиг/(алдагдал)	7,128	(3,133)
<i>Тохируулга :-</i>		
Алтны дахин үнэлгээний бодит бус (ашиг)/алдагдал	(27,757)	87
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн (ашиг)/алдагдал	(19,198)	8,491
Үнэт металлын дахин үнэлгээний бодит бус алдагдал	-	505
Үндсэн хөрөнгийн элэгдэл	857	877
Данснаас хассан үндсэн хөрөнгө	17	17
Гаргасан аккредитивт байгуулсан сан	27,889	-
Бусад активын болзошгүй алдагдлын сан	39,329	-
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	28,265	6,844
<i>Үйл ажиллагааны хөрөнгийн өөрчлөлтүүд:-</i>		
Мөнгөжсөн алт ба үнэт металл	(169,668)	(158,569)
Санхүүгийн хөрөнгө оруулалт - Борлуулахад бэлэн	(53,578)	(28,423)
Урвуу буцаан худалдан авах хэлцлүүд	51,385	(56,260)
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан		
хөрөнгө, хадгаламж	(200,054)	(221,875)
Дотоодын банкуудад олгосон зээл	(919)	(758)
Сангийн яаманд олгосон зээл	6,218	101,453
Бусад актив	(22,281)	(12,502)
<i>Үйл ажиллагааны пассивын өөрчлөлтүүд:-</i>		
Гүйлгээнд гаргасан мөнгө	118,975	53,413
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд	(77)	-
Гаргасан үнэт цаас	32,580	(54,868)
Гадаад өр төлбөр	(1,131)	(8,243)
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж	198,203	314,831
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	22,485	58,994
Бусад пассив	(8,226)	16,050
Үйл ажиллагаанаас орсон бэлэн мөнгөний цэвэр гүйлгээ	2,177	10,087
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	11	7
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(702)	(1,614)
Хөрөнгө оруулалтад ашигласан цэвэр мөнгөн гүйлгээ	(691)	(1,607)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт	1,486	8,480
Валютын ханшийн зөрүүний нөлөө	919	196
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,792	12,116
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	23,197	20,792

Хавсргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. БАНКНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монголбанк нь Монгол Улсын Засгийн газрын 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тогтоолоор Монгол Улсын Төв Банк (цаашид Банк гэх) болон байгуулагдсан ба байршил нь: Монгол Улс, Улаанбаатар 46, Бага тойруу 9.

Банк нь бүхий л үйл ажиллагаагаа Монгол Улсад явуулдаг бөгөөд Англи улсын Лондон хот дахь төлөөлөгчийн газраас өөр хилийн чанадад үйл ажиллагаа явуулдаг салбаргүй болно.

Банк нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгууллага. Банкны үндсэн зорилго нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг баталгаажуулах ба санхүүгийн зах зээл, банкны системийн тогтвортой байдлыг хангах замаар тэнцвэртэй, тогтвортой үндэсний эдийн засгийн хөгжлийг дэмжих явдал юм.

Монголбанк нь эдгээр зорилгоо биелүүлэхийн тулд дараахь үйл ажиллагаануудыг явуулдаг. Үүнд:

- Төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ
- Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх
- Банкны үйл ажиллагаанд хяналт тавих
- Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах
- Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, зохицуулах
- Гүйлгээнд мөнгөн тэмдэгт гаргах

Банкны 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангуудыг гаргахыг Захирлуудын Зөвлөлийн 2008 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн шийдвэрээр зөвшөөрсөн.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

2.1 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Банкны санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэгдсэн болно.

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэх барилгууд, үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд, “Борлуулахад бэлэн” санхүүгийн хөрөнгө оруулалтуудыг эс тооцвол санхүүгийн тайлангуудыг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд саяын орноор, Монгол төгрөгөөр тайлагнасан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО

(а) Хүүний болон түүнтэй адилтгах орлого ба зардал

“Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа” эсвэл “Бодит үнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” гэж ангилагдсан санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад бүх хүүтэй санхүүгийн хэрэгслүүдийн хүүний орлого, зардлыг холбогдох санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн үр ашигт хүүний хувийг хэрэглэн орлогын тайланд “Хүү болон түүнтэй адилтгах орлого” ба “Хүү болон түүнтэй адилтгах зардал” гэж хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон зээл, урьдчилгааны хүүний орлогоос бусад хүүний орлогыг аккруэл сууриар орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хүүний орлогыг үнэ цэнийн бууралтад орсон бүртгэлийн дүнд хэрэглэсэн анхны үр ашигт хүүний хувь хэмжээгээр тооцож хүлээн зөвшөөрнө.

(б) Шимтгэлийн орлого

Банкны шимтгэлийн орлого нь ихэвчлэн банк хоорондын төлбөр тооцоо, гадаад банкуудын төлбөр тооцооны шимтгэлээс бүрддэг. Хураамж ба шимтгэлийн орлогыг ихэвчлэн үйлчилгээ үзүүлсэн хугацаанд нь аккруэл сууриар хүлээн зөвшөөрдөг.

(в) Гадаад валютын хөрвүүлэг

Банк нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн нэгж болох Монгол төгрөгөөр гаргадаг. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгж рүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн ханшаар хөрвүүлдэг. Банк нь гадаад валютаар илэрхийлэгдсэн өөрийн мөнгөөрх хөрөнгө ба өр төлбөрийг өдөр бүр дахин үнэлж байх бодлого барьдаг. Ханшийн бүх зөрүүг ашиг, алдагдлаар бүртгэнэ.

Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ.

(г) Алт ба үнэт металл

Алтыг бодит үнэлгээгээр нь тайлан тэнцэлд тусгадаг бөгөөд дахин үнэлгээг сар бүр хийдэг. Алтны бодит үнийг тогтоохдоо алтны зах зээлийн үнийг харгалзан үздэг. Дахин үнэлгээний олз, гарзыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

Алт, мөнгө, зоос болон түүх соёлын үнэт зүйлсийг өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь бүртгэдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(д) **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд касс дахь төгрөг, гадаад валют орно.

(е) **Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт**

(i) *Хүлээн зөвшөөрөх өдөр*

Санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг нь зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг эдгээр худалдан авалт, борлуулалтыг арилжаа хийгдсэн өдөр нь хүлээн зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл банк хөрөнгийг худалдах, худалдан авахыг амласан өдөр хүлээн зөвшөөрнө. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг арилжааны өдрөөр хүлээн зөвшөөрнө.

(ii) *Санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлт*

Анх хүлээн зөвшөөрч буй санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал нь тэдгээрийн зориулалт, шинж чанараас шалтгаална. Санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан бодит үнээр нь хэмжих ба харин бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэхгүй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд бодит үнэ дээр тэдгээртэй шууд холбоотой худалдан авалтын эсвэл гаргалтын ахиуц зардлуудыг нэмсэн дүнгээр бүртгэнэ.

(iii) *Бодит үнийн өөрчлөлтийг нь орлого, зарлагын дансанд бүртгэдэг үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд*

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрт алтны опцион, валютын ханшны форвард гэрээ хэлцлүүд, гадаад валютын опцион зэрэг багтана. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл санхүүгийн хэрэглүүдийн бодит үнийн өөрчлөлтийг “Үйл ажиллагааны бусад орлого” -оор бүртгэдэг.

Хөрвөх бондод агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд гэх мэт өөр бусад санхүүгийн хэрэглүүрт агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг салгаж авч үзэх ёстой ба агуулагдсан болон агуулагч гэрээнүүдийн эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдлүүд нь нягт хамааралгүй, мөн агуулагч гэрээг нь арилжаалах зорилгоор эзэмшээгүй ба анхны хүлээн зөвшөөрөлтөөр “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх”-д ангилаагүй байвал тэдгээрийг бодит үнээр нь бүртгэнэ. Агуулагч гэрээнээс нь салгасан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг арилжааны багц дахь бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр нь бүртгэх ба уг өөрчлөлтийг нь орлого, зарлагын дансанд бүртгэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(е) Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (үргэлжлэл)

(iv) *Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөр*

“Арилжаалах зорилгоор эзэмшиж буй” санхүүгийн хэрэгслүүдийг (үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд үүнд орохгүй) багтаасан “Арилжаалах зорилгоор эзэмшиж буй” санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрүүдийг тайлан тэнцэлд бодит үнээр нь бүртгэнэ. “Үйл ажиллагааны бусад орлого”-д бодит үнийн өөрчлөлтийг тусгана. Хүүний болон ногдол ашгийн орлого эсвэл зардлыг гэрээний нөхцлийн дагуу эсвэл төлбөрийн эрх үүссэн үед нь “Үйл ажиллагааны бусад орлого”-д бүртгэнэ.

Энэ бүлэгт ойрын хугацаанд борлуулах эсвэл эргүүлэн худалдан авах зорилгоор олж авсан өрийн бичгүүд, энгийн хувьцаа, үнэт цаасууд орсон.

(v) *Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр*

Дараах нөхцлүүд хангагдсан үед санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө энэ ангилалд оруулахаар шийдвэрлэж болно. Үүнд:

- энэхүү шийдвэр нь активыг хэмжих эсвэл активаас үүсэх олз гарзыг ялгаатай сууриар орлого, зардалд хүлээн зөвшөөрсөнөөс бий болох тууштай бус байдлыг арилгах эсвэл дорвитойгоор бууруулах; эсвэл
- эдгээр санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн бүлгийн нэг хэсэг эсвэл аль аль нь бөгөөд тэдгээрийг хүчин төгөлдөр эрсдэлийн удирдлагын бодлого эсвэл хөрөнгө оруулалтын стратегийн дагуу удирдаж, гүйцэтгэлийг нь бодит үнэ дээр нь суурилан хэмждэг; эсвэл
- санхүүгийн хэрэглүүрт агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэгсэл багтаж байгаа бол (гэхдээ агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь мөнгөн урсгалыг нь ихээхэн хэмжээгээр өөрчлөхгүй нь, эсвэл бага хэмжээний судалгааны үндсэн дээр эсвэл огт судалгаагүйгээр уг хэрэглүүр тусдаа бүртгэгдэхгүй нь тодорхой байгаагаас бусад тохиолдолд).

Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг тайлан тэнцэлд бодит үнээр нь тусгана. Бодит үнийн өөрчлөлтийг “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн цэвэр олз эсвэл гарз” дансанд бүртгэнэ. Орж ирэх эсвэл төлөх хүүг гэрээний нөхцлийн дагуу хүүний орлого, зардалд хуримтлуулж, ногдол ашгийн орлогыг тус ногдол ашгийг хүртэх эрх үүссэн үед нь “Үйл ажиллагааны бусад орлого”-д бүртгэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(e) Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (үргэлжлэл)

(vi) *‘Анхны өдөр’-ийн ашиг*

Идэвхигүй зах зээл дээрх арилжааны үнэ нь ижил хэрэглүүрийн хувьд зах зээл дээр ажиглаж болохуйц одоогийн зах зээлийн бодит үнээс зөрүүтэй эсвэл зөвхөн зах зээл дээр ажиглаж болохуйц өгөгдлийг багтаасан хувьсагчтай үнэлгээний загварт үндэслэн тогтоосон бодит үнээс зөрүүтэй байвал уг зөрүүг (энэ нь бодит үнэ ба арилжааны үнийн зөрүү буюу анхны өдрийн ашиг юм) Банк орлого, үр дүнгийн тайлангийн “Арилжааны цэвэр орлого”-д шууд хүлээн зөвшөөрнө. Ажиглах боломжгүй өгөгдлийг ашигласан тохиолдолд арилжааны үнийн зөрүү ба загварын үнийн зөрүүг орлого үр дүнгийн тайланд өгөгдлүүд нь ажиглаж болохуйц болох үед эсвэл тухайн хэрэгслийг үл хүлээн зөвшөөрөх үед л хүлээн зөвшөөрнө.

(vii) *Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт*

Банк нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших зорилго, чадвартай, тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөртэй ба тогтоосон хугацаатай санхүүгийн хэрэглүүрүүдийг дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт гэнэ. Эхний хэмжилтийн дараа дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтыг үр ашигт хүүний арга ашиглаж тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын санг хассан дүнгээр хэмжинэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцдог. Хорогдуулалт нь орлого, үр дүнгийн тайлангийн “Хүү болон түүнтэй адилтгах орлого”-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлого, үр дүнгийн тайлангийн “Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал” хэсэгт хүлээн зөвшөөрнө.

(viii) *Банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба зээл, урьдчилгаа*

Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба зээл, урьдчилгаа нь идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөрүүдтэй, тогтсон дуусгавар хугацаатай, “Зээл ба авлага” гэж ангилагдах санхүүгийн хэрэглүүрүүд юм. Анх хэмжсэний дараа бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба зээл, урьдчилгааг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнэ бууралтын санг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцно. Хорогдуулалт нь орлого, үр дүнгийн тайлангийн “Хүү болон түүнтэй адилтгах орлого”-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдалыг орлого, үр дүнгийн тайлангийн “Зээлийн алдагдлын зардал” хэсэгт хүлээн зөвшөөрнө.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(е) Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (үргэлжлэл)

(ix) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт гэж анхны хүлээн зөвшөөрөлтөөр ийнхүү ангилагдсан эсвэл бодит үнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэг, дуусгавар хугацаа хүртэл эзэмших эсвэл зээл ба урьдчилгаа гэсэн ангилалд багтаагүй санхүүгийн хөрөнгийг хэлнэ. Эдгээрт өөрийн хөрөнгийн хэрэгсэл, хамтын санд оруулсан хөрөнгө оруулалтууд, мөнгөний зах зээлийн болон өрийн хэрэглүүрүүд багтдаг.

Анх хүлээн зөвшөөрсний дараа борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтыг бодит үнээр нь хэмждэг. Хэрэгжээгүй ашиг алдагдлыг өөрийн хөрөнгийн “Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөц”-д бүртгэдэг. Хөрөнгө оруулалтыг борлуулахад, өмнө хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан ашиг эсвэл алдагдлыг орлого, үр дүнгийн тайланд “Бусад үйл ажиллагааны орлого” эсвэл “Бусад үйл ажиллагааны зардал”-аар хүлээн зөвшөөрнө. Банк нь нэг төрлийн үнэт цаасанд нэгээс илүү удаа хөрөнгө оруулсан бол тэдгээрийг “эхэлж авснаа эхэлж зарлагадах” зарчмыг баримтлан борлуулсан гэж үзнэ. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон хүүг үр ашигт хүүний аргаар тооцон, хүүгийн орлого гэж тайлагнадаг. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон ногдол ашгийг төлбөрийн эрх нь тогтоогдсон үед орлого, үр дүнгийн тайлангийн “Үйл ажиллагааны бусад орлого”-д хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлого, үр дүнгийн тайлангийн “Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал”-д хүлээн зөвшөөрч, борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөцөөс хасч өгнө.

(x) Төв Банкны үнэт цаас ба гадаад өр төлбөр

Гэрээт зохицуулалтын агуулга нь өөрийн тодорхой тооны хувьцааны оронд бэлэн мөнгө эсвэл өөр ямар нэг санхүүгийн хөрөнгийг өгөх үүргийг Банкинд үүсгэж байгаа үед, Банкнаас гаргасан бөгөөд “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” гэж ангилагдаагүй санхүүгийн хэрэглүүрүүд эсвэл тэдгээрийн бүрдэл хэсгүүдийг “Төв банкны үнэт цаас ба гадаад өр төлбөр” гэсэн нэрээр өр төлбөрийн хэсэгт ангилна. Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементийг агуулсан нийлмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бүрэлдэхүүн хэсгүүдийг салгаж тус тусад нь бүртгэх бөгөөд өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгийн дүн нь нийт дүнгээс өр төлбөрийн хэсгийн бодит үнэ (уг өр төлбөр үүссэн өдрийн бодит үнэ)-ийг хассан дүн байна.

Анх хүлээн зөвшөөрсний дараа, Төв Банкны үнэт цаас ба гадаад өр төлбөрийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо эдгээрийг гаргах эсвэл үүсгэх үеийн хөнгөлөлт эсвэл урамшуулал, үр ашигт хүүг бүрдүүлж буй зардлуудыг авч үзнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(ё) Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

(i) Санхүүгийн хөрөнгө

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн нэг хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийг) үл хүлээн зөвшөөрнө:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан; эсвэл
- Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн бол
- Банк хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн эсвэл Банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг их хэмжээгээр шилжүүлээгүй мөн авч үлдээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг болон хяналтыг шилжүүлээгүй мөн авч үлдээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

Шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой үргэлжилсэн оролцоо нь борлуулсан ба/эсвэл худалдан авсан опцион (үүнд бэлэн мөнгөөр төлбөр хийгддэг опцион эсвэл ижил төрлийн хэлэлцээр багтсан) хэлбэртэй байвал тус оролцооны дүн нь Банкны буцаан худалдан авч болзошгүй шилжүүлсэн хөрөнгийн дүн юм. Гэсэн хэдий ч, бодит үнэ цэнээр хэмжигддэг хөрөнгийг худалдах опционтой үед Банкны үргэлжлүүлэн оролцоор байх хэмжээ нь шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон опцион хэрэгжих үнийн аль багаар нь хязгаарлагдана.

(ii) Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо оршин байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр орлуулсан эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийн дагуу өмнөх санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх ба шинэ өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, тус тусынх нь дансны үнийн зөрүүг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(ж) Бодит үнэ цэнийн тодорхойлолт

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагдаж буй санхүүгийн хэрэглүүрүүдийн тайлан тэнцлийн өдрийн бодит үнэ нь аливаа гүйлгээний зардлыг хасаагүй биржийн ханш болон диллерийн үнэ (урт позицийн хувьд авах үнэ, богино позицийн хувьд зарах үнэ) дээр үндэслэнэ. Идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд бодит үнийг нь тохиромжтой үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлно. Эдгээр аргуудад цэвэр өнөөгийн үнэ цэнийн арга, ажиглаж болохуйц зах зээлийн үнэтэй, төсөөтэй өөр бусад санхүүгийн хэрэглүүрүүдтэй харьцуулах арга, опционы үнэлгээний загвар, холбогдох бусад үнэлгээний загварууд багтана.

(з) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Банк нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг тайлан тэнцлийн өдөр бүр үнэлж үзнэ. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны “Алдагдлын тохиолдол”-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг “Алдагдлын тохиолдол” нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн бодитойгоор тооцоолох боломжтой ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ. Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтанд орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

(и) *Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба олгосон зээл, урьдчилгаа*

Хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг, бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба олгосон зээл, урьдчилгааны дүнгүүдийн хувьд Банк нь эхлээд дангаараа чухал ач холбогдолтой санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн (тусгайлан), дараа нь чухал ач холбогдолгүй санхүүгийн хөрөнгүүдийг нийлүүлэн (бүлгээр нь) үнэлнэ. Хэрэв Банк нь нэг бүрчлэн үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгийн үнэлгээний хувьд (чухал ач холбогдолтой, холбогдолгүй эсэхийг үл харгалзан) үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй гэж үзвэл ойролцоо зээлийн эрсдлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулан үнэ цэнийн бууралтыг нь нэгдсэн байдлаар үнэлдэг. Үнэ цэнийн бууралтын нэг бүрчилсэн үнэлгээ хийгдсэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үргэлжилж буй хөрөнгийг бүлгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд оруулахгүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(з) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

(i) *Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба олгосон зээл, урьдчилгаа (үргэлжлэл)*

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн (бодитоор тохиолдоогүй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Хүүний орлогыг хөрөнгийн анхны, үр ашигт хүүний хувиар бууруулсан хөрөнгийн бүртгэлийн дүнгээс үргэлжлүүлэн тооцно. Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй ба барьцаа хөрөнгө нь бүрэн ашиглагдсан эсвэл банкинд бүрэн шилжсэн үед зээлийг холбогдох зээлийн эрсдлийн сангийн хамт данснаас хасна. Хэрэв дараагийн жил нь үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсөх эсвэл буурвал эрсдэлийн санг тохируулах замаар үнэ цэнийн бууралтын алдагдалыг өсгөж эсвэл бууруулж болно. Хэрэв өмнө данснаас хассан байсан зээл эргэн төлөгдвөл тус төлөлтийг “Зээлийн алдагдлын зардал” дансны кредит талд бичнэ.

Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүний хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүний хувь нь хөвөгч байх нөхцөлд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүний хувьтай тэнцүү байна. Барьцаатай санхүүгийн хөрөнгийн ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоо нь барьцааг хураан авах нь боломжтой эсэхээс үл хамааран тус барьцааг хураан авч, албадан борлуулахад гарах зардлыг хассаны дараах мөнгөн урсгалыг харуулдаг.

Үнэ цэнийн бууралтыг нэгдсэн байдлаар үнэлэхийн тулд санхүүгийн хөрөнгийн төрөл, хамаарах салбар, газарзүйн байрлал, барьцаа хөрөнгийн төрөл, хугацаа хэтрэлтийн байдал болон бусад гол хүчин зүйлс зэрэг зээлийн эрсдлийн шинж чанарыг агуулсан банкны дотоод зээллэгийн ангиллын системд үндэслэн тэдгээрийг бүлэглэнэ.

Үнэ цэнийн бууралтын бүлгийн үнэлгээнд хамрагдсан бүлэг санхүүгийн хөрөнгийн ирээдүйн мөнгөн урсгалыг ойролцоолон тооцохдоо бүлэгт багтаж буй хөрөнгүүдийн зээлийн эрсдэлийн шинж чанартай холбоотойгоор гарч байсан түүхэн алдагдалын хувь хэмжээг ашиглана. Өнөө үед үгүй болсон түүхэн нөхцөл байдлын нөлөөг арилгах, түүхэн алдагдлын суурилж буй жилүүдэд хамааралгүй өнөөгийн нөхцөл байдлын нөлөөг харуулах үүднээс түүхэн алдагдлын мэдээнд өнөө үед ажиглагдахуйц өгөгдлүүдэд үндэслэн тохиргоо хийнэ. Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өөрчлөлтийн тооцоолол нь жил жилийн ажиглаж болохуйц холбогдох өгөгдлүүдийн өөрчлөлтүүдийг тусгасан. (Үүнд: ажилгүйдлийн түвшин, эд хөрөнгийн үнэ, өргөн хэрэглээний барааны үнэ, төлбөрийн чадавхи, алдагдлыг илэрхийлэх хүчин зүйлс бүлгээр болон ач холбогдлоор нь). Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг тооцоолоход ашигласан аргачлал, таамаглалуудыг тооцоолсон алдагдал, бодитоор хүлээсэн алдагдлын хоорондын зөрүүг багасгах зорилгоор тогтмол хянана.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(3) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

(ii) *Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт*

Банк нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт нэг бүр дээр үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг үнэлж үзнэ. Үнэ цэнэ бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба тооцоолсон ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хоёрын зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүнг бууруулж, алдагдалын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

Хэрэв дараагийн тайлант жилд тооцоолж байсан үнэ цэнийн бууралтын алдагдлын хэмжээ нь уг үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдлын улмаас буурвал өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдлыг “Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал” дансны кредитэд бүртгэнэ.

(iii) *Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт*

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын хувьд, Банк нь хөрөнгө оруулалт эсвэл бүлэг хөрөнгө оруулалт нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг тайлан тэнцлийн өдөр бүр үнэлж үзнэ.

“Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоонд бодит үнэ цэнэ нь тус хэрэглүүрийн өртгөөс их хэмжээгээр эсвэл тогтмол буурч байх явдал ордог. Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа тохиолдолд хуримтлагдсан алдагдал (худалдан авалт ба өнөөгийн бодит үнэ цэнэ хоёрын зөрүүнээс орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн байсан тухайн хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжигдэх)-ыг өөрийн хөрөнгөөс хасч орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ бууралтын алдагдлын буцаалтыг орлогын тайлангаар дамжуулдаггүй, үнэ цэнийн бууралтын дараах бодит үнийн өсөлтийг өөрийн хөрөнгөд тусгана.

“Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан өөрийн хөрөнгийн хэрэгслийн хувьд түүний үнэ цэнийн бууралтыг хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдтэй адил шалгуур үзүүлэлтүүд дээр суурилан үнэлнэ. Зээлийн бууруулсан бүртгэлийн дүнгээс анхны үр ашигт хүүний хувь хэмжээгээр тооцон, хүүг үргэлжлүүлэн хуримтлуулах ба “Хүүний ба түүнтэй адилтгах орлого”-ын нэг хэсэг болгон бүртгэнэ. Хэрэв дараагийн тайлант жилд өөрийн хэрэгслийн бодит үнэ цэнэ нь өссөн ба уг өсөлт нь үнэ цэнэ бууралтын алдагдлыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдалтай уялдаатай болох нь тогтоодсон бол, үнэ цэнэ бууралтын алдагдлыг орлогын тайлангаар дамжуулан буцаана.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(з) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

(iv) Зээлийн шинэчилсэн гэрээ

Банк нь барьцаа хөрөнгийг хурааж өөрийн болгохоос илүүтэйгээр аль болох гэрээг шинэчлэн байгуулах боломжийг хайж байдаг. Үүнд зээлийн эргэн төлөлтийн хуваарийг сунгах, зээлийн шинэ нөхцлийг санал болгох зэрэг ойлголтыг хамруулж болох юм. Зээлийн гэрээг нэгэнт шинэчлэн байгуулсан бол зээлийг хугацаа хэтэрсэн гэж үзэхгүй. Гэрээнд заасан зээлийн шалгуур нөхцөлүүд биелж буй эсэх, ирээдүйн зээл төлөлт хийгдэх баталгаа байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс зээлийн шинэчилсэн гэрээнд удирдлагын зүгээс байнгын хяналт тавин ажилладаг. Эдгээр зээл нь зээлийн анхны үр ашигт хүүний хувиар тооцоологддог нэг бүрчилсэн болон нийлмэл үнэ цэнийн бууралтын үнэлгээнд хамрагдсаар байх юм.

(и) Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Хэрэв байгууллага нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр тайлан тэнцэлд толилуулах эрхтэй. Мастер цэвэршүүлэлт гэрээнүүдийн хувьд энэ нь хэрэгждэггүй ба холбогдох хөрөнгө болон өр төлбөрийг нийт дүнгээр нь тайлан тэнцэлд тус тусад нь толилуулдаг.

(й) Үндсэн хөрөнгө

Бүх үндсэн хөрөнгийг өртгөөр нь анх бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаанд гарсан зардлыг тухайн зардалтай холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг Банк хүртэх магадлалтай ба өртгийг нь найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд л хөрөнгийн бүртгэлийн дүнд нэмж эсвэл тусдаа хөрөнгө болгох хоёрын аль таарамжтай гэж үзсэнээр нь хүлээн зөвшөөрдөг. Аливаа сольсон хэсгийн бүртгэлийн дүнг үл хүлээн зөвшөөрнө. Бүх урсгал засварыг тэдгээрийн гарсан тайлангийн хугацаанд орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

Хүлээн зөвшөөрсний дараах үед барилга байшинг дахин үнэлсэн дүн (дахин үнэлгээний өдрийн бодит үнээс хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүн)-гээр илэрхийлдэг. Бодит үнийг мэргэжлийн үнэлгээчийн хийсэн үнэлгээгээр гаргаж ирсэн зах зээлд суурилсан нотолгоогоор тодорхойлно. Дахин үнэлэгдсэн хөрөнгүүдийн бодит үнэ цэнийг тэдгээр хөрөнгүүдийн бүртгэлийн дүнгээс их зөрүүтэй байлгахгүй байх үүднээс таван жил тутамд нэг удаа үндсэн хөрөнгүүдийг дахин үнэлнэ. Дахин үнэлгээний аливаа нэмэгдлийг өөрийн хөрөнгө доторх дахин үнэлгээний санд бүртгэнэ. Дахин үнэлгээний аливаа нэг нэмэгдлээс эхлээд тухайн хөрөнгө дээр өмнө нь үүсч, орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний бууралтыг буцааж (энэ тохиолдолд өсөлтийг өмнө хүлээн зөвшөөрсөн бууралтын хэмжээгээр орлого, үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрнө), үлдэх дүнг өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний санд нэмж бүртгэнэ. Дахин үнэлгээний бууралтыг эхлээд тухайн хөрөнгө дээр өмнө нь хүлээн зөвшөөрсөн, хэрэглэгдээгүй дахин үнэлгээний нэмэгдлээс суутгах бөгөөд үүний дараа үлдэх дүнг орлого үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийг борлуулах эсвэл данснаас хасах үед тодорхой нэг хөрөнгөтэй холбоотой аливаа нэг дахин үнэлгээний санг хуримтлагдсан ашигт шууд шилжүүлнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(й) Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Хүлээн зөвшөөрсний дараах үед барилга байшингаас бусад үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг.

Дуусаагүй барилгад элэгдэл байгуулдаггүй. Үндсэн хөрөнгийн элэгдлийг үндсэн хөрөнгийн төрөл бүрээр, дараах ашиглалтын жилийг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулдаг. Үүнд:

Áàðëëàà, ààéøèí	25 - 60 æë
Òààðëëàà, òííà ò°ò°ò°íæ	8 - 10 æë
Èííüðààð	5 - 8 æë
Òýýàðëéí òýðýãñý	6 - 8 æë

Үндсэн хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл тэдгээрийн ашиглалтаас ирээдүйд эдийн засгийн үр өгөөж орж ирэхгүй гэж үзсэн үед бүртгэлээс хасна. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр дүн хоёрын зөрүүг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг ба тухайн хөрөнгийн дахин үнэлгээний хэрэглэгдээгүй хэсгийг хуримтлагдсан ашиг уруу шууд хуваарилна.

(к) Орлогын албан татвар

Монгол Улсын “Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хууль”-д заасны дагуу Банк нь орлогын албан татвараас чөлөөлөгддөг.

(л) Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Банк тайлант хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийж гүйцэтгэх шаардлагатай үед Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцож үздэг. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнэ (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын өртөг хоёрын аль өндөр нь байна. Хөрөнгийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүнгээр нь бууруулан бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(л) Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Тайлан тэнцлийн өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээг хийдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл нөхөн төлөгдөх дүнг ойролцоолон тооцож үзнэ. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Хэрэв тийм бол хөрөнгийн бүртгэлийн дүнг цуглуулан авах дүн хүртэл нь өсгөж бүртгэнэ. Энэ өссөн дүн нь хэрэв өмнөх жилүүдэд хөрөнгөд үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүнгээс (элэгдлийг хассан цэвэр дүнгээс) хэтрэхгүй байна. Ийм буцаалтуудыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Ийм буцаалтыг хийсний дараа, хөрөнгийн шинэ бүртгэлийн дүн (үлдэгдэл өртгийг хассан дүн)-г түүний ашиглалтын хугацаанд системтэйгээр хуваарилах үүднээс элэгдлийн зардалд залруулга хийнэ.

(м) Буцаан худалдан авах, урвуу буцаан худалдан авах хэлцлүүд

Ирээдүйд тодорхой заасан хугацаанд буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл ('репо')-ийн дор худалдсан үнэт цааснуудыг тайлан тэнцлээс үл хүлээн зөвшөөрдөггүй. Хүлээн авсан холбогдох бэлэн мөнгөө хуримтлуулсан хүүний хамт тайлан тэнцэлд 'Зээлдүүлсэн үнэт цаас ба буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа' гэж тусгагдах ба энэ нь Банкинд олгосон зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлдэг байна. Борлуулсан ба ирээдүйд буцаан худалдан авах үнийн зөрүүг хүүний зардал гэж үзэж үр ашигт хүүний аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна. Харин хөрөнгө хүлээн авагч нь тус хөрөнгийг борлуулах эсвэл барьцаанд тавих эрхтэй үед тус хөрөнгийг 'Барьцаанд тавьсан арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө' гэж тайлан тэнцэлд бүртгэнэ.

Харин буцаан худалдах хэлцэл ('урвуу репо')-ийн дор худалдан авсан үнэт цааснуудыг тайлан тэнцэлд хүлээн зөвшөөрдөггүй. Төлсөн мөнгө хуримтлуулсан хүүгийн хамт тайлан тэнцэлд 'Зээлсэн үнэт цаас ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа' гэж тусгагдана. Худалдан авсан ба буцаан худалдах үнийн зөрүүг хүүгийн орлого гэж үзэж үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(н) Санхүүгийн баталгаа

Банк бизнесийн хэвийн нөхцөлд голдуу тендерийн баталгаа болон аккредитивээс бүрдэх санхүүгийн баталгаануудыг гаргадаг. Санхүүгийн баталгааг санхүүгийн тайланд анхлан бүртгэхдээ бодит үнээр нь буюу хүлээн авсан урамшууллын дүнгээр “Бусад өр төлбөр”-т хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү анхлан хүлээн зөвшөөрсний дараа, баталгаа бүрт Банкны хүлээх хариуцлагыг хорогдуулсан урамшуулал ба уг баталгааны улмаас үүсэх аливаа нэг санхүүгийн үүргийг биелүүлэхэд шаардлагатай зардлын хамгийн сайн тооцоолсон дүн хоёрын аль ихээр нь хэмжинэ.

Санхүүгийн баталгааны холбогдох өр төлбөрийн аливаа өсөлтийг орлого, үр дүнгийн тайлангийн “Үнэ цэнийн бууралтын алдагдал” дансанд бүртгэнэ. Хүлээн авсан урамшууллыг санхүүгийн баталгааны хүчинтэй байх хугацааны туршид нь шулуун шугамын аргаар тооцож орлого, үр дүнгийн тайлангийн “Үйл ажиллагааны бусад орлого” дансанд хүлээн зөвшөөрнө.

(о) Ажиллагсдын тэтгэмж

(i) *Богино хугацаат тэтгэмж*

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана.

(ii) *Заавал төлөх даатгалын шимтгэлүүд*

Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол Улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь орлого, үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ҮНЭЛЭЛТ БА ТООЦООЛЛУУД

Банк нягтлан бодох бүртгэлийн бодлогуудаа мөрдөхийн явцад санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдийг тодорхойлохдоо өөрийн үнэлэлт болон тооцооллуудыг ашигласан. Ашигласан хамгийн томоохон үнэлэлт болон тооцооллуудыг дор харуулав. Үүнд:

Зээл ба урьдчилгааны болзошгүй алдагдлын сан

Банк нь үнэ цэнийн бууралтын алдагдлын санг орлого, үр дүнгийн тайланд бүртгэх шаардлагатай эсэхийг үнэлэх үүднээс тайлагналын өдөр бүр асуудалтай зээл, урьдчилгаануудыг хянаж үздэг. Тухайлбал, шаардлагатай сангийн түвшинг тодорхойлох үед ирээдүйн мөнгөн урсгалын дүн, хугацааг ойролцоолон тооцоолоход удирдлагын үнэлэмж шаардагддаг. Ийм тооцоолол нь олон тооны хүчин зүйлүүдийн талаарх таамаглалууд дээр үндэслэдэг ба бодит үр дүнгээс өөр байж болох бөгөөд энэ нь ирээдүйд сангийн хэмжээнд өөрчлөлт оруулахад хүргэж болно.

3. ХҮҮНИЙ ОРЛОГО

	2007 сая төгрөг	2006 сая төгрөг
Санхүүгийн хөрөнгө оруулалт -Боруулахад бэлэн	6,485	322
Урвуу буцаан худалдан авах хэлцлүүд	9,361	2,522
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	31,995	14,876
Сангийн яам, дотоодын банкуудад олгосон зээл	573	1,059
	48,414	18,779

4. ХҮҮНИЙ ЗАРДАЛ

	2007 сая төгрөг	2006 сая төгрөг
Гаргасан үнэт цаас	7,900	4,359
Гадаад өр төлбөр	565	217
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	7,990	2,948
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	2,057	548
Буцаан худалдан авах гэрээнүүд	383	-
	18,895	8,072

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. АЛТ, ҮНЭТ МЕТАЛЛЫН АРИЛЖААНЫ ЦЭВЭР АШИГ

	2007 сая төгрөг	2006 сая төгрөг
Алтны арилжааны ашиг	726	3,021
Үнэт металлын дахин үнэлгээний бодит бус ашиг	-	(505)
Алтны дахин үнэлгээний бодит бус ашиг/(алдагдал)	27,757	(87)
Алтны дахин үнэлгээний бодит ашиг	1,485	-
Үнэт металл цэвэршүүлэлтээс олсон валютын ханшийн бодит ашиг	-	54
Бусад үнэт металлын арилжааны цэвэр ашиг	8	217
Тээвэрлэлт ба цэвэршүүлэлтийн зардал	(145)	(391)
	29,831	2,309

6. ВАЛЮТЫН ХАНШИЙН ЗӨРҮҮНИЙ ЦЭВЭР АШИГ/ (АЛДАГДАЛ)

	2007 сая төгрөг	2006 сая төгрөг
Валютын арилжааны цэвэр бодит ашиг	7,761	1,004
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг/(алдагдал)	19,198	(8,491)
	26,959	(7,487)

7. ҮНЭ ЦЭНЭ БУУРАЛТЫН АЛДАГДАЛЫН ЗАРДАЛ

	2007 сая төгрөг	2006 сая төгрөг
Бусад хөрөнгө (Тодруулга 19)	39,329	-
Бусад	122	-
	39,451	-

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

8. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	2007 сая төгрөг	2006 сая төгрөг
Зар сурталчилгаа	45	443
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 18)	857	877
Боловсон хүчний зардал (Тодруулга 9)	1,469	1,280
Хуулийн ба мэргэжлийн үйлчилгээний хөлс	550	-
Данснаас хассан үндсэн хөрөнгө	17	17
Гадаад улсууд дахь төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны зардал	92	87
Харуул хамгаалалт	252	197
Харилцаа холбоо	540	451
Тээвэр, албан томилолт	286	234
Сургалт	86	88
Ашиглалтын зардал	229	235
Гишүүнчлэлийн ба мэргэжлийн үйлчилгээний хөлс	150	141
Үйл ажиллагааны бусад зардал	317	617
	<u>4,890</u>	<u>4,667</u>

9. БОЛОВСОН ХҮЧНИЙ ЗАРДАЛ

	2007 сая төгрөг	2006 сая төгрөг
Цалин, хөлс	1,145	999
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	324	281
	<u>1,469</u>	<u>1,280</u>

10. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ЗАРДЛУУД

	2007 сая төгрөг	2006 сая төгрөг
Мөнгөн тэмдэгтийн зардал	6,590	5,080
Алт хадгалуулсны зардал	442	15
Гаргасан, баримтуудтай аккредитивийн өглөгийн сангийн зардал	27,889	-
Азийн Хөгжлийн Банкны МОН-1510 дугаарт зээлийн гэрээний үүргийн зардал	1,439	-
Бусад зардлууд	359	104
	<u>36,719</u>	<u>5,199</u>

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

11. АЛТ, ҮНЭТ МЕТАЛЛ

	2007 сая төгрөг	2006 сая төгрөг
Үнэлгээгээр		
Мөнгөжсөн алт	232,665	156,851
Мөнгөжсөн мөнгө	-	120
Өртгөөр		
Мөнгөжөөгүй алт, мөнгө	129,900	8,051
Зоос, түүх соёлын үнэт зүйлс	2,730	2,848
	<u>365,295</u>	<u>167,870</u>

12. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ, ХАДГАЛАМЖ

	2007 сая төгрөг	2006 сая төгрөг
Богино хугацаат хадгаламж	698,335	502,227
Зээлжих тусгай эрх	90,764	89,612
Харилцах данс	41,225	20,032
Дэлхийн банкинд оруулсан хувь, хөрөнгө	865	985
Бусад хувь, хөрөнгө	3	3
	<u>831,192</u>	<u>612,859</u>

Богино хугацаат хадгаламж

